

УЛААНБААТАР ХОТЫН ЯДУУРАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

Хүн амын сургалт, судалгааны төв

Улаанбаатар хот, 2004

ТАЛАРХЛЫН ҮГ

Монголд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нэмэгдсээр байна. Энэ хандлага Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшин, төлөв байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилгоор “Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгааг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны захиалга, НҮБХХ-ийн санхүүжилтээр МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Хүн Амын Сургалт Судалгааны Төв (ХАССТ)-ийн судлаачид хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд баримтын судалгаа, чанарын судалгаа, тоон судалгаа хийсний үндсэн дээр гаргаж буй тайлан илтгэлийг Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Судалгааг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБХХ, мэргэжлийн үнэтэй санал зөвлөмж өгсөн олон улсын зөвлөх Алисиа Менендес, Нилс Рименсчнайдер, Ядуурлын судалгааны нэгжийн зөвлөх Ричард Маршалл, Үндэсний статистикийн газрын ахлах мэргэжилтэн Ю.Туул, төслийн хүрээнд хамтран ажилласан суурин төлөөлөгчийн газрын ажилтан Хелене Лиллеор, Мартина Никодемова, Г.Уянга нарт болон үр дүнгийн тайлангийн Англи орчуулгыг хянан тохиолдуулсан НҮБ-ийн сайн дурын байгууллагын ажилтан Абигэйл Вилмерт ХАССТ-ийн хамт олны өмнөөс гүн талархалаа илэрхийлье.

Судалгааны үр дүнгийн тайланд үнэтэй санал, зөвлөмж өгсөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Улаанбаатар хотын захиргааны холбогдох хүмүүст талархал илэрхийлэхийн ялдамд, цаашид хамтран ажиллахад баяртай байх болно.

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгааг амжилттай явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, судалгааг явуулах багт ярилцлага авагчаар оролцсон МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийн оюутнуудад ХАССТ чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

ХАССТ-ийн Захирал

А.Солонго

ОЙЛГОЛТ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Ажил эрхэлж буй хүн ам: Ажил эрхлэлт нь 15 ба түүнээс дээш насны хүн амд хамаарах асуудал бөгөөд дараахь нөхцөлд ажил эрхэлдэг хүн ам гэж үзнэ.

- Судалгааны өмнөх 7 хоногийн турш эсвэл аль нэг өдөр цалин орлоготой ажил эрхэлсэн бүх хүмүүс.
- Судалгааны өмнөх 7 хоногт ажиллаагүй боловч үндсэн байгууллагатайгаа хөдөлмөрийн гэрээ хэлцлээ цуцлаагүй ямар нэг тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох хүмүүс.
- Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг, тухайлбал малчин болон ногоочин өрхийн гишүүд.

Ажил эрхлэлтийн түвшин: Ажил эрхэлж байгаа нийт хүн амыг 15 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно.

Ажил эрхэлдэггүй хүн ам: 15 ба түүнээс дээш настай, ажил эрхэлж байгаагаас бусад бүх хүмүүс ажил эрхэлдэггүй хүн амд хамаарна. Өөрөөр хэлбэл, судалгааны үед ажил идэвхтэй эрж байсан ажилгүйчүүд болон ажиллах хүчинд багтаагүй нийт хүн амыг хамруулан ойлгоно.

Ажилгүйчүүд: Судалгаа авах үед ажил эрхлээгүй байсан боловч ажил олохоор идэвхтэй хайж байсан нийт хүн амыг ажилгүйчүүд гэсэн ангилалд оруулав.

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно.

Ажиллах хүчин/Эдийн засгийн идэвхитэй хүн ам: Ажиллагсад болон ажилгүйчүүдийн нийлбэрийг хамруулан ойлгоно.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчин буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг 15 ба түүнээс дээш насны нийт хүн амд харьцуулан харьцаа юм.

Албан сектор: Улсын болон хувийн өмчид суурилан харьцангуй тогтвортой үйл ажиллагаагаа явуулдаг, улсын бүртгэлд хамрагдсан, ажлын нөхцөл, ажиллагсдын нийгмийн хангамж, хамгаалал харьцангуй сайтай сектор. Үүнд, бүх төрлийн улсын болон хувийн байгууллагууд, мөн төрийн бус болон олон улсын байгууллагууд багтана.

Албан бус сектор: Ихэнхдээ бүртгэл, татвар, хуулийн зохицуулалтаас гадуур, далд эдийн засгийн чанартай, тогтворгүй, байнгын бус үйл ажиллагаа явуулдаг, ажлын нөхцөл, нийгмийн хангамж, хамгаалал муутай сектор. Энэ секторт ажиллагсад, хувиараа бизнес эрхлэгчид, өөр өрхөд ажилладаг болон тохиолдлын чанартай ажил эрхэлж байгаа хүмүүс багтана.

Амьжиргааны түвшин: Хүн амын эдийн засгийн чадавхийг харуулах үзүүлэлт. Нийт хүн амыг амьжиргааны түвшингээр нь 5 ангилалд хувааж тодорхойлсон.

Байшин: Бүтцийн хувьд нэг өрх амьдрах зориулалттай, нэг болон хэд хэдэн өрөөтэй сууц. Үүнд, сууцны тусдаа байшин, нийтийн сууцны доторх сууц, оюутан, бусад хүмүүс амьдрах нийтийн байр болон бусад сууцнууд орно.

Байшингийн өрөөний тоо: Унтлагын өрөө, амрах өрөө, ажлын өрөө болон бусад өрөөний нийт тоо. Үүнд, гал тогоо, үүдний өрөө, ариун цэврийн өрөө, ханын хувцас зэрэг эд хогшил хадгалахад зориулсан өрөө хамаарахгүй.

Насны голч: Нийт хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг таллан хувааж буй нас. Жишээлбэл, хэрэв судалгаанд хамрагдсан хүн амын насны голч 24 байвал тухайн хүн амын 50 хувь нь 24 хүртэлх настай, үлдсэн 50 хувь 24-өөс дээш настай байна гэсэн үг.

Нийгмийн сүлжээ: Өрх амьжиргаагаа хөтлөхөд нь нөлөөлж буй өрхийн гишүүд болон тэдний төрөл садан, танил, найз нөхдийн хоорондох холбоо, харилцаа.

Нийтийн сууцны байшин: Зориулалтын зураг төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд хоёроос дээш айл суухад зориулан төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшин.

Нийтийн сууцны байшин доторх сууц: Нийтийн сууцны байшин дотор өрх тус бүрт зориулсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, тоноглол төхөөрөмжтэй бусад айлаас тусгаарлагдсан зориулалтын ханатай, нэгдсэн шат, хонгил, эсвэл гудамж хашаа руу шууд гарах хаалгатай нэг айл суухад зориулагдсан сууц.

Орлого: Амьжиргаагаа хангахын тулд төрөл бүрийн эх үүсвэрээс олж буй мөнгөн болон мөнгөн бус орлогууд хамаарна. Үүнд: Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлого, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олох орлого, бусдаас авсан үнэгүй зүйл, мөнгөн тусламж, хүү, түрээсийн орлого зэрэг орлогууд багтана.

Оюутан сурагчдын нийтийн байр: Бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байр (тусгай сургууль, хүүхдийн зуслан).

Өрхийн тэргүүлэгчийн хүүхдийн тоо: Нас хамаарахгүйгээр, судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчийн хувьд хүүхэд гэсэн хамааралтай хүн амын тоо.

Сургууль завсардсан хүн ам: Судалгааны үед боловсролын зэрэг олгох сургуульд суралцаагүй боловч өмнө нь боловсролын тогтолцооны аль нэг түвшинд суралцаж байгаад түвшнээ бүрэн дүүргээгүй 7-18 насны хүн ам.

Сургуульд хамрагдалтын түвшин: Сургуульд суралцаж буй 7-29 насны хүн амын тухай насны бүлгийн нийт хүн амд эзлэх хувь.

Сууц: Судалгааны үед айл, өрх амьдарч байсан, бүтцийн хувьд тусдаа, биеэ даасан орон байр. Сууц нь амьдрах зориулалтгүй байж болно.

Сууцны бус зориулалттай сууц: Анхнаасаа хүн суух зориулалтын бус боловч өрх айл, хүн сууж байгаа сууц. Үүнд албан байгууллагын байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаа, вагончик, орц гэх зэрэг багтана.

Сууцны тусдаа байшин: Орон сууцны зориулалтын зураг төслөөр баригдсан, зориулалтын зураг төсөлгүй боловч иргэд өөрсдөө сууцанд зориулж барьсан нэг буюу

Ойлголт, нэр томъёоны тайлбар

хэд хэдэн өрх суухад зориулан төхөөрөмжлөгдсөн, дэд бүтцийн холбогдох хангамжтай сууц.

Хөдөлмөрийн нас: Хөдөлмөрийн нас гэдэгт Олон Улсын ангиллаар 15 ба түүнээс дээш насыг хамруулан ойлгоно. Ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин зэрэг үзүүлэлт нь бүгд хөдөлмөрийн насны хүн амд хамаарах үзүүлэлтүүд болно

Хүйсийн харьцаа: 100 эмэгтэй хүн ам тутамд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ногдох хүүхэд, өндөр настнуудын тоо. Үүнийг тооцохдоо, 0-14 насны хүн ам болон 65, түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 настай хүн амд харьцуулж 100-аар үржүүлнэ.

Хүрээлэл: Өрхийн гишүүдтэй холбоо, харилцаатай байдаг, өрхийн гишүүдийн дотно танил хүмүүс. Үүнд, өрхийн гишүүдийн төрөл садан, найз нөхөд, төрсөн нутаг усныхан, нэг ангийнхан, нэг оны цэргийнхэн, хамт ажиллаж байсан болон ажиллаж буй хүмүүс гэх мэт танилууд багтаж болно.

Шилжигч: Судалгаа явуулж буй сараас өмнөх дөрвөн жилийн дотор өөр аймаг, улсаас Улаанбаатарт шилжин суурьшсан, 15-64 настай хүн ам

Шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн ам: Судалгаа явуулж буй сараас өмнөх 5, түүнээс дээш жилийн хугацаанд Улаанбаатарт амьдарч буй 15-64 настай хүн ам

Шилжигч өрх: Өрхийн тэргүүн нь судалгаа явуулж буй сараас өмнөх дөрвөн жилийн дотор өөр аймаг, улсаас Улаанбаатарт шилжин суурьшсан өрх

Эдийн засгийн идэвхгүй хүн ам: Хөдөлмөрийн насанд хүрсэн буюу 15 ба түүнээс дээш настай боловч ажиллах хүчинд багтахгүй буюу ажил эрхлэхэд одоогоор бэлэн бус байгаа хүмүүсийг хамруулсан. Үүнд: Оюутнууд, гэрийн ажилтай хүмүүс, бүртгэл, бичиг баримтын зөрчлийн улмаас ажил эрхлээгүй хүмүүс, өндөр насны тэтгэвэрт байгаа хүн ам, ажлаасаа түр цомхотгогдсон ч дахин ажил олохоор эрж хайхгүй байгаа хүн ам багтана.

Ядуурлын шугам/Амьжиргааны доод түвшин: Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлоход хэрэглэгдэж буй ядуу хүн амыг ядуу бус хүн амаас ялгах жишиг үзүүлэлт.

ХУРААНГУЙ

“Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгаанд Улаанбаатар хотын 1500 өрх санамсаргүй түүвэрлэлтээр сонгогдож, гэр хорооллын 4070 хүн ам, байшин хорооллын 2777 хүн ам хамрагдсан болно.

Энэхүү судалгааны гол зорилго нь Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшинг орлого, хэрэглээнд үндэслэн тооцож, ядуурал, шилжих хөдөлгөөний асуудлыг цогц байдлаар судлах явдал байв. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах асуудлуудыг дэвшүүлэн тавьсан юм. Үүнд:

- Амьжиргааны гол эх үүсвэр, өрхийн орлого, хэрэглээний бүтцийг тодорхойлох;
- Нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг тодорхойлох;
- Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг гэр ба байшин хороолол, шилжигч ба шилжигч бус хүн амаар тодорхойлох;
- Улаанбаатарт шилжин ирэгчдийн шалтгаан, бүртгэлгүй иргэдийн нийгмийн үйлчилгээний хүртээмжийг тодорхойлох;
- Ядуурал ба шилжих хөдөлгөөний хоорондын хамаарлыг тодорхойлох;
- Ядуу хүн амын шинж байдал болон нийгмийн эмзэг бүлгийг тодорхойлж, бодлогын зөвлөмж гаргах.

Судалгааны бүлэг тус бүрийн гол үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна.

ӨРХ БА ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ

- Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 59.4 хувь нь гэр хороололд, 40.6 хувь нь байшин хороололд амьдардаг хүмүүс байна.
- Байшин хороололд оршин суугчдын боловсролын түвшин гэр хороололд оршин суугчдын боловсролын түвшингээс дээгүүр байна.
- 15-64 насны нийт хүн амын 14.6 хувь нь шилжих хөдөлгөөнд оролцсон хүн ам байна. Шилжин ирэгчдийн дийлэнх нь буюу 79.5 хувь нь гэр хороололд амьдарч байна.
- Улаанбаатар хотын өрхүүдийн дийлэнх нь 3-5 хүн амьдардаг (63.4 хувь), ба дан гэр бүлээрээ байгаа өрхүүд (83.5 хувь) байна.
- Нийт өрхийн 17.9 хувь нь гэр сууцанд, үлдсэн хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ОРЛОГО

Түлхүүр асуултууд

- Ажил эрхлэлтийн түвшин ямар байна вэ?
- Ажилгүйдлийн түвшин ямар байна вэ? Ажилгүйдэл нь хүн амын бүлгүүдийн дунд ямар байна вэ?
- Өрхийн орлогын гол эх үүсвэрүүд юу вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 42.4 хувь нь ямар нэгэн орлоготой ажил эрхэлж байна.

- Ажилгүйдлийн түвшин 22.9 хувь байна. Гэр хороололд оршин суугчид (29.5 хувь), эмэгтэйчүүд (23.2 хувь) болон шилжин ирэгчдийн (24.6 хувь) хувьд ажилгүйдлийн түвшин өндөр байна.
- Хүн амын боловсролын түвшин дээшлэхийн хэрээр ажил эрхлэлт нэмэгдсэн зүй тогтол ажиглагдаж байна.
- Өрхийн сарын дундаж орлогын бүтцийг авч үзвэл: Нийт орлогын 67.5 хувь нь цалин, 18.2 хувь нь мөнгөн тусламж/бэлэг/түрээс, хүүгийн орлого, 8.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмжээс бүрдэж байна.

БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Түлхүүр асуултууд

- Хэн боловсрол багатай байна вэ?
- Хэн нийгмийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй байна вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Гэр хорооллын эрэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байна.
- 26-35 насны залуучуудын 38.4 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Тэдэнд мэргэжил шаардсан ажил хийх боломж хязгаарлагдмал байна.
- Хотын захын гэр хороололд амьдарч буй шилжин ирсэн өрхүүдийн хүүхдүүдийн 1/3 нь хоёроос илүү километр зайг туулж байж сургуульдаа хүрч байна.
- Хотын ерөнхий боловсролын сургуулиудад анги дүүргэлт өндөр, хотын захын хорооллуудад ерөнхий боловсролын сургууль цөөн байгаа нь сургуулийн ачааллыг ихэсгэж байна.
- Албан бус секторт ажиллагсад, эрэгтэйчүүд болон гэр хороололд оршин суугчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин хангалтгүй байна.
- Гэр хороололд амьдарч буй шилжин ирсэн өрхийн 28 хувь нь өрхийн эмнэлгээс 3 ба түүнээс дээш километр зайд алслагдан суурьшжээ.
- Анхаарал хандуулах бүлгийнхний нийгмийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Гэр хороололд шинээр сургууль, цэцэрлэг барьж байгуулахад хөрөнгө оруулалтыг түлхүү хийх шаардлагатай байна.

МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ БА НИЙГМИЙН КАПИТАЛ

Түлхүүр асуултууд

- Хотын иргэдийн дунд төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, хүртээмж ямар байна вэ?
- Хотын иргэдийн нийгмийн оролцоо ямар байна вэ?
- "Нийгмийн сүлжээ" хүн амын бүлгүүдэд ямар байна вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төр, засгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн талаар өрхүүдийн талаас илүү хувь нь мэдээлэл авсан боловч 1/10 хүрэхгүй хувь нь л төслийн үр шимээс хүртжээ.
- Нийслэлийн өрхүүдийн бараг тал хувь нь нийгмийн оролцооны идэвх сул аж төрж байна.
- Ялангуяа, орлого өндөртэй өрхүүдийн олон нийтийн ажилд оролцох оролцоо хамгийн доогуур байна.
- Амьжиргаагаа дээшлүүлэхэд ард иргэдийн өөрсдийн идэвх, оролцоо хангалтгүй байна. Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад

хамрагдсан өрхүүдийн хувь амьжиргааны түвшингээр онцын ялгаагүй байгаа ч сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан нэн ядуу өрхийн хувь чинээлэг өрхийнхөөс бараг гурав дахин бага байна.

- Өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхэн өрхийн амьжиргаанд тус дэм үзүүлж байна. Гэвч шилжигч, гэр хороололд амьдарч буй, ядуу, нэн ядуу өрхүүдийн амьдралд туслахуйц хүрээллийнхэн харьцангуй хязгаарлагдмал байна.

ЯДУУРАЛ

Түлхүүр асуултууд

- Улаанбаатар хотод ядуурлын түвшин ямар байна вэ?
- Хэн ядуу байна вэ?
- Энэ талаар юу хийх шаардлагатай вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүн амын 33 хувь нь ядуурлын шугамаас (25300 төгрөг) доогуур амьжиргаатай, түүврийн 10 хувь нэн ядуу (өөрөөр хэлбэл зардал нь ядуурлын шугамаас 60 хувиар доогуур) байна.
- Гэр хороололд амьдрагсад болон шилжигчид илүү ядуу байна (харгалзан 45 хувь ба 37 хувь).
- Тэгш бус байдал гэр хороололд амьдрагсдын дунд харьцангуй гайгүй байна. Харин шилжигчдийн хувьд нэлээд ялгаатай байна.
- Залуу насны, бага боловсролтой болон гэрлээгүй хүмүүс илүү ядуу байна. Тэдний дийлэнх гэр хороололд, ялангуяа Баянзүрх дүүрэгт амьдарцгааж байна. Эдгээр хүмүүсийн өрх олон ам бүлтэй, мөн дийлэнх нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.
- Ядуурлыг бууруулах үйл ажиллагааг явуулах зорилтот бүлэг нь ам бүл олон, гэр хорооллын өрхүүд юм. Түүнчлэн, өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас бага боловсролтой өрхүүдэд анхаарах нь зүйтэй.
- Нэн тэргүүнд хийгдэх үйл ажиллагаа нь ахуйн болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах асуудал юм. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн боловч чанарын асуудалд түлхүү анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- Бүртгэлтэй эсэх нь ядууралтай хамааралтай асуудал биш байна. Ядуу хүмүүс ядуу бус хүмүүсийн нэгэн адил бүртгэлтэй байна. Ядуучуудын 90 хувь бүртгэлтэй байв.
- Нийт хүн амын 4.3 хувийг эзэлж буй казак хүн амын 60 хувь ядуу байна. Энэ цаашид судлах шаардлагатай асуудлуудын нэг юм.

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Түлхүүр асуултууд

- Шилжигчид хэн байна вэ?
- Шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаанууд юу байна вэ? Шилжин ирсний дараа амьдралд нь өөрчлөлт гарсан уу?
- Бүртгэл шилжих хөдөлгөөний урсгалд нөлөөлж байна уу?
- Ядуурал ба шилжих хөдөлгөөний хооронд хамаарал байна уу?
- Засгийн газраас нэн тэргүүнд анхаарах ямар асуудлууд байна вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Хот руу шилжин ирэгчид голдуу гэр хороололд амьдарч байгаа ба тэдний дийлэнх нь бүрэн дундаас доош боловсролтой байна.
- Шилжин ирэгчдийн дийлэнх нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, суралцах болон зах зээлд ойртох зорилгоор шилжин иржээ. Шилжин ирсний дараа ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх болон зах зээлд ойртох гэсэн зорилгууд нь биелж байгаа боловч боловсролын байдалд нь ахиц гарсангүй. Эндээс, шилжих хөдөлгөөний зохицуулалтыг улам анхаарах хэрэгтэй байна.
- Шилжин ирэгчдийн ихэнх нь (71 хувь) шилжин ирсэн зорилгоо биелсэн гэж үзэж байна.
- Бүртгэл нь Улаанбаатар руу шилжин ирэх хөдөлгөөнийг багасгахад нөлөөлж чадахгүй байна (шилжигчдийн тал хувь нь бүртгэлгүй байна). Гэвч бүртгэлгүй байдал нь эрүүл мэндийн даатгалгүй шилжигчдийн (1/3) эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа үндсэн шалтгаануудын нэг (эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа шилжигчдийн 1/4 нь бүртгэлгүй гэсэн шалтгаанаар хамрагдаж чадахгүй байна) болж байна.
- Шилжигчид нь шилжих хөдөлгөөнд оролцсон учраас ядуу байгаа биш, тухайлбал, боловсролын түвшин доогуур байгаагаас ядууралд өртөж байна. Шилжигчид шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай адил боломжтой нь харагдаж байгаа бөгөөд тэдний гол бэрхшээл нь мэргэжил, боловсролын байдлаараа шилжигч бус хүн амынхаас бага зэрэг дутмаг байгаа явдал юм.
- Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засгийн байдал болон боловсролын чанарыг сайжруулах асуудал хамгийн чухал байна.

АГУУЛГА

Талархлын үг	i
Хүснэгт, зургийн жагсаалт	iv
Хураангуй	ix
Ойлголт, нэр томъёоны тайлбар	xiii
БҮЛЭГ 1. Удиртгал	1
<i>Алгаагийн Солонго</i>	
1.1. Үндэслэл	1
1.2. Судалгааны зорилго	1
1.3. Илтгэлийн бүтэц	2
БҮЛЭГ 2. Судалгааны арга зүй, аргачлал	3
<i>Алгаагийн Солонго</i>	
2.1. Түүвэрлэлтийн арга	3
2.1.1. Тоон судалгаа	3
2.1.2. Чанарын судалгаа	5
БҮЛЭГ 3. Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал	7
<i>Баатарын Наранчимэг</i>	
3.1. Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал	7
3.1.1. Хүн ам зүйн шинж байдал	7
3.1.2. Нийгэм, эдийн засгийн шинж байдал	9
3.2. Өрхийн шинж байдал	11
3.2.1. Өрхийн тэргүүний шинж байдал	11
3.2.2. Өрхийн хүн ам зүйн шинж байдал	13
3.2.3. Өрхийн ахуйн нөхцөл	14
3.3. Дүгнэлт	20
БҮЛЭГ 4. Ажил эрхлэлт ба орлого	21
<i>Баатаржавын Нарантулга</i>	
4.1. Ажил эрхлэлтийн байдал	21
4.1.1. Ажил эрхлэлтийн талаарх ойлголт тодорхойлолтууд	21
4.1.2. Хүн амын бүлгүүдийн дундах ажил эрхлэлтийн байдал	24
4.2. Албан ба албан бус сектор	27
4.3. Өрхийн орлогын эх үүсвэрүүд	29
4.4. Дүгнэлт	30
БҮЛЭГ 5. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	31
<i>Алгаагийн Солонго</i>	
5.1. Боловсрол	31
5.1.1. Насанд хүрэгсдийн боловсролын түвшин	31
5.1.2. Боловсрол дахь хүйсийн харьцаа	32
5.1.3. Сургууль завсардалт	33
5.1.4. Сургалтын төлбөр, түүний хэлбэр	35
5.1.5. Дунд сургуулийн хүртээмж	36
5.2. Эрүүл мэнд	37
5.2.1. Эрүүл мэндийн байдал	37
5.2.2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт	38
5.2.3. Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ	43
5.2.4. Эрүүл аж төрөх орчин ахуй	43
5.3. Дүгнэлт	44

БҮЛЭГ 6.	Мэдлэг, мэдээлэл ба нийгмийн капитал	46
	<i>Батцэнгэлийн Мөнхжаргал</i>	
6.1.	Нийгмийн оролцоо	46
6.1.1.	Төсөл, хөтөлбөрийн талаарх мэдлээлэл ба хүртээмж	46
6.1.2.	Иргэдийн олон нийтийн оролцоо	50
6.1.3.	Мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал	52
6.2.	Нийгмийн сүлжээ	55
6.3.	Дүгнэлт	60
БҮЛЭГ 7.	Улаанбаатар хотын ядуурал	61
	<i>Нилс Рименсчнайдер, Дашидоржийн Хүрэлмаа, Баатаржавын Нарантулга</i>	
7.1.	Ядуурлын уламжлалт үзүүлэлтүүд	62
7.2.	Ядуурлын шинж байдал	66
7.2.1	Ядуучуудын шинж байдал	67
7.2.2	Үйл ажиллагааны зорилтот бүлгийг тодорхойлох нь	69
7.3	Хэрэглээ ба амжиргааны түвшин	71
7.4	Ядуучуудад чиглэсэн үйл ажиллагаа	77
7.5	Үйл ажиллагааны хамгийн чухал хэсгүүд	81
7.5.1	Хэсгийн дүгнэлт	84
7.6	Ядуурлыг судлах	85
7.6.1	Хүртээмжийн ядуурал	85
7.6.2	Нийгмийн оролцооны ядуурал	88
7.6.3.	Хүртээмж, нийгмийн оролцооны ядуурлын үзүүлэлтүүд ядуурлын стандарт үзүүлэлтүүдтэй хэрхэн холбоотой байна вэ?	91
7.6.4	Хэсгийн дүгнэлт	95
БҮЛЭГ 8.	Шилжих хөдөлгөөн	96
	<i>Төмөртолгойгийн Навч, Дашидоржийн Хүрэлмаа</i>	
8.1.	Шилжигчдийн шинж байдал	96
8.2.	Өрхийн шинж байдал, ахуйн нөхцөл	98
8.3.	Шилжигчдийн боловсрол	102
8.4.	Шилжигчдийн эрүүл мэнд	103
8.5.	Шилжин ирсэн шалтгаан	105
8.6.	Оршин сууж буй газрын бүртгэл	109
8.7.	Ирээдүйн шилжилт	110
8.8	Шилжих хөдөлгөөн ба ядуурал	111
8.9	Дүгнэлт	114
Бодлогын зөвлөмж		116
Хавсралт 1:	Ашигласан ном зүй	117
Хавсралт 2:	Асуулгын хуудас	118
Хавсралт 3:	Судалгаанд оролцогсад	132

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгтийн жагсаалт:

<i>Хүснэгт 2.1.</i>	Ядуурлын түвшин байршлаар	3
<i>Хүснэгт 2.2.</i>	Түүвэрлэлтийн хүрээ	4
<i>Хүснэгт 3.1.</i>	Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, хүн ам зүйн үзүүлэлтүүд, байршлаар	9
<i>Хүснэгт 3.2.</i>	Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, байршлаар	10
<i>Хүснэгт 3.3.</i>	Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүний хүн ам зүйн шинж байдал, байршлаар	11
<i>Хүснэгт 3.4.</i>	Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүний нийгэм, эдийн засгийн шинж байдал, байршлаар	13
<i>Хүснэгт 3.5.</i>	Өрхийн хувийн жин, өрхийн хүн ам зүйн шинж байдал, байршлаар	14
<i>Хүснэгт 3.6.</i>	Өрхийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, байршлаар	15
<i>Хүснэгт 3.7.</i>	Өрхийн хувийн жин, өрхийн ахуйн нөхцөл, байршлаар	16
<i>Хүснэгт 3.8.</i>	Гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, гэр сууцны нөхцлөөр	19
<i>Хүснэгт 4.1.</i>	Ажиллах хүчний үзүүлэлтүүд, хариулагчдын шинж байдлаар	23
<i>Хүснэгт 4.2.</i>	Арван тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, ажил эрхлэлт, хүн ам зүйн шинж байдлаар	25
<i>Хүснэгт 4.3.</i>	Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүлэгчдийн ажил эрхлэлт, өрхийн шинж байдлаар	26
<i>Хүснэгт 4.4.</i>	Ажил эрхэлж буй хүн амын хувийн жин, ажиллаж буй сектор, сонгосон үзүүлэлтүүдээр	27
<i>Хүснэгт 4.5.</i>	Ажил эрхэлж буй хүн амын хувийн жин, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, ажиллаж буй сектороор	28
<i>Хүснэгт 4.6.</i>	Ажил эрхэлдэг хүн амын сарын дундаж цалин/орлогын түвшин, ажиллаж буй сектороор	28
<i>Хүснэгт 4.7.</i>	Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, хувиар, сонгосон үзүүлэлтүүдээр	29
<i>Хүснэгт 5.1.</i>	Насанд хүрэгсдийн боловсролын түвшин, насны бүлгээр	32
<i>Хүснэгт 5.2.</i>	Долоогоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалтын түвшин, байршил, хүйс, насны бүлгээр	33
<i>Хүснэгт 5.3.</i>	Долоогоос хорин есөн насны хүн амын хувийн жин, сургуульд суралцаж буй хугацаандаа амьдардаг газар, байршлаар	34
<i>Хүснэгт 5.4.</i>	Сургуульд суралцаж буй хүн амын хувийн жин, сургалтандаа төлбөр төлдөг эсэх, байршлаар	35
<i>Хүснэгт 5.5.</i>	Эрүүл мэндийн байдал, амьжиргааны түвшингээр	39
<i>Хүснэгт 5.6.</i>	Эрүүл мэндийн даатгалгүй хүн амын шинж байдал, байршлаар	40
<i>Хүснэгт 5.7.</i>	Хүн амын хувийн жин, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжтой эсэх, амьжиргааны түвшингээр	42
<i>Хүснэгт 6.1.</i>	Өрхүүдийн хувь, хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий хөтөлбөр, төслүүдийн талаар мэдээлэл авсан байдал, сонгосон үзүүлэлтүүдээр	47
<i>Хүснэгт 6.2.</i>	Өрхүүдийн хувь, хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий хөтөлбөр, төслүүдийн үр шимээс хүртсэн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр	49
<i>Хүснэгт 6.3.</i>	Өрхүүдийн хувийн жин, дүүрэг/хорооноос зохион байгуулдаг олон	

	нийтийн ажилд оролцдог эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	51
<i>Хүснэгт 6.4.</i>	Өрхүүдийн хувийн жин, өрхөөс мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалт, дамжаанд хамрагдсан хүн байгаа эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	52
<i>Хүснэгт 6.5.</i>	Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтанд хамрагдсан гишүүнтэй өрхүүдийн хувийн жин, сургалт, дамжаанд хамрагдсанаар амьиргаагаа дээшлүүлж чадсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	53
<i>Хүснэгт 6.6.</i>	Өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох танилтай өрхүүдийн хувь, танилуудын ажил, мэргэжил, сонгосон үзүүлэлтүүдээр	55
<i>Хүснэгт 6.7.</i>	Өрхүүдийн хувийн жин, өдөр тутмын амьдралдаа дотно/танил хүрээллийнхнээс дэмжлэг авдаг эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр	56
<i>Хүснэгт 6.8.</i>	Өдөр тутмын амьдралд өрхийн гишүүдийн дотно/танил хүрээллийнхнээсээ дэмжлэг авдаг өрхүүдийн хувь, дэмжлэг үзүүлдэг хүрээлэл, сонгосон үзүүлэлтүүдээр	59
<i>Хүснэгт 7.1.</i>	Хүн амын хувийн жин, ядуурлын үзүүлэлтүүд, байршил, шилжилтийн байдлаар	63
<i>Хүснэгт 7.2.</i>	Тэгш бус байдлын хэмжүүр	65
<i>Хүснэгт 7.3.</i>	Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, хэрэглээний зардлын ядуурал, сонгосон үзүүлэлтээр	67
<i>Хүснэгт 7.4.</i>	Хүн амын хувийн жин, амьжиргааны түвшингээр	71
<i>Хүснэгт 7.5.</i>	Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтүүдээр	72
<i>Хүснэгт 7.6.</i>	Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, өрхийн шинж байдлаар	73
<i>Хүснэгт 7.7.</i>	Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, дүүргээр	74
<i>Хүснэгт 7.8.</i>	Арван тав ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтүүдээр	75
<i>Хүснэгт 7.9.</i>	Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтүүдээр	77
<i>Хүснэгт 7.10</i>	Хүн амын хувийн жин, хүртээмжийн ядуурал, сонгосон үзүүлэлтээр	86
<i>Хүснэгт 7.11</i>	Хүн амын хувийн жин, нийгмийн оролцооны ядуурал, сонгосон үзүүлэлтээр	89
<i>Хүснэгт 7.12</i>	Хүн амын хувийн жин, хүртээмжийн ядуурал, сонгосон үзүүлэлтээр	92
<i>Хүснэгт 8.1.</i>	Судалгаанд хамрагдсан 15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал, хүн ам зүйн шинж байдлаар	98
<i>Хүснэгт 8.2.</i>	Судалгаанд хамрагдсан 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, байршил, шилжилтийн байдал, архийн шинж байдлаар	99
<i>Хүснэгт 8.3.</i>	Судалгаанд хамрагдсан 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, шилжилтийн байдал, өрхийн сууцны үзүүлэлтүүдээр	99
<i>Хүснэгт 8.4.</i>	15-64 насны тэргүүнтэй, гэрт амидардаг өрхийн хувийн жин, шилжилтийн байдал, сууцны нөхцөлөөр	100
<i>Хүснэгт 8.5.</i>	15-64 насны тэргүүнтэй, гэрт амидардаг өрхүүдийн хувийн жин, шилжилтийн байдал, ахуйн нөхцөлөөр	101
<i>Хүснэгт 8.6.</i>	15-64 насны хүн амын хувийн жин, тухайн өрхөд бүртгэлтэй эсэх, байршил, шилжилтийн байдлаар	101
<i>Хүснэгт 8.7.</i>	15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал,	

	сонгосон үзүүлэлтүүдээр	102
Хүснэгт 8.8.	15-64 насны хүн амын хувийн жин, эрүүл мэндийн байдал, байршил, шилжилтийн байдлаар	104
Хүснэгт 8.9.	15-64 насны, эрүүл мэндийн даатгалгүй хүн амын хувийн жин, даатгалд хамрагдаагүй шалтгаан байршил, шилжилтийн байдлаар	104
Хүснэгт 8.10.	Шилжин ирэгчийн хувийн жин, шилжин ирэхээс өмнө амьдарч байсан байршил, шилжилтийн шалтгаан, байршлаар	106
Хүснэгт 8.11.	Шилжин ирэгчийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, байршлаар	107
Хүснэгт 8.12.	Шилжин ирэгчийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, хүйсээр	108
Хүснэгт 8.13.	Шилжин ирэгчийн хувийн жин, шилжин ирсэн хугацаагаар	108
Хүснэгт 8.14.	Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, хүйсээр	109
Хүснэгт 8.15	Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, байршлаар	110
Хүснэгт 8.16	Судалгаанд хамрагдсан 15-64 насны хүн амын хувийн жин, ирээдүйн шилжилт, амьжтргааны байршлаар	111
Хүснэгт 8.17	Ядуу өрхийн магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр	112
Хүснэгт 8.18	Нийгмийн эмзэг өрхийн магадлалын харьцаа , сонгосон үзүүлэлтээр	114

Зургийн жагсаалт:

Зураг 3.1.	Судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн суварга	7
Зураг 3.1а.	Гэр хорооллын хүн амын нас, хүйсийн суварга	7
Зураг 3.1б.	Байшин хорооллын хүн амын нас, хүйсийн суварга	7
Зураг 3.2.	Судалгаанд хамрагдагчдын хүн ам зүйн ачаалал, байршлаар	8
Зураг 3.3.	Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны хүн амын хувь, боловсролын түвшин, байршлаар	10
Зураг 3.4.	Өрхүүдийн хувийн жин, сууцаа олж авсан арга зам, байршлаар	16
Зураг 4.1.	Ажиллах хүчний үзүүлэлтүүд	22
Зураг 4.2.	Эдийн засгийн идэвхгүй хүн амын хувийн жин, ажил эрхлээгүй шалтгаанаар	24
Зураг 4.3.	Хүн амын хувийн жин, ажил эрхлэлт, байршил, шилжилтийн байдлаар	25
Зураг 4.4.	Хүн амын хувийн жин, ажил эрхлэлт, боловсролын түвшингээр	26
Зураг 5.1.	Арван тав ба түүнээс дээш настай хүн амын хүйсийн харьцаа, боловсролын түвшин, байршлаар	33
Зураг 5.2.	Долоогоос арван найман насны сургууль завсардсан хүүхдүүдийн хувийн жин, байршил, хүйсээр	34
Зураг 5.3.	ЕБС-иас 2 ба түүнээс дээш км зайд оршдог өрхийн эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр	35
Зураг 5.4.	ЭМД-тай хүн амын эзлэх хувь, байршлаар	38
Зураг 5.5.	ЭМД-тай хариулагчдын хувийн жин, ЭМД-ын хураамж төлж буй байдал, байршлаар	39
Зураг 5.6.	Өрхийн эмнэлгээс 3 ба түүнээс дээш км-т алслагдсан өрхийн эзлэх	

	хувь, сонгосон үзүүлэлтээр	41
Зураг 5.7.	Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой хүн амын хувь, сонгосон үзүүлэлтээр	41
Зураг 6.1.	Хөтөлбөр, төслүүдийн талаар мэдээлэл авсан, үр шимээс нь хүртсэн өрхийн хувь, өрхийн амьжиргааны түвшингээр	50
Зураг 6.2.	Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамрагдсан болон сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлсэн өрхүүдийн хувь, амьжиргааны түвшнээр	54
Зураг 7.1.	Лоренцийн муруй, Улаабаатар	64
Зураг 7.2	Хэрэглээний зардалын хувиарлалт, байршлаар	66
Зураг 7.3	Нийгэм эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус өрхүүдийн хамгийн их ялгаа	69
Зураг 7.4	Нийгэм эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус ялгаа харьцангуй бага үзүүлэлтүүд	70
Зураг 7.5	Нийгэм эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус ялгаа харьцангуй бага үзүүлэлтүүд	70
Зураг 7.6	Хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, байршлаар	73
Зураг 7.7	Хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, шилжилтийн байдлаар	74
Зураг 7.8	Хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, сууцны төрлөөр	76
Зураг 7.9	Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Ахуйн нөхцөл	78
Зураг 7.10	Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Боловсрол	78
Зураг 7.11	Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Эрүүл мэнд	79
Зураг 7.12	Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Ажил эрхлэлт ба нийгмийн оролцоо	80
Зураг 7.13	Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Бүртгэл ба орлогын эх үүсвэр	80
Зураг 7.14	Оролцооны хамгийн чухал хэсгүүд 1	81
Зураг 7.15	Оролцооны хамгийн чухал хэсгүүд 2	82
Зураг 7.16	Оролцооны хамгийн чухал хэсгүүд 3	82
Зураг 7.17	Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Ахуйн нөхцөл	83
Зураг 7.18	Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Боловсролын хүртээмж	83
Зураг 7.19	Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Эрүүл мэндийн хүртээмж	84
Зураг 7.20	Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Орон сууц, боловсрол ба эрүүл мэнд	84
Зураг 7.21	Ядуурлын гурван цагираг	91
Зураг 7.22	Ядуурлын гурван цагираг	92
Зураг 7.23	Нийгмийн эмзэг бүлгийнхэн ба нэн ядуу хүмүүс	92
Зураг 7.24.1	Нийгмийн эмзэг бүлгийн болон хэрэглээний хувьд ядуу хүмүүсийг харьцуулах нь 1	94
Зураг 7.24.2	Нийгмийн эмзэг бүлгийн болон хэрэглээний хувьд ядуу хүмүүсийг харьцуулах нь 2	94
Зураг 8.1.	Хүн амын нас, хүйсийн суварга	97
Зураг 8.2.	Шилжин ирэгчдийн хувийн жин, Улаанбаатарт амьдарч буй хугацаагаар	105
Зураг 8.3.	Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн хувийн жин, аймгаар	105
Зураг 8.4	Шилжин ирсэн бүртгэлгүй хүмүүсийн хувийн жин, дүүргээр	109

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Үндэслэл

Монголд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал үргэлжилсээр байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоос (ҮСГ, 2001) үзэхэд Улаанбаатар хотын хүн амын гуравны нэгийг шилжин ирэгсэд бүрдүүлж байна.

Шилжих хөдөлгөөний үр дагавар Улаанбаатар хотын гэр хороололд илүү тод илэрч байна. Хотын гэр хорооллын хүн амын хурдтай өсөлт нь хотын нийгэм, эдийн засгийн болон засаг захиргааны ажилд асар их ачаалал үүсгэж, ядуурлыг улам бүр гүнзгийрүүлэн тэлж байна. Гэр хорооллын оршин суугчдын олонхи нь ажилгүй эсвэл албан бус секторт ажиллах нэр төдий аж төрж байна. Шилжин ирэгсдийн энэхүү түрэлт дэд бүтцийн чадавхийг шавхаж байгаа бөгөөд хөдөөнөөс ирээд дасан зохицох, амьжиргааны наад захын нөхцлийг бүрдүүлэхэд нь туслах, боловсрол, эмнэлгийн үйлчилгээнд хамруулах зэрэг нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэхэд сайтар боловсруулсан төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил шаардагдаж байна.

2000 онд хийгдсэн Монголын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар шилжин ирэгчдийн ахуйн нөхцөл Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай харьцуулахад муу байна гэсэн дүн гарчээ (НХХЯ, ХАССТ, НҮБХАС, 2001).

Шилжих хөдөлгөөн нь ядууралд нөлөө үзүүлсээр байна. Ядуучуудын бодит тоо 1995 онд 828 мянга байснаа 1998 онд 849.8 мянга болж өссөн боловч нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувийн жин 36.3-аас 35.6 хувь болж буурчээ. Нийт ядуучуудын талаас илүү хувь нь хот, суурин газарт, тэдгээрийн дөрөвний нэг орчим хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна. Ядуу хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг илэрхийлэгч үзүүлэлт болох ядуурлын ялгаа 1995 онд 5.7 байснаа 7.1 болж өсчээ (Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, 2000).

Цэвэр усаар хангагдаж чадаагүй айл өрхүүд олон байгаагийн зэрэгцээ тэд хог, хаягдал, муу ус, бохир зайлуулах нэгдсэн сүлжээгүй орчинд, ердийн зуухан халаалттай, халуун усны гачаалалтай аж төрж байна. Гэр хороололд цахилгаанд холбогдоогүй өрхүүд ч цөөнгүй байна.

Бодлогын арга хэмжээ нь шилжигчид болон ядуучуудын хүний эрхийг хамгаалах, тэдэнд нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг ядуурлаас сэргийлэхэд чиглэгдэх хэрэгтэй байна. Үүний тулд бодлогын арга хэмжээ, тэдгээрийн зохицуулалтанд шаардлагатай үндсэн мэдээллээр хангах асуудал онцгой чухал юм. Гэтэл Улаанбаатар хотын байшин болон гэр хороололд орлого, хэрэглээний тэгш бус байдлыг нарийн харуулсан судалгаа хараахан хийгдээгүй байна.

1.2 Судалгааны зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшинг орлого, хэрэглээнд үндэслэн тооцож, ядуурал, шилжих хөдөлгөөний асуудлыг цогц байдлаар судлахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах асуудлуудыг дэвшүүлэн тавьсан юм. Үүнд:

- Амьжиргааны гол эх үүсвэр, өрхийн орлого, хэрэглээний бүтцийг тодорхойлох;
- Нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг тодорхойлох;
- Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг гэр ба байшин хороолол, шилжигч ба шилжигч бус хүн амаар тодорхойлох;
- Улаанбаатарт шилжин ирэгчдийн шалтгаан, бүртгэлгүй иргэдийн нийгмийн үйлчилгээний хүртээмжийг тодорхойлох;
- Ядуурал ба шилжих хөдөлгөөний хоорондын хамаарлыг тодорхойлох;
- Ядуу хүн амын шинж байдал болон нийгмийн эмзэг бүлгийг тодорхойлж, бодлогын зөвлөмж гаргах;

1.3 Илтгэлийн бүтэц

Илтгэлийг дараах бүтэцтэйгээр бэлтгэлээ. Илтгэл нь хураангуй хэсгээр эхлэх ба энд судалгааны гол үр дүнг танилцуулсан болно. Бүлэг 1-д судалгааны үндэслэл болон зорилгыг тодорхойлж өгөв. Бүлэг 2-г судалгааны арга зүй-аргачлалыг, Бүлэг 3-т түүвэрлэгдсэн хүн амын шинж байдлыг тайлагнасан болно. Бүлэг 4-д хүн амын ажил эрхлэлт ба орлогын эх үүсвэрийн талаар авч үзсэн. Хүн амын боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн талаар Бүлэг 5-д өгүүлнэ. Харин Бүлэг 6-д мэдээллийн хүртээмж, нийгмийн капиталын асуудлыг хөндсөн юм. Ядуурал гэсэн 7-р бүлэгт ядуу хүн амын шинж байдлыг тодруулан, анхаарал хандуулах зорилтот бүлэг болон нэн тэргүүнд шаардагдаж буй үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж өгөв. Чадавхи болон нийгмийн капитал дээр үндэслэн ядуурлын сонгосон үзүүлэлтүүдийг судалсан. Бүлэг 8-д шилжигчдийн шинж байдал, шилжих хөдөлгөөн ба ядуурлын холбоо, хамаарлыг шинжлэн үзлээ. Төгсгөлд нь судалгааны гол үр дүн дээр үндэслэсэн бодлогын зөвлөмжийг санал болгосон болно.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг бид тоон болон чанарын аргаар хийсэн болно.

2.1 Түүвэрлэлтийн арга

Тоон болон чанарын судалгаанд хоёуланд нь санасмаргүй түүвэрлэлтийг аргыг ашигласан.

2.1.1 Тоон судалгаа

Хоёр шатат энгийн санасмаргүй түүврийн аргыг түүврийн загварт хэрэглэв. Түүвэрлэлтийн эхний шатанд түүврийн анхдагч нэгж болох 30 хороог Улаанбаатар хотын 96 хорооноос хүн амынх нь тоотой шууд хамааралтайгаар, түүвэрлэлтийн хоёр дахь шатанд дээрх 30 хороо бүрээс 50 өрхийг санасмаргүй түүврийн аргаар тус тус сонгосон болно.

Түүврийн хэмжээ

Түүвэр олонлогийн хэмжээг дараах томъёоны тусламжтай тодорхойлов. Үүнд:

$$n = \left[\frac{e^2}{t^2 p(1-p)} \right]^{-1}, \quad \text{Үүнд } n - \text{Түүвэр олонлогийн хэмжээ}$$

e- Түүврийн алдаа

p- Ядуу хүн амын хувийн жин

t- Итгэх түвшний утга

Түүвэр судалгааны алдааг 0.04 хувь, итгэх түвшний утгыг 0.05 хувь байхаар сонгов.

Хүснэгт 2.1 Ядуурлын түвшин, байршлаар

Байршил	Ядуурлын түвшин	Нийт хүн ам		Нийт ядуу хүн ам	
		мян.хүн	хувь	мян.хүн	Хувь
Хот	39.4	1252.3	52.5	493.4	57.2
Улаанбаатар хот	34.1	649.8	27.2	221.6	25.7
Аймгийн төвүүд	45.1	602.5	25.2	271.8	31.5
Хөдөө	32.6	1134.7	47.5	369.9	42.8
Улсын хэмжээнд	35.6	2387	100	849.8	100

Эх сурвалж: ҮСГ, 1999. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998. Улаанбаатар

Улаанбаатар хотод ядуурлын түвшин 34.1 хувьтай байгаа нь хотын ядуурлын түвшин (39.4 хувь) ба аймгийн төвүүдийн ядуурлын түвшнээс доогуур болохыг Хүснэгт 2.1 харуулж байна. Гэхдээ ядуурлын эдгээр үзүүлэлтүүд өрхүүдийн сууцны төрлөөр

Судалгааны арга зүй

ангилагдаагүй байна. Амьжиргааны түвшний судалгаанд ашиглах өөр ямар нэгэн бодитой статистик мэдээлэл хараахан байхгүй байгаа тул эдгээр үзүүлэлтүүдийг түүвэр олонлогийн хэмжээг тодорхойлоход ашигласан юм.

Эдгээр мэдээлэл болон дээрх томъёог ашиглан түүвэр олонлогийн оновчтой хэмжээг 539 өрх гэж тодорхойллоо. Түүврийн бус алдаа болон кластерийн нөлөөг хамгийн бага байлгах үүднээс эх олонлогоос нийт 1500 өрхийг түүвэр судалгаанд хамрууллаа (Түүвэр судалгааны практикаас үзвэл ихэнх тохиолдолд кластерийн нөлөөний коэффициент 2.5-тай тэнцүү байдаг).

Түүврийн хүрээ ба хамрагдалт

Судалгаанд сонгогдсон дүүрэг, хороо, өрх, өрхийн хүн амын тоог Хүснэгт 2.2-д үзүүлэв.

Хүснэгт 2.2 Түүвэрлэлтийн хүрээ

Дүүрэг	Сонгогдсон			
	Хороо	Өрх	Хүн ам	Хувь
Баянзүрх	4	200	909	13.3
Налайх	2	100	492	6.7
Сонгинохайрхан	10	500	2344	33.3
Сүхбаатар	7	350	1448	23.3
Хан-Уул	2	100	481	6.7
Чингэлтэй	5	250	1173	16.7
Бүгд	30	1500	6847	100.0

1500 өрхийн (Улаанбаатар хотын 6 дүүргийн 30 хорооноос) 6847 хүн ам түүвэр судалгаанд хамрагдаж, түүврийн хамрагдалтын түвшин 100 хувь байв. Судалгаанд гэр хорооллын 816 (54.4 хувь) өрхийн 4070 хүн, байшин хорооллын 684 (45.6 хувь) өрхийн 2777 хүн тус тус хамрагдсан.

Асуулгын хуудас

Судалгаанд хамрагдсан өрх, өрхийн гишүүд, хамтран амьдрагчдын хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдлыг тодорхойлох зорилгоор тоон судалгаанд дараах хэсгүүдээс бүрдсэн асуулгын хуудсыг ашигласан. Үүнд:

- Өрхийн гишүүд ба хамтран амьдрагчид
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Ажил эрхлэлт
- Ахуйн нөхцөл
- Орлого ба хэрэглээ
- Зарлага

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

- Нийгмийн үйлчилгээ ба нийгмийн сүлжээ
- Шилжих хөдөлгөөн

Туршилтын судалгаа

Асуулгын чанар, логик уялдаа, хариултын боломжит байдлыг шалгах, өрхүүдийн бэлэн байдлыг тандах зорилгоор туршилтын судалгааг судалгааны 6 баг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2003 оны 9-р сарын 28-29-ний өдрүүдэд явуулав. Туршилтын судалгаанд үндсэн судалгааны түүвэрлэлтэд хамрагдаагүй, ядуурал, шилжих хөдөлгөөн ихтэй гэр (Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо) болон байшин (Сүхбаатар дүүргийн 9-р хороо) хорооллын хороодыг хамруулсан. Туршилтын судалгаанд хамрагдсан 30 өрхийн 18 нь гэр, 12 нь байшин хорооллын өрхүүд байв.

Багийн ахлагч болон ярилцлага авагчдад зориулсан сургалт

Судалгааны ярилцлага авагчаар МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн оюутнуудаас сонгон шалгаруулж авав. Эдгээр оюутнууд Нийгмийн судалгааны арга зүй хичээлд бүрэн хамрагдаж, амжилттай дүүргэсэн оюутнууд юм. Ярилцлага авагчид, багийн ахлагчдад зориулсан сургалтыг дадлагын ажлын хамт 2003 оны 10-р сарын 20-23 хүртэл хугацаанд зохион байгуулж, асуулга авагчид, багийн ахлагч нарт зориулсан мэдээлэл цуглуулах гарын авлага, арга зүйг бэлтгэн тараав. Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын удирдамж боловсруулан, багийн ахлагч, ярилцлага хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч нарт тодорхой зааварчилгаа өгсөн болно.

Мэдээлэл цуглуулалт

Тоон судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2003 оны 11-р сарын 6-наас 20-ны өдрийг дуустал хугацаанд нийт 7 баг, (баг тус бүр багийн ахлагч 5 гишүүнтэйгээр) 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Судалгаанд сонгогдсон өрхийг хайж олоход тухайн хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагчид туслалцаа үзүүлж байлаа. Багийн ахлагч, ярилцлага авагч нар ажил үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдлыг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулах, гаргаж байгаа алдаа, буруу ташаа ойлголтыг олж илрүүлэх зорилгоор явцын хяналтыг мэдээлэл цуглуулж буй газар дээр хянан, шалгаж байсан.

Мэдээлэл цуглуулалтад тохиолдсон бэрхшээлүүд

Цаг агаарын хүйтрэл, хотын зах руу (уулаар) ил задгай буусан айлууд, хотын төвийн байшин хороолол болон Налайх дүүргээс мэдээлэл цуглуулахад илүү их хүндрэлтэй байлаа. Эдгээр бэрхшээлүүдийг даван туулахад хороодын хэсгийн ахлагчид, хогийн байцаагчид, судалгааны багийн жолооч нар гүн туслалцаа үзүүлж байв.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээллийг шалгах, нээлттэй хариултуудыг кодлох ажлын явцад 1500 өрхөөс 47 өрхөд (буюу 3.1 хувь) дахин очиж мэдээллийн тодруулга, залруулга хийв. Тоон судалгааны мэдээллийг ISSA программыг ашиглан компьютерт бэлтгэн оруулж, мэдээллийн боловсруулалт, статистик шинжилгээнд SPSS программыг ашиглав. Өрх, хувь хүний шинж байдлын тархалтын давтамжийг тайлбар статистикийн аргаар шинжлэн судлав. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд болох ядуурлын хамрагдалт (Po), гүнзгийрэлт (P1), ялгаа (P2)-ны индексүүд, Жини коэффициент, Лоренцийн муруйг хотын хэмжээнд, гэр, байшин хороолол болон шилжигч, шилжигч бус хүн амын хувьд тооцоолов. Олон

Судалгааны арга зүй

хүчин зүйлийн ложистик регрессийн загварыг ядуу болон нийгмийн эмзэг бүлэгт нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэхэд ашигласан болно.

2.1.2 Чанарын судалгаа

Түүвэрлэлтээр сонгогдсон гэр болон байшин хорооллын хороодоос шилжих хөдөлгөөнд оролцогчид олонтой, ядуурал ихтэй тухайлбал, Баянзүрх дүүргийн 5, 15-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 7, 19-р хороодыг чанарын судалгаанд сонгон авсан.

Мэдээлэл цуглуулалт

Чанарын судалгааны мэдээллийг 2003 оны 12-р сарын 18-23-ны өдрүүдэд ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, ажиглалт гэсэн аргуудыг ашиглан цуглуулав.

Фокус Бүлгийн Ярилцлага

Чанарын судалгаанд ганцаарчилсан ярилцлага, бүлгийн ярилцлагын удирдамжийг ашигласан юм. Ганцаарчилсан ярилцлагыг хотын захын гэр хорооллын хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, өрхийн эмч, сургуулийн багш нийт 8 хүнээс авсан. Бүлгийн ярилцлагыг нийгэм, эдийн засгийн ялгаатай бүлгүүдээр 1) хотын захын гэр хорооллын ядуу иргэд, 2) хотын төвийн байшин хороололд амьдрагчид, 3) шилжин ирсэн бүртгэлгүй иргэд 4) шилжин ирсэн бүртгэлтэй иргэд гэсэн 4 ангиллаар зохион байгуулж нийт 20 хүнийг хамруулав.

Мэдээлэл боловсруулалт

Чанарын судалгааны мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар боловсруулсан.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМ, ӨРХИЙН ШИНЖ БАЙДАЛ


Бүлэг 1-д судалгааны үндэслэл болон зорилгыг тодорхойлж өгөв. Энэхүү бүлэгт судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, яс үндэс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн талаар болон тэдний өрхийн ерөнхий шинж байдлыг танилцуулах болно. Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал, ахуйн нөхцлийг гэр хороолол, байшин хорооллоор ангилан харьцуулав.

3.1 Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал


3.1.1 Хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд хамрагдагсдын 59.4 хувь нь гэр хороололд, 40.6 хувь нь байшин хороололд амьдардаг хүмүүс байв. Хүн амын нас, хүйсийн суваргыг нийт хүн ам болон гэр, байшин хорооллын хүн амын хувьд Зураг 3.1-т харууллаа.


Зураг 3.1. Хүн амын нас, хүйсийн суварга
Нийт хүн ам



Зураг 3.1а. Хүн амын нас, хүйсийн суварга
Гэр хорооллын хүн ам




Зураг 3.1б. Хүн амын нас, хүйсийн суварга
Байшин хорооллын хүн ам



Судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн суваргын ерөнхий хэлбэр нь Монгол улсын хүн амын нас, хүйсийн бүтцийн ерөнхий дүр зурагтай ойролцоо гарсан юм. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хүн амын төрөлтийн түвшин урьд өмнөхөөс илүү хурдацтай буурч, одоо тогтворжих хандлагатай болж байгааг эдгээр зургаас харж болно. Энэ нь гэр болон байшин хорооллын хувьд онцын ялгаагүй байна.

Судалгаанд хамрагдагсдын 46.6 хувь нь эрэгтэй, 53.5 хувь нь эмэгтэй, хүйсийн харьцаа 87.4 байв. Мөн судалгаанд хамрагдагсдын голч нас 24 (хүн амын 50 хувь нь 24 -өөс доош настай, үлдсэн 50 хувь нь 24-өөс дээш настай хүн ам), дундаж нас 28 гарчээ.



Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн насны 100 хүн тутамд хөдөлмөрийн бус насны 45.3 хүн ногдож байгаа (хүн ам зүйн ачаалал) нь төдийлөн өндөр үзүүлэлт биш юм (Зураг 3.2). Гэр хороололд хүн ам зүйн ерөнхий ачаалал байшин хорооллоос 5 пунктээр өндөр байв. Хүүхэд насны хүн ам зүйн ачаалал нь гэр хороололд байшин хорооллоос бараг 9 пунктээр их, харин хөгшин настны ачаалал 4 орчим пунктээр бага байна.

Судалгаанаас өмнөх 7 хоногт ямар нэг орлого олох ажил эрхэлсэн эсэхээр нь эдийн засгийн (эдийн засгийн идэвхтэй 100 хүн амд ногдох эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо) ачааллыг тооцож үзэхэд 215.2 хувь гарчээ. Энэ нь ажил эрхэлж буй 1 хүн өөрөөсөө гадна 2-оос илүү хүнийг тэжээж байна гэсэн үг юм.

Хүснэгт 3.1-д судалгаанд хамрагдагсдыг хүн ам зүйн зарим шинж байдлаар нь харууллаа.

Арван тав ба түүнээс дээш настай нийт хүн амын тал орчим (50.3 хувь) хувь нь гэр бүлтэй хүмүүс байсан ба тэдний дийлэнх (80.7 хувь) нь гэрлэлтээ баталгаажуулжээ. Харин 37.8 хувь нь огт гэрлээгүй хүмүүс байв. Өрхийн байршлын хувьд гэрлэлтээ баталгаажуулсан өрхийн хувь байшин хороололд гэр хорооллоос өндөр байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр Монгол улсын ястан үндэстнээс халх, казак, дөрвөд, баяд, буриадуудын эзлэх хувь бусдаас харьцангуй өндөр байсан учир судалгаанд эдгээр ястан, үндэстнийг тусгайлан ангилж (гадаадын 9 хүнийг “бусад” гэсэн ангилалд оруулсан) үзсэн. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх (86.9 хувь) нь халх, 3.8 хувь нь казак, 2.7 хувь нь дөрвөд, 2.1 хувь нь баяд, 1.0 хувь нь буриад, 3.5 хувь нь бусад ястан, үндэстэн байгаа нь тооллогын үр дүнтэй нэлээд ойролцоо түвшинд байна. Байршлаар нь авч үзвэл, гэр хороололд амьдрагчдын 90 хувь нь, байшин хороололд амьдрагчдын 88.2 хувь нь халхууд байв.

Шилжих хөдөлгөөний асуултыг судалгаанд хамрагдсан зөвхөн 15-64 насны хүн амын хувьд асуусан бөгөөд энэ насны хүн амын 14.6 хувь нь сүүлийн 4 жилийн дотор

Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

шилжих хөдөлгөөнд оролцсон байв. Нийт шилжин ирэгчдийн дийлэнх (79.5 хувь) нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 3.1. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, хүн ам зүйн үзүүлэлтүүд, байршлаар

Хүн ам зүйн үзүүлэлтүүд	<i>Байршил</i>		Нийт
	Байшин хороолол	Гэр хороолол	
Гэрлэлтийн байдал*			
Огт гэрлээгүй	34.7	40.0	37.8
Батлуулсан гэр бүлтэй	43.7	38.3	40.6
Батлуулаагүй гэр бүлтэй	8.6	10.6	9.7
Тусгаарласан	1.5	1.7	1.6
Салсан	3.1	1.9	2.4
Бэлбэсэн	8.4	7.5	7.9
Бүгд	100.0	100.0	100.0
15 ба түүнээс дээш настай хүн амын тоо	2136	2917	5053
Яс үндэс			
Халх	88.2	90.0	86.9
Казак	2.5	0.6	3.8
Дөрвөд	2.5	2.3	2.7
Буриад	1.6	2.6	1.0
Баяд	2.1	2.0	2.1
Бусад**	3.1	2.5	3.5
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт хүн амын тоо	3654	3193	6847
Шилжилтийн байдал***			
Шилжигч	7.2	19.8	14.6
Шилжигч бус	92.8	80.2	85.4
Бүгд	100.0	100.0	100.0
15-64 настай хүн амын тоо	1952	2760	4712

* - Арван тав ба түүнээс дээш настай хүн амын гэрлэлтийн байдал.

** - Гадаадын 9 хүнийг бусад гэсэн ангилалд оруулав.


*** - Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзэв.

3.1.2 Нийгэм, эдийн засгийн шинж байдал

Судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшинг нийт хүн ам болон гэр, байшин хорооллоор харьцуулан Зураг 3.3-т харуулав.

Нийт хүн амын 32.8 хувь нь бүрэн дунд (10 жил), 21.5 хувь нь бүрэн бус дунд¹ (8 жил), 12.3 хувь нь техник мэргэжлийн болон тусгай дунд/бүрэн бус дээд, 21.3 хувь нь дээд, үлдсэн 12.1 хувь нь бага боловсролтой болон боловсролгүй хүмүүс байлаа. Хүн амын боловсролын түвшин өрхийн байршлаар нэлээд ялгаатай байна. Байшин хороололд амьдарч буй тусгай мэргэжлийн дунд/ бүрэн бус дээд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин гэр хорооллынхоос 2 пунктээр, дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувийн жин 27 пунктээр өндөр байхад техник мэргэжлийн боловсролоос доош боловсролтой хүн амын эзлэх хувийн жин 2-15 пунктээр бага байв. Өөрөөр хэлбэл, гэр хороололд оршин суугчдын боловсролын түвшин байшин хорооллынхоос доогуур байна.

¹ Монголын боловсролын системээр, эхний 3 жил нь бага (8-10 нас), дараагийн 5 жил нь бүрэн бус дунд (11-16 нас), дахин 2 жил сурснаар бүрэн дунд боловсрол (17-18 нас) эзэмшдэг.



Судалгаанд хамрагдсан хүн амын ажил эрхлэлтийн байдлыг Хүснэгт 3.2-т харууллаа.

Хүснэгт 3.2. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, байршлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Ажил эрхлэлт			
Ажил эрхэлдэг	39.5	47.5	42.9
Ажил эрхэлдэггүй	60.5	52.5	57.1
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт хүн амын тоо	2917	2136	5053
Ажиллаж буй сектор			
Албан	63.1	73.4	67.9
Албан бус	35.7	24.0	30.2
Гадаадад	1.2	2.6	1.9
Бүгд	100.0	100.0	100.0
Ажил эрхэлдэг хүн амын тоо	1152	1014	2166

Арван тав ба түүнээс дээш настай хүн амын 42.9 хувь нь судалгаа авахын өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр ямар нэг орлого олох ажил эрхэлсэн гэж хариулсан бөгөөд энэ нь байшин хороололд гэр хорооллынхоос 8 пунктээр өндөр байгаа юм.

Ажил эрхлэлтийг сектороор нь ангилж үзвэл, судалгаанд хамрагдагсдын 67.9 хувь нь албан секторт, 30.2 хувь нь албан бус секторт, 1.9 хувь нь гадаадад ажиллаж байв.

Байршлын хувьд энэ нь нэлээд ялгаатай байна. Гэр хорооллын хүн амын хувьд албан бус секторт ажилладаг хүн амын эзлэх хувийн жин байшин хорооллынхоос 12 пунктээр өндөр байхад албан секторт ажилладаг хүмүүсийн эзлэх хувийн жин 10 пунктээр бага байлаа. Эндээс гэр хорооллынхон албан бус секторт илүү их ажилладаг нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

3.2. Өрхийн шинж байдал

3.2.1 Өрхийн тэргүүний шинж байдал

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 76.3 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 23.7 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байв. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь байшин хороололд гэр хорооллынхоос 4 пунктээр өндөр байлаа.

Хүснэгт 3.3. Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүний хүн ам зүйн шинж байдал, байршлаар

Өрхийн тэргүүний шинж байдал	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Хүйс			
Эрэгтэй	78.1	74.1	76.3
Эмэгтэй	21.9	25.9	23.7
Насны бүлэг			
20-с доош	1.1	0.4	0.8
20-34	24.5	20.9	22.9
35-44	27.3	28.4	27.8
45-54	25.1	23.2	24.3
55-64	11.9	12.0	11.9
65 ба түүнээс дээш	10.1	15.1	12.3
Гэрлэлтийн байдал			
Огт гэрлээгүй	5.8	7.9	6.7
Батлуулсан гэр бүлтэй	61.0	58.0	59.7
Батлуулаагүй гэр бүлтэй	11.7	8.6	10.3
Тусгаарласан	2.0	2.5	2.2
Салсан	3.4	5.3	4.3
Бэлбэсэн	16.1	17.7	16.8
Хүүхдийн тоо			
Хүүхэдгүй	11.3	20.8	15.6
1-2	48.7	59.1	53.4
3 ба түүнээс дээш	40.1	20.2	31.0
Дундаж	2.3	1.6	1.9
Шилжилтийн байдал*			
Шилжигч	18.3	7.2	13.4
Шилжигч бус	81.7	92.8	86.6
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт өрхийн тоо	816	684	1500
Өрхийн тэргүүн нь 15-64 настай нийт өрхийн тоо	734	581	1315*

Тэмдэглэл: * Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзэв.

Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчдийг насны бүтцээр задалбал, 22.9 хувь нь 20-34 настай, талаас илүү (35-54 насны өрхийн тэргүүлэгч 52.1%) хувь нь идэр настай, 24.2 хувь нь ахмад (55 ба түүнээс дээш) настай, 0.8 хувь нь 20-оос доош настай хүн ам байв. Монголчуудын дунд өрхийн тэргүүлэгч нь нас барсан нөхцөлд насанд хүрээгүй эрэгтэй хүүхдээ өрхийн тэргүүлэгчээр тодорхойлох явдал цөөнгүй тохиолддог нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Өндөр настай тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь байшин хороололд гэр хорооллоос 5 пунктээр өндөр байгааг үл харгалзвал өрхийн тэргүүлэгчдийн насны бүтэц байршлын хувьд онцын ялгаагүй байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчдийн 70 орчим хувь нь гэрлэсэн, 6.7 хувь нь огт гэрлээгүй, 16.8 хувь нь бэлбэсэн, үлдсэн 6.5 хувь нь салсан/тусгаарласан хүмүүс байлаа. Нийт гэр бүлтэй өрхийн тэргүүлэгчдийн дийлэнх (85.3%) хувь нь гэрлэлтээ хуулиар баталгаажуулжээ. Гэрлэсэн өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувь гэр хороололд байшин хороолоос 6 пунктээр өндөр байхад огт гэрлээгүй болон салсан/тусгаарласан, бэлбэсэн өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувь байшин хороололд гэр хороолоос 1-2 пунктээр өндөр байна. Байшин хороололд бэлбэсэн өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувь гэр хорооллынхоос их байгаа нь магадгүй судалгаанд хамрагдсан өндөр настай хүмүүсийн эзлэх хувь байшин хороололд өндөр байгаатай холбоотой байж болох юм.

Нийт судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчдийн 53.4 хувь нь 1-2 хүүхэдтэй, 31.0 хувь нь 3 ба түүнээс олон хүүхэдтэй, үлдсэн 15.6 хувь нь огт хүүхэдгүй бөгөөд өрхийн тэргүүлэгчид дунджаар 1.9 хүүхэдтэй гэсэн үр дүн гарчээ. Гэр хороололд амьдардаг өрхийн тэргүүлэгч дунджаар 2.3 хүүхэдтэй байгаа нь байшин хорооллынхоос 0.7 пунктээр өндөр байна.

Өрхийн тэргүүлэгчдийн 13.4 хувь нь судалгаанаас өмнөх сүүлийн 4 жилийн дотор Улаанбаатар хотод шилжин ирсэн бөгөөд тэдний дийлэнх (76.1%) нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 3.4-т судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчдийн нийгэм, эдийн засгийн шинж байдлыг байршлаар харуулав.

Өрхийн тэргүүлэгчдийн талаас илүү (52.6 хувь) хувь нь бүрэн дундаас доош боловсролтой, 45 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой, 2.4 хувь нь боловсролгүй байлаа. Дээд боловсролтой өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувийн жин байшин хороололд гэр хорооллынхоос 37 орчим пунктээр өндөр байсан бол огт боловсролгүй өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувийн жин гэр хороололд байшингийнхаас 1.5 пунктээр өндөр байв. Ерөнхийдөө техник мэргэжлийн боловсролоос доош боловсролын түвшинтэй өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувь гэр хороололд илүү өндөр, харин түүнээс дээш боловсролтой өрхийн тэргүүлэгчдийн хувь арай бага байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа.

Өрхийн тэргүүлэгчдийн 59.6 хувь нь судалгаанаас өмнөх 7 хоногт орлого олох ямар нэг ажил эрхэлсэн (Үүнд: ажил эрхлээгүй боловч хөдөлмөрийн гэрээтэй байгаа хүмүүс бас орно) бөгөөд ийм өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувийн жин байшин хороололд гэр хороолоос 7 пунктээр өндөр байна.

Ажил эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн 62.5 хувь нь албан секторт, 35.9 хувь нь албан бус секторт, 1.6 хувь нь гадаадад ажиллаж байна. Албан секторт ажилладаг өрхийн тэргүүлэгчдийн эзлэх хувийн жин байшин хороололд гэр хороолоос 12 пунктээр өндөр, харин албан бус секторт ажиллагчдын эзлэх хувийн жин гэр хороололд байшингийнхаас 14 пунктээр өндөр байв.

Хүснэгт 3.4. Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүний нийгэм, эдийн засгийн шинж байдал, байршлаар

Өрхийн тэргүүний шинж байдал	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Боловсролын түвшин			
Боловсролгүй	3.1	1.6	2.4
Бага	9.9	4.8	7.6

Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

Бүрэн бус дунд	25.6	9.2	18.1
Бүрэн дунд	32.0	20.8	26.9
Техник мэргэжлийн	7.5	4.1	5.9
ТМД, бүрэн бус дээд	11.2	12.1	11.6
Дээд	10.7	47.4	27.5
Ажил эрхлэлт			
Ажил эрхэлдэг	56.4	63.5	59.6
Ажил эрхэлдэггүй	43.6	36.5	40.4
Ажиллаж буй сектор			
Албан	56.5	68.9	62.5
Албан бус	42.8	28.6	35.9
Гадаадад	0.7	2.5	1.6
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт өрхийн тоо	816	684	1500
Өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг нийт өрхийн тоо	460	434	894

3.2.2 Өрхийн хүн ам зүйн шинж байдал

Өрхийн хүн ам зүйн шинж байдлыг байршлаар Хүснэгт 3.5-д харуулав. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн дийлэнх (90.4 хувь) нь оршин сууж буй хороондоо бүртгэлтэй² байсан ба байшин хорооллын бүртгэлгүй өрхийн эзлэх хувь гэр хорооллынхоос 1 пунктээр илүү байлаа. Энэ нь магадгүй байшин хороололд бусдын байр, хажуу өрөө хөлслөн суудаг айлууд нэлээд байдагтай холбоотой байж болох юм.

Нийт өрхийн талаас илүү хувь (63.4 хувь) нь 3-5, 25 орчим хувь нь 6 ба түүнээс дээш, 11.9 хувь нь 1-2 гишүүнтэй байв. Байшин хорооллын 1-2 гишүүнтэй өрхийн эзлэх хувь гэр хорооллынхоос 2 дахин, 2-5 гишүүнтэй өрхийн эзлэх хувь гэр хорооллынхоос 7 пунктээр өндөр, 6 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн эзлэх хувь гэр хороололд байшингийнхаас 2 дахин өндөр байлаа. Байшин хороололд дунджаар 4.8 гишүүнтэй өрхүүд, гэр хороололд дунджаар 5.9 гишүүнтэй өрхүүд амьдарч байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн дийлэнх (82.2 хувь) нь нэг ч шилжин ирэгчгүй, 10.1 хувь нь 1-2 шилжин ирэгчтэй, үлдсэн 10 хүрэхгүй хувь нь 3 ба түүнээс дээш шилжин ирэгчтэй өрхүүд байв. Байшин хорооллын нийт өрхийн 10 хүрэхгүй хувь нь шилжин ирэгчтэй өрхүүд байхад гэр хорооллын нийт өрхийн 12.4 хувь нь 1-2, 8.3 хувь нь 3-4, 3.4 хувь нь 5 ба түүнээс дээш шилжин ирэгчтэй өрхүүд байлаа.

Хүснэгт 3.5. Өрхийн хувийн жин, өрхийн хүн ам зүйн шинж байдал, байршлаар

Өрхийн хүн ам зүйн шинж байдал	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Хороондоо бүртгэлтэй эсэх			
Бүртгэлтэй	90.9	89.8	90.4
Бүртгэлгүй	9.1	10.2	9.6

² Бүртгэл нь хэд хэдэн түвшинд хийгддэг: нийслэл хотын түвшинд (энэ нь тухайн иргэн Улаанбаатар хотын иргэн болж байгаа тохиолдолд), дүүргийн түвшинд, хорооны түвшинд. Тухайн иргэн хороондоо бүртгүүлэхийн тулд эхлээд хотод болон харьяа дүүрэгтээ бүртгүүлсэн байх ёстой. Хороондоо бүртгүүлээгүй хүн хотод бүртгүүлсэн ч байж болно, бүртгүүлээгүй ч байж болно.

Өрхөд амьдарч буй хүний тоо			
1-2	8.0	16.7	11.9
3-5	60.0	67.4	63.4
6 ба түүнээс дээш	32.0	15.9	24.7
Дундаж	5.9	4.8	5.5
Өрхөд шилжин ирсэн хүний тоо			
0	75.9	89.8	82.2
1-2	12.4	7.5	10.1
3-4	8.3	2.5	5.7
5 ба түүнээс дээш	3.4	0.2	2.0
Дундаж	0.8	0.2	0.6
Өрхөд амьдарч буй гэр бүлийн тоо			
1	81.9	85.4	83.5
2 ба түүнээс дээш	18.1	14.6	16.5
Дундаж	1.3	1.3	1.3
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт өрхийн тоо	816	684	1500

Судалгаанд хамрагдсан дийлэнх өрхүүдэд ихэвчлэн (83.5%) нэг л гэр бүл амьдарч байв. Харин 2 ба түүнээс олон ам бүлтэй холимог өрхийн хувь гэр хороололд байшин хорооллоос өндөр (4 пунктээр) байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

3.2.3 Өрхийн ахуйн нөхцөл

Өрхийн амьдарч буй сууцны төрөл, зориулалтыг байршлаар Хүснэгт 3.6-д харуулав³.

Судалгаанд хамрагдсан дийлэнх өрхүүд (82.1 хувь) орон сууц, эсвэл байшинд амьдардаг, харин гэр хорооллын нийт өрхийн гуравны нэг нь буюу 33 хувь нь гэрт амьдардаг гэжээ.

Байшинд амьдардаг өрхүүдийг сууцны зориулалтаар нь ангилж үзвэл, тэдгээрийн талаас илүү (51.3 хувь) нь нийтийн сууцны байшин доторх сууц буюу угсармал, тоосгон орон сууцанд, 42.3 хувь нь сууцны тусдаа байшинд, 3.8 хувь нь нийтийн эзэмшлийн бусад байруудад, үлдсэн 2.6 хувь нь сууцны зориулалтын бус байр болох орцны 00-ийн өрөө, жижүүрийн байр, зөөврийн сууц (вагончик), амбаар болон албан байгууллагын өрөөнүүдэд амьдарч байна. Гэр хорооллын өрхийн дийлэнх (95.3 хувь) нь сууцны тусдаа байшинд, байшин хорооллын өрхийн дийлэнх (92.2 хувь) нь нийтийн сууцны доторх сууцанд амьдарч байна. Харин хүн суухад зориулагдаж баригдаагүй сууцанд амьдарч буй өрхийн эзлэх хувийн жин байшин хороололд гэр хороолоос 2 дахин өндөр байгаа нь байшин хорооллын байруудын бараг орц бүрт орцны жижүүр амьдардагтай холбоотой болов уу.

³ Гэр хороололд ихэнх өрхүүд гэр эсвэл хашаа байшинд амьдардаг. Гэр хорооллын байшингууд зөөврийн болон урсгал уснаас ундны усаа авдаг, төвлөрсөн бус халаалтын системтэй байдаг.

Хүснэгт 3.6. Өрхийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, байршлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Амьдарч буй сууцны төрөл			
Гэр	33.0	0.0	17.9
Байшин*	67.0	100.0	82.1
Сууцны зориулалт**			
Сууцны тусдаа байшин	95.3	0.0	42.3
Нийтийн сууцны байшин доторх сууц	0.0	92.2	51.3
Нийтийн эзэмшлийн байр	3.1	4.4	3.8
Сууцны бус	1.6	3.4	2.6
Сууцны эзэмшил			
Өөрийн эзэмшлийн	91.0	83.8	87.7
Өөрийн эзэмшлийн бус	9.0	16.2	12.3
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт өрхийн тоо	816	684	1500


Тэмдэглэл: * Сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторх сууц, нийтийн эзэмшлийн байрууд, мөн сууцны зориулалтын бус байрууд орно.

** Гэр ороогүй.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 87.7 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг ажээ. Харин өөрийн эзэмшлийн бус сууцанд амьдардаг өрхүүдийн эзлэх хувь байшин хороололд гэр хорооллоос 1.8 дахин өндөр байв. Энэ нь байшин хорооллын айлууд орон сууцаа бусдад хөлслүүлэх нь түгээмэл болсонтой холбоотой.

Өрхүүд амьдарч буй сууцаа янз бүрийн байдлаар олж авсан нь судалгаанаас харагдаж байна (Зураг 3.4). Тухайлбал, гэр хорооллынхон голдуу (71.1 хувь) өөрсдөө барьсан/худалдаж авсан сууцанд амьдардаг бол байшин хорооллынхон эцэг, эхээсээ өвлөж авсан байранд (52.2 хувь) амьдардаг ажээ. Хүмүүс байшин хороололд байр хөлсөлж суухаас гадна бас гэр хороололд хашаа, байшин хөлсөлж суух тохиолдол цөөнгүй байгаа нь харагдаж байна. Энд сонирхол татаж буй нэг зүйл бол бусдын байр, хашаа, байшин харж үнэ хөлсгүй суудаг өрхүүд (6.1 хувь) цөөнгүй байгаа явдал юм. Байшин хороололд энэ үзүүлэлт гэр хорооллоос 2 пунктээр өндөр байна. Эдгээр өрхүүдийн зарим нь магадгүй бусдын орон гэрийг харж, зарим нь бусдын (танил, хамаатан садныдаа) гэр/хашаа, байшинд хамт амьдардаг байж болох юм.

Хүснэгт 3.7-д өрхийн сууцны ахуйн нөхцлийн шинж байдлыг байршлаар харуулав. Судалгаанд хамрагдсан байшин хорооллын нийт өрх төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрээс цахилгаан авдаг бол гэр хорооллын өрхийн 5.1 хувь нь цахилгаан гэрэлгүй, лаа хэрэглэдэг ажээ.



Хүснэгт 3.7 Өрхийн хувийн жин, өрхийн ахуйн нөхцөл, байршлаар

Ахуйн нөхцөл	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Гэрэлтүүлэг			
Төвлөрсөн цахилгаан	94.9	100.0	97.2
Лаа	5.1	0.0	2.8
Ундны усны эх үүсвэр			
Төвлөрсөн: Халуун, хүйтэн устай	0.0	93.6	42.7
Зөвхөн хүйтэн устай	0.0	3.5	1.6
Худаг: Хамгаалалттай	82.0	2.3	45.7
Хамгаалалтгүй	6.0	0.3	3.4
Зөөврийн болон гол булаг/шанд	12.0	0.3	6.6
Халаалт			
Төвлөрсөн	0.2	97.7	44.7
Төвлөрсөн бус	2.3	1.0	1.7
Ердийн галлагаа	97.4	1.3	53.6
Хэрэглэдэг түлшний төрөл*			
Цахилгаан	28.4	99.1	60.7
Мод	98.2	6.9	56.5
Нүүрс	95.2	1.9	52.7
Аргал	4.4	0.0	2.4
Хий	0.1	2.2	1.1
Бусад	0.1	0.3	0.2
Бие засах газар			
Сууц дотроо төвлөрсөн: Тусдаа	0.1	93.1	42.5
Нийтийн	0.1	5.1	2.4
Нүхэн жорлонтой	97.3	1.6	53.7
Байхгүй	2.5	0.1	1.4

Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

Бохир ус зайлуулалт			
Төвлөрсөн	0.0	98.5	44.9
Төвлөрсөн бус	0.9	0.0	0.5
Нүх/цооног	89.1	0.6	48.7
Ил задгай	10.0	0.9	5.9
Хог зайлуулалт			
Тусгай зориулалтын хогийн цэг дээр	90.6	99.6	94.7
Ил задгай нүх, суваг, шуудуунд	9.4	0.4	5.3
Өрөөний тоо**			
1	67.5	24.5	43.8
2	25.5	47.0	37.4
3	5.0	23.3	15.1
4 ба түүнээс дээш	2.0	5.1	3.8
Илүү гэр/байшин/гарааштай эсэх			
Байгаа	43.4	20.0	32.8
Байхгүй	56.6	80.0	67.2
Утастай эсэх			
Утастай	42.0	84.5	61.4
Утаасгүй	58.0	15.5	38.6
	100.0	100.0	100.0
Бүгд			
Нийт өрхийн тоо	816	684	1500

Тэмдэглэл:* Олон сонголттой хариултаас тооцсон хувь.

** Гэр ороогүй.

Ундны усны эх үүсвэрийг сонирхож үзвэл, байшин хорооллын өрхүүд (94.1 хувь) төвлөрсөн цэгээс хэрэглээний халуун, хүйтэн усаа авдаг, гэр хорооллын өрхийн дийлэнх (82.0 хувь) нь хамгаалалттай худгаас ундны усаа авдаг гэжээ. Нийт өрхийн 44.3 хувь нь төвлөрсөн цэгээс (халуун, хүйтэн ус), 45.7 хувь нь хамгаалалттай худгаас, 3.4 хувь нь хамгаалалтгүй худгаас, 6.6 хувь нь бусад эх үүсвэрээс ундны усаар хангагдаж байна. Өөрөөр хэлбэл, эрсдэлтэй буюу ямар нэг байдлаар хамгаалалтгүй ус ундандаа хэрэглэж буй өрх гэр хороололд байшин хорооллоос бараг 30 дахин өндөр байна. Түүнчлэн, гэр хороололд амьдардаг өрхүүд ундны усаа авдаг худгаасаа дунджаар 358.5 метр зайтай амьдарч байна. Гэр хорооллын иргэдийн усан хангамж харьцангуй муу гарсан нь тэнд ундны ус нэн тулгамдсан асуудал хэвээр байгааг судалгааны үр дүн дахин нотолж байна. Тэд зарим үед нэгээс хоёр цаг дугаарлан зогсож байж ус авдаг, заримдаа худгийн ус дуусдаг болохоор дугаарлаж зогссон хэдий ч усгүй хонох тохиолдол гардаг талаар судалгаанд хамрагдсан бүлгийн ярилцлагад оролцогчид өгүүлж байлаа.

“...Халуун усны газар зайлшгүй хэрэгтэй байна. Мааш олон хүн үүнийг хүсэж байгаа. Худгийн асуудал их хүндрэлтэй. Усны хангамж хүрэлцээгүйгээс нэг худаг дээр мааш их дараалал үүсдэг ч заримдаа ус нь хүрэлцэхгүй дуусчихдаг.”

(Б, эмэгтэй, нас 45, багш, БЗД-5)

Энд сэтгэл эмзэглэмээр бас нэг асуудал нь байшин хороололд амьдардаг ч төвлөрсөн сүлжээгээр ундны усаа авч чаддаггүй айлууд мэр сэр байгаа явдал юм. Тэдгээр айлууд ихэвчлэн байшин хороолол дунд байрладаг хуучны ажилчдын нийтийн байруудад

амьдардаг ажээ. Ер нь дүүрэг болгонд иймэрхүү (төвлөрсөн усгүй, бие засах газаргүй, хогийн тусгай цэггүй) ахуйн наад захын нөхцөл хангадаггүй нийтийн байруудад амьдардаг айлууд цөөнгүй байдаг байна.

“...Тэдгээр нийтийн байруудад ус байдаггүй учир хэдийд ч хамаагүй айлын хаалга нүдээд явж байдаг. Ус тоолууртай болсон учир хэр баргийн айл ус өгөхгүй шүү дээ.”

(Д, эмэгтэй, нас 53, хорооны Засаг дарга, СХД)

Гэр ба байшин хорооллын ахуйн нөхцлийн бас нэг том ялгаа бол халаалтын төрөл юм. Байшин хорооллын өрхийн дийлэнх (97.7 хувь) нь төвлөрсөн халаалтын сүлжээтэй байхад гэр хорооллын өрхийн дийлэнх (97.4 хувь) нь ердийн халаалттай байв.

Нийт өрхийн хэрэглэдэг түлшийг төрлөөр нь ангилбал, *нэгдүгээрт*: цахилгаан (60.7 хувь), *хоёрдугаарт*: мод (56.5 хувь), *гуравдугаарт*: нүүрс (52.7 хувь) зонхилж байна. Мөн аргал, хий зэрэг түлш хэрэглэдэг өрхүүд тодорхой хувийг эзэлж байна. Түүнчлэн түлшиндээ цаас, хог зэрэг бусад зүйлс хэрэглэдэг өрхүүд ч цөөнгүй байв. Гэр хорооллынхон бүгд мод, нүүрс түлдэг байхад байшин хорооллынхон голдуу цахилгаан хэрэглэж байна.

Ахуйн нөхцлийг тодорхойлогч гол үзүүлэлтүүдийн нэг нь бие засах газрын төрөл юм. Судалгаанд хамрагдсан өрхийн 42.5 хувь нь сууц дотроо төвлөрсөн, 2.4 хувь нь сууц дотроо нийтийн, 53.7 хувь нь нүхэн жорлонтой, үлдсэн 1.4 хувь нь жорлонгүй гэжээ. Энэ үзүүлэлтийг байршлаар үзвэл, байшин хорооллынхон мэдээж ихэнх (93.1%) нь сууц дотроо төвлөрсөн, харин гэр хорооллынхон ихэнх (97.3%) нь нүхэн жорлонтой байв. Байшин хороололд нийтийн бие засах газартай өрхүүд нийт өрхийн 5.1 хувийг эзэлж байгаа нь гэр хорооллынхоос 5 пунктээр өндөр байна. Харин огт жорлонгүй өрх байшин хорооллын нийт өрхийн 0.1 хувийг эзэлж байв. Эдгээр өрхүүд магадгүй нөгөө л нийтийн эзэмшлийн гэгдэх байранд амьдардаг байна. Тэдний хувьд жорлон, хогийн цэг, бохир усны цооног нэн тулгамдсан асуудал гэдэг нь тодорхой юм. Энэ байдал ойр орчмын агаар, хөрсний бохирдолд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй бусад иргэдийн эрүүл мэнд, тайван амьдрах нөхцөл бололцоонд ч муугаар нөлөөлдөг байна.

“...Гурван гологдол байрныхан л хогоо хаа хамаагүй ил асгадаг. Тэдэнд жорлон байхгүй учир ил задгай бие засаж, бохироо асгадаг. Тийм болохоор энд хөрс, агаарын бохирдолт маш өндөр. Ойр хавийнх нь байрны айлууд бид тэдний өтгөн шингэнээр амьсгалж байна гэж уурладаг.”

(Д, эмэгтэй, нас 53, хорооны Засаг дарга, СХД)

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн тал орчим (48.7 хувь) нь нүхэн цооногт, 44.9 хувь нь төвлөрсөн сүлжээгээр, 0.5 хувь нь төвлөрсөн бус сүлжээгээр, 5.9 хувь нь ил задгай бохир усаа зайлуулдаг гэжээ. Гэр хорооллынхны ихэнх нь (99.1 хувь) нүхэн цооногт, 10.0 хувь нь ил задгай, 1 хүрэхгүй хувь нь төвлөрсөн бус сүлжээгээр бохир усаа зайлуулдаг, харин байшин хорооллынхон бараг нийтдээ (98.5 хувь) төвлөрсөн сүлжээгээр бохир усаа зайлуулж байна.

Байршлаас үл хамааран судалгаанд хамрагдсан өрхийн дийлэнх (94.7 хувь) нь төвлөрсөн цэгт хогоо асгадаг болсон нь сайшаалтай юм. Гэхдээ гэр хорооллын өрхийн 9.4 хувь, байшин хорооллын өрхийн 0.4 хувь нь ил задгай буюу суваг, шуудуунд хогоо асгадаг гэжээ.

Судалгаанд хамрагдсан хүн ам, өрхийн шинж байдал

Байшинд амьдардаг өрхүүдийн дийлэнх (81.2 хувь) нь 1-2 өрөөтэй сууцанд (гал тогоог оруулахгүй) амьдарч байна. Гэр хорооллын нэг өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн хувь байшин хорооллынхоос бараг 3 дахин өндөр, харин байшин хороололд 3 ба түүнээс дээш өрөөтэй сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувийн жин гэр хорооллынхоос 4 дахин өндөр байв.

Судалгаанд хамрагдсан өрхийн 32.8 хувь нь амьдардаг сууцнаасаа гадна ямар нэгэн амбаар, гарааш, эсвэл илүү гэртэй гэж хариулжээ. Гэр хорооллынхны хувьд ийм өрхийн эзлэх хувь байшин хорооллоос 2 дахин өндөр байв. Илүү гэр, амбаартай гэж ихэвчлэн гэр хорооллынхон, харин гарааштай гэж байшин хорооллынхон хариулсан байна.

Манай улсад цахилгаан утсан холбоо нэлээд хөгжиж, түүний ашиглалтын хүрээ өргөжиж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Энэ үзүүлэлт тухайн өрхийн ахуйн нөхцөл, амьжиргааны түвшинг тодорхой хэмжээгээр илэрхийлж байдаг. Нийт өрхийн талаас илүү буюу 61.4 хувь нь гэртээ утастай гэж хариулжээ. Энэ нь суурин болон үүрэн телефоны аль нэг нь, эсвэл хоёулаа байгаа өрхүүдийн эзлэх хувийн жин юм. Байшин хороололд амьдарч буй өрхийн 84.5 хувь нь гэртээ ямар нэг холбоо барих утастай байгаа нь гэр хорооллынхоос 2 дахин өндөр хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан 1500 өрхийн 269 нь гэрт амьдардаг бөгөөд тэдгээрийн талаас илүү (64.3 хувь) нь 5 ханатай, 23.0 хувь нь 4-өөс бага, 12.7 хувь нь 6 ба түүнээс дээш ханатай гэрт амьдарч байна (Хүснэгт 3.8).

Хүснэгт 3.8. Гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, гэр сууцны нөхцлөөр

Сууцны нөхцөл	Өрхийн хувь
Ханын тоо*	
4-өөс бага	23.0
5	64.3
6 ба түүнээс дээш	12.7
Туурга**	
Дан	40.5
Давхар	59.5
Бүрээс***	
Дан	39.8
Давхар	60.2
Шал****	
Шалтай	77.7
Шалгүй	22.3
Бүгд	100.0
Гэрт амьдардаг нийт өрхийн тоо	269

Тэмдэглэл: * Гэр нь модон сараалжин ханатай. Хананы тоо нь гэрийн хэмжээг тодорхойлдог. Хамгийн жижиг гэр нь 3 ханатай байдаг.

** Гэр нь эргэн тойрондоо эсгий бүрээстэй байдаг. Дулааны улиралд ихэнхдээ дан, харин хүйтний улиралд давхар бүрээс тавьдаг.

*** Туурга олон давхар байх нь чийг нэвтрэхээс хамгаалдаг.

**** Ихэнхдээ эвхдэг модон шал хэрэглэдэг. Зуны улиралд зарим өрхүүд шал тавьдаггүй.

Гэрт амьдардаг өрхүүдийн хувьд хүйтний улиралд давхар бүрээс, туурга болон шал тавьж хэрэглэдэг эсэх нь амьжиргааны түвшингийн чанарыг харуулах чухал үзүүлэлт болдог. Судалгаанд хамрагдсан гэрт амьдардаг өрхүүдийн 59.5 хувь нь хүйтний улиралд давхар бүрээстэй, 60.2 хувь нь давхар туургатай, 77.7 хувь нь шал тавьсан

гэжээ. Энэ нь гэрт амьдардаг өрхүүдийн цөөнгүй хувийнх нь ахуйн нөхцөл байдал тааруухан байгааг харуулж байна.

Дүгнэлт

Нийслэлийн хүн амыг насны бүтцээр нь авч үзвэл, хөдөлмөрийн насны (15-64 нас) 2 хүн хөдөлмөрийн бус насны (хүүхэд, өндөр настан) 1 хүнийг тэжээхээр байгаа боловч ажил хийж буй 1 хүн өөрөөсөө гадна 2 хүнийг тэжээж байна. Ялангуяа, гэр хорооллынхны эдийн засгийн ачаалал байшин хорооллынхноос илүү өндөр байна. Энэ нь Улаанбаатар хотод, ялангуяа гэр хорооллын хүн амын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгааг харуулж байна.

Хөдөлмөр оролцооны түвшин хүйсийн хувьд нэлээд ялгаатай байгаа нь эдийн засгийн идэвхгүй хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаатай холбоотой юм. Хотын эмэгтэйчүүд гэрийн ажил, хүүхэд, өндөр настан асрах зэрэг өрхийн үнэлгээгүй ажилд эрэгтэйчүүдээс илүүтэй оролцож байна.

Гэр хороололд оршин суугчдын боловсролын түвшин байшин хорооллынхоос доогуур, мөн орлоготой ажил эрхэлдэг хүн амын хувийн жин ч байшин хорооллынхоос эрс бага байна. Харин албан бус секторт ажил эрхлэлт байшин хорооллынхноос өндөр байв. Өөрөөр хэлбэл, мэргэжил, боловсролын өндөр түвшин төдийлэн шаарддаггүй салбарт ажиллагсад гэр хороололд олон байна.

Ахуйн нөхцөл, тэр дундаа цэвэр усны хангамж гэр хороололд нэн хангалтгүй байна. Хамгаалалтгүй ус ундандаа хэрэглэж буй өрх гэр хороололд байшин хорооллоос 30 дахин илүү байгаа ба усны урт дараалалд зогсоод ч усгүй хонох тохиолдол гарсаар байна.

Гэрт амьдардаг өрхүүдийн тал орчим хувь нь өвлийн улиралд шалгүй, давхар бүрээс, давхар туургагүй гэрт амьдарч байгаа нь тэд ахуйн нөхцлийн наад захын шаардлага хангагдаагүй сууцанд амьдарч байгааг харуулж байна. Арван айл тутмын нэг нь ахуйн хог хаягдлаа ил задгай хаяж байгаа нь гэр хорооллынхны эрүүл амьдрах орчин, ахуйн нөхцлийг доройтуулахад нөлөөлж байна.

Байшин хороололд гэр хорооллын ахуйн нөхцөлтэй ижил, бараг түүнээс ч дор нөхцөлд амьдарч буй өрхүүд цөөнгүй байна. Тэдгээр нь ахуйн наад захын нөхцөл хангахгүй болсон нийтийн эзэмшлийн байруудад амьдардаг өрхүүд юм. Захын хороололд амьдарч байгаа хүмүүс дулааны цахилгаан станцын дуу чимээ, арьс ширний үйлдвэрийн үнэр, танар, утаа тортогт баригдан тав тух алдсаар байна.

Байшинд оршин суугчдын дийлэнх нь утсан холбоо ашиглаж байгаа нь сайшаалтай боловч гэр хорооллын хүн амын ердөө тал хүрэхгүй хувь нь л утас ашиглаж байна. Энэ нь гэр хорооллынхонд харилцаа холбооны хөгжлийн хүртээмж бага, ямар нэгэн гэнэтийн яаралтай асуудал гарахад түргэн шуурхай холбоо барих боломж муу байгааг харуулж байна.

БҮЛЭГ 4. АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ОРЛОГО

Бүлэг 4-д түүвэрлэгдсэн хүн амын ажил эрхлэлт ба орлогын эх үүсвэрийн талаар авч үзсэн. Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын хүн амын ажил эрхлэлтийн байдал, ажил эрхлэлтийг тодорхойлогч үзүүлэлтүүд, ажил эрхлээгүй шалтгааныг тодорхойлох юм. Түүнчлэн албан ба албан бус секторуудын ялгаатай байдлыг тодорхойлж, өрхийн орлогын эх үүсвэрүүд, орлогын бүтцийг харуулахыг зорьсон болно.

Түлхүүр асуултууд

- Ажил эрхлэлтийн түвшин ямар байна вэ?
- Ажилгүйдлийн түвшин ямар байна вэ? Ажилгүйдэл нь хүн амын бүлгүүдийн дунд ямар байна вэ?
- Өрхийн орлогын гол эх үүсвэрүүд юу вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Ажил эрхлэлтийн түвшин 42.4 хувь байна.
- Ажилгүйдлийн түвшин 22.9 хувь байна. Гэр хороололд оршин суугчид (29.5 хувь), эмэгтэйчүүд (23.2 хувь) болон шилжин ирэгчдийн (24.6 хувь) хувьд ажилгүйдлийн түвшин өндөр байна.
- Хүн амын боловсролын түвшин ба ажил эрхлэлтийн хооронд мэдэгдэхүйц хамаарал ажиглагдаж байна.
- Өрхийн сарын дундаж орлогын бүтцийг авч үзвэл: Нийт орлогын 67.5 хувь нь цалин, 18.2 хувь нь мөнгөн тусламж/бэлэг/түрээс хүүгийн орлого, 8.4 хувь нь тэтгэвэр тэтгэмжээс бүрдэж байна.

4.1 Ажил эрхлэлтийн байдал

4.1.1 Ажил эрхлэлтийн талаарх ойлголт, тодорхойлолтууд

Хүн амын ажил эрхлэлтийн байдлыг судлахаас өмнө ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолтуудыг авч үзье. Юуны өмнө эдийн засгийн идэвхтэй болон эдийн засгийн идэвхгүй хүн амын ялгааг гаргах нь чухал. Эдийн засгийн идэвхгүй хүн ам гэдэг нь одоогоор ажил эрхлэхгүй байгаа бөгөөд ажил эрхлэхэд бэлэн бус байгаа хүмүүс юм. Үүнд: Оюутан сурагчид, гэрийн ажилтай хүмүүс, бүртгэл, бичиг баримтын зөрчлийн улмаас ажил эрхлээгүй хүмүүс, өндөр насны тэтгэвэрт байгаа хүн ам, ажлаасаа түр цомхотгогдсон ч дахин ажил олохоор эрж хайхгүй байгаа хүн ам багтана.

Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажил эрхэлж байгаа болон ямар нэгэн орлоготой ажил эрхлэхээр хайж байгаа бүх хүн ам багтана. Ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүйчүүдийг нийтэд нь ажиллах хүчинд хамруулан ойлгоно.

Ажилгүйчүүд нь ажиллах хүчний нэг хэсэг бөгөөд (эдийн засгийн идэвхтэй) судалгааны үед ямар нэгэн ажил эрхлээгүй хүмүүс юм.

Энэхүү бүлгийн хүрээнд дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ:


Ажил эрхлэлт ба орлого

- Ажиллах хүчинд багтаж байгаа нийт хүн ам/Ажиллах хүч (=эдийн засгийн идэвхтэй хүн ам). Ажиллах хүчнийг 15 ба түүнээс дээш насны нийт хүн амд хуваасан харьцаагаар ажиллах хүчний оролцооны түвшин тодорхойлогдоно.
- Ажиллах хүчний нэг хэсэг болох *ажил эрхэлж буй хүн ам*. Ажил эрхэлж байгаа нийт хүн амыг 15 ба түүнээс дээш насны нийт хүн амд харьцуулсан харьцаагаар ажил эрхлэлтийн түвшинг тодорхойлж болно.
- Ажиллах хүчний нэг хэсэг болох *ажилгүйчүүд*. Ажилгүйдлийн түвшинг тооцохдоо ажилгүй байгаа, өөрөөр хэлбэл ажил идэвхтэй хайж байгаа нийт хүн амыг ажиллах хүчинд хуваана.
- Ажиллах хүчинд багтахгүй буюу *эдийн засгийн идэвхгүй хүн ам*.

Ажил эрхлэлтийн түвшин ба ажилгүйдлийн түвшингийн нийлбэр нь 100 хувь биш гэдгийг дурьдах нь зүйтэй юм. Учир нь ажил эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны нийт хүн амын тоонд, ажилгүйдлийн түвшин нь зөвхөн ажиллах хүчний тоонд үндэслэгдэн тооцоологдсон болно.

Доорх схем нь эдгээр ойлголтуудын холбоо хамаарлыг тодорхой харуулна.

Зураг 4.1 Ажиллах хүчний үзүүлэлтүүд



Ажил эрхлэлт нь ерөнхийдөө 15 ба түүнээс дээш насны хүн амд хамаарах асуудал учраас энэхүү бүлэгт зөвхөн 15 ба түүнээс дээш насны хүн амын талаар яригдах болно. Хөдөлмөрийн насыг ийнхүү тодорхойлоход суралцаж байгаа шалтгаанаар ажиллах хүчинд орохгүй хүн амын тоо нэлээд өндөр гарч байна. Гэвч судалгааны үр дүнг Монгол Улсад хийгдсэн бусад судалгаа, шинжилгээний ажилтай харьцуулах зорилгоор хөдөлмөрийн насыг стандарт байдлаар 15 ба түүнээс дээш насаар авсан болно.

Тодорхойлолтын үр дүн

Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн насны нийт хүн амын 42.4 хувь нь ямар нэгэн орлоготой ажил эрхэлж байна (Хүснэгт 4.1). Ажил эрхэлж байгаа нийт хүн амын 7.0 хувь нь удирдах албан тушаалтнууд, 11.9 хувь нь багш, эмч зэрэг албан хаагчид, 7.4 хувь нь инженер техникийн ажилтнууд, 23.5 хувь нь үйлчилгээний ажилтнууд, 15.2 хувь нь борлуулалт, худалдааны ажилтнууд, 22.5 хувь нь ачигч, зөөгч, оёдолчин, үйлчлэгч зэрэг түгээмэл мэргэжлийн ажил эрхэлдэг хүмүүс байна.

Хүснэгт 4.1 Ажиллах хүчний үзүүлэлтүүд, хариулагчдын шинж байдлаар

Хариулагчдын шинж байдал	Ажиллах хүчний үзүүлэлтүүд		
	Ажиллах хүчний оролцооны түвшин	Ажил эрхлэлтийн түвшин	Ажилгүйдлийн түвшин
<i>Хүйс</i>			
Эрэгтэй	62.4	48.3	22.5
Эмэгтэй	49.9	38.3	23.2
<i>Байршил</i>			
Гэр хороолол	56.1	39.5	29.5
Байшин хороолол	54.9	47.5	13.6
<i>Шилжилтийн байдал</i>			
Шилжигч	53.8	40.6	24.6
Шилжигч бус	60.3	46.7	22.7
<i>Нийт</i>	55.6	42.4	22.9

Улаанбаатар хотын нийт эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчний 23 орчим хувь нь ажилгүйчүүд байна. Гэр хорооллын хүн амын дундах ажилгүйдлийн түвшин байшин хорооллынхоос 16 орчим пунктээр өндөр байна. Энэ нь ажил эрхлэх хүсэлтэй ч ажил олдохгүй байгаа хүн ам буюу ажилгүйчүүдийн хувь гэр хороололд байшин хорооллынхоос өндөр байгааг харуулж байна.


15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 55.6 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүмүүс буюу ажиллах хүчин байна. Эрэгтэй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэй хүн амынхаас өндөр байгаа нь эмэгтэйчүүд харьцангуй эрт тэтгэвэрт гардаг, эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалд эрэгтэйчүүдээс өндөр, мөн гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн тоо харьцангуй өндөр байгаатай холбоотой юм.

“Эдийн засгийн идэвхгүй” байгаа шалтгаан

Зураг 4.2-т эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтцийг харуулав. 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 44.4 хувь буюу 2245 хүн эдийн засгийн идэвхгүй байгаа ба эдгээр хүн амын бараг тал хувь нь суралцагсад байна. Суралцаж байгаа шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй байгаа нь хүн амын насны бүтэцтэй холбоотой юм. Ажил

Ажил эрхлэлт ба орлого

эрхлээгүй шалтгааныг байршлаар авч үзвэл өвчний улмаас ажил эрхлээгүй, улмаар ажиллах хүчинд багтаагүй хүн амын хувь гэр хороололд байшин хорооллоос 38.6 хувиар өндөр байгаа нь гэр хорооллын хүн амын эрүүл мэндийн байдал доогуур байгаатай холбоотой байж болох юм. Түүнчлэн байшин хорооллын 65 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин гэр хорооллынхоос өндөр байгаагаас хамааран тэтгэвэрт байгаа шалтгаанаар ажил эрхлээгүй хүмүүс байшин хороололд гэр хорооллоос өндөр байна.



Шилжилтийн нэг үндсэн шалтгаан нь суралцах, боловсрол, мэргэжлээ дээшлүүлэх явдал байгаатай холбоотойгоор шилжигч хүн амын хувьд суралцдаг шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа хүн амын хувь шилжигч бус хүн амынхаас 4.5 пунктээр өндөр байна.

Мөн шилжих хөдөлгөөний бүлэгт өгүүлсэнчлэн шилжин ирсэн нийт хүн амын тэн хагас нь бүртгүүлээгүй иргэд байна. Иймээс шилжигчдийн хувьд бүртгэл, бичиг баримтын зөрчлийн улмаас ажил эрхлээгүй тохиолдол шилжигч бус хүн амаас 5.7 дахин өндөр байна.

4.1.2 Хүн амын бүлгүүдийн дундах ажил эрхлэлтийн байдал

Судалгаанд хамрагдсан хүн амын ажил эрхлэлтийн байдлыг хүн ам зүйн шинж байдлаар Хүснэгт 4.2-д харуулав. Нийтлэг зүй тогтлын дагуу ажил эрхлэлтийн түвшин 35-44 насанд хамгийн өндөр буюу энэ насны 10 хүн тутмын 7 нь ажил эрхэлж байна.

Огт гэрлээгүй хүн амын 60 орчим хувь нь 20-оос доош насны, эцэг эхтэйгээ хамтран амьдарч байгаа хүн ам байгаа учраас энэ насны бүлгийн хүн амын ажил эрхлэлтийн түвшин доогуур гарчээ.


Гэр хороололд оршин суугчдын ажил эрхлэлт байшин хорооллынхны ажил эрхлэлтээс 8 пунктээр бага байна (Зураг 4.3). Тухайлбал, гэр хорооллын эдийн засгийн идэвхтэй 5 хүн тутмын 2 нь ажил эрхэлж байгаа бол байшин хорооллын эдийн засгийн идэвхтэй 5 хүн тутмын 3 нь ажил эрхэлж байна. Энэ нь байшин хорооллыг бодвол гэр

хорооллынхны боловсролын түвшин доогуур байгаатай холбоотой юм (Боловсрол ба ажил эрхлэлтийн хамаарлыг Зураг 4.4-с үзнэ үү).

Хүснэгт 4.2 15 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, ажил эрхлэлт, хүн ам зүйн шинж


Хүн ам зүйн шинж байдал	Ажил эрхлэлтийн байдал		Бүгд	15 ба түүнээс дээш настай нийт хүн амын тоо
	Ажил эрхэлдэг	Ажил эрхэлдэггүй		
Нас				
20 хүртэл	7.2	92.8	100.0	920
20-34	51.1	48.9	100.0	1930
35-44	71.2	28.8	100.0	914
45-54	58.2	41.8	100.0	634
55-64	27.1	72.9	100.0	314
65+	2.6	97.4	100.0	341
Хүйс				
Эрэгтэй	48.3	51.7	100.0	2301
Эмэгтэй	38.3	61.7	100.0	2752
Гэрлэлтийн байдал				
Огт гэрлээгүй	24.7	75.3	100.0	1909
Батлуулсан гэр бүлтэй	59.1	40.9	100.0	2052
Батлуулаагүй гэр бүлтэй	54.4	45.6	100.0	491
Тусгаарласан	63.4	36.6	100.0	82
Салсан	59.2	40.8	100.0	120
Бэлэвсэн	23.3	76.7	100.0	399
	42.9	57.3	100.0	5053
Нийт				

Ажил эрхлэлт ба орлого



Шилжин ирэгчдийн дунд ган, зудаас болоод малгүй болсон малчид буюу ажлын дадлага, туршлагагүй хүмүүс, боловсрол багатай, бүртгэл, бичиг баримтгүй хүмүүс тодорхой хувийг эзэлж байгаа нь шилжигсдийн ажил эрхлэлтийн түвшин доогуур байгаагийн үндсэн шалтгаан болж байна (“Шилжих хөдөлгөөн” бүлгийг үзнэ үү).

Хүн амын боловсролын түвшин дээшлэхийн хэрээр ажил эрхлэлт нэмэгдэж буй ерөнхий зүй тогтол ажиглагдаж байна (Зураг 4.4). Дээд боловсролтой хүн амын ажил эрхлэлт боловсролгүй, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын ажил эрхлэлтээс өндөр байна. Ийнхүү ажлын байртай байх нэг шалгуур бол боловсролын түвшингээ ахиулах явдал болох нь судалгаагаар нотлогдож байна.



Ажил эрхлэлтийн байдлыг өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар үзвэл (Хүснэгт 4.3) 1-2 хүн амьдардаг өрхийн тэргүүлэгчдийн бараг тэн хагас нь (46.9 хувь) ямар нэгэн

орлоготой ажил эрхэлж байхад 3-5 хүнтэй өрхийн тэргүүлэгчдийн бараг гуравны хоёр нь ажил эрхэлж байна.

Түүнчлэн олон хүн амьдардаг өрхүүдийн хувьд цөөн хүнтэй өрхийг бодвол хүн ам зүйн ачаалал арай өндөр, улмаар ажил эрхлэлтийн түвшин доогуур байгаатай холбоотойгоор өрхийн ядууралд өртөх магадлал илүү байж болох юм.

Хүснэгт 4.3 Өрхийн хувийн жин, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт, өрхийн шинж байдлаар

Өрхийн шинж байдал	Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт		Бүгд	Нийт өрхийн тоо
	Ажил эрхэлдэг	Ажил эрхэлдэггүй		
Хүүхдийн тоо				
Хүүхэдгүй	41.9	58.1	100.0	1068
1-2	63.7	36.3	100.0	2287
3 ба түүнээс дээш	61.5	38.5	100.0	
Өрхөд амьдарч буй хүний тоо				
1-2	46.9	53.1	100.0	179
3-5	64.0	36.0	100.0	951
6 ба түүнээс дээш	54.3	45.7	100.0	370
Өрхөд байгаа гэр бүлийн тоо				
1	62.2	37.8	100.0	1252
2 ба түүнээс дээш	46.4	53.6	100.0	248
Хороондоо бүртгэлтэй эсэх				
Бүртгэлтэй	59.3	40.7	100.0	1356
Бүртгэлгүй	62.5	37.5	100.0	144
	42.9	57.3	100.0	1500
Нийт				

Оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ засаг захиргаанд бүртгэлтэй өрхийн тэргүүлэгчдийн ажил эрхлэлтийн түвшин бүртгүүлээгүй өрхийн тэргүүлэгчдийн ажил эрхлэлтийн түвшингээс доогуур байна. Үүнээс үзвэл, хүмүүс хороогоор дамжуулан ажил олох нь ховор байдаг төдийгүй, хороодын зүгээс иргэдийг ажлын байртай болгох, хөдөлмөр эрхлэлтийн албадтай хамтран ажиллах үйл ажиллагаа хангалттай бус байгаа нь харагдаж байна.

4.2 Албан ба албан бус сектор

Энэ бүлэгт албан ба албан бус секторын ялгааг авч үзэх болно.

Ажил эрхэлж буй хүн амыг ажил эрхэлж буй сектороор Хүснэгт 4.4-д харуулав. Нийт хүн амын 68 хувь нь албан, 30 хувь нь албан бус, 2 хувь нь гадаадад ажиллаж байна.

Зах зээлийн нээлттэй байдал, хотжилтын өндөр түвшин, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээс үүдэн нийслэлд албан бус секторууд хүрээгээ тэлсээр байна. Улаанбаатар хотын нийт хүн амын гуравны нэг нь энэхүү сектороос амьжиргааныхаа эх үүсвэрийг залгуулж байгааг судалгааны дүн харуулж байна.

Ажил эрхлэлт ба орлого

Хүснэгт 4.4 Ажил эрхэлж буй хүн амын хувийн жин, ажиллаж буй сектор, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ажиллаж буй сектор			Бүгд	Ажил эрхэлж буй нийт хүн амын тоо	
	Албан	Албан бус	Гадаадад			
Хүйс						
	<i>Эрэгтэй</i>	60.1	37.9	2.0	100.0	1112
	<i>Эмэгтэй</i>	76.2	22.1	1.7	100.0	1054
	Боловсролын түвшин*					
	<i>Бүрэн дунд ба түүнээс доош</i>	62.4	35.3	2.3	100.0	1090
	<i>Бүрэн дундаас дээш</i>	73.8	24.7	1.5	100.0	1062
	Байршил					
	<i>Гэр хороолол</i>	63.1	35.7	1.2	100.0	1152
	Байшин хороолол	73.3	24.0	2.7	100.0	1014
	Шилжилтийн байдал**					
	Шилжигч	62.7	35.8	1.5	100.0	279
	Шилжигч бус	68.7	29.3	2.0	100.0	1878
	Нийт	67.9	30.2	1.9	100.0	2166

Тайлбар: * Боловсролгүй хүн амын тоо маш бага (N=14) байсан тул хасаж тодорхойлов.

** Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд тодорхойлсон болно.

Боловсрол өндөртэй, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хотын иргэд албан секторт ажиллаж байна. Харин шилжин ирэгсэд, боловсрол багатай хүмүүс боловсрол, мэргэжил төдийлөн шаарддаггүй ажил эрхлэх буюу нийгмийн хангамж, хамгаалал хангалтгүй, баталгаатай бус албан бус секторт ажиллаж, орлогын эх үүсвэрээ хангаж байна (Хүснэгт 4.4).

Хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ажил эрхлэлтийн сектороор ялгаатай байгааг Хүснэгт 4.5-аас харж болно. Улсын болон хувийн секторт ажилладаг 10 хүн тутмын 8-9 нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байхад албан бус секторт тухайлбал, айлд гэрээгээр ажилладаг, зах зээл дээр худалдаа хийдэг, гудамжинд гар дээрээс худалдаа хийдэг 10 хүн тутмын 5-6 эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.

Хүснэгт 4.5 Ажил эрхэлж буй хүн амын хувийн жин, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, ажиллаж буй сектороор

Ажиллаж буй сектор	Даатгалд хамрагдсан эсэх		Бүгд	Ажил эрхэлж буй нийт хүн амын тоо
	Хамрагдсан	Хамрагдагүй		
<i>Албан</i>	86.7	13.3	100.0	1471
Албан бус	55.7	44.3	100.0	654
Нийт	76.4	23.6	100.0	2166

Тэмдэглэл: Гадаадад ажиллаж байгаа хүмүүсийн тоо цөөн (N=41) байна. Иймээс мэдээлэл төдийлөн бодитой бус байх учраас хүснэгтэнд оруулаагүй олно.

Албан бус секторт ажиллагсдын цалингийн түвшингийн ялгавартай байдлыг Хүснэгт 4.6-с харж болно. Тухайлбал, хувийн бизнес эрхлэгчдийн цалингаас албан бус секторын

2/3-ыг бүрдүүлж буй ногоо тарих, зах зээл дээр жижиг худалдаа эрхлэх, түүнчлэн хог цуглуулах, ачаа буулгах, зөөх зэрэг хүнд хүчир ажил эрхлэгчдийн цалин 79 хувиар бага байна.

“Хэдэн малаа барсан хүмүүс энд ирээд зах дээр хүнд зарагдаж байж хэдэн төгрөг олж байна. Харин сүйхээтэй нэг хэсэг нь танил тал, ах дүүгийн хүчээр ажил хийж байгаа байх. Зарим нэг хэсэг нь хөдөөнөөс ирэхдээ малаа зарж байж олсон хэдэн төгрөгөөрөө амиа аргацааж байна.”

(Шилжин ирсэн бүртгэлтэй иргэдийн бүлгийн ярицлагаас)

Түүнчлэн улсын болон хувийн байгууллагад ажиллагсадтай харьцуулахад хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүсийн цалингийн түвшин өндөр байгаа нь нэлээд сонирхолтой үзүүлэлт юм.

Хүснэгт 4.6 Ажил эрхэлдэг хүн амын сарын дундаж цалин/орлогын түвшин, ажиллаж буй сектороор

Ажиллаж буй сектор	Дундаж цалин/орлого (төгрөг)	Ажил эрхэлж буй нийт хүн амын тоо
<i>Албан сектор</i>		
Улсын/Хувийн нэг байгууллагад ажилладаг	88 807 87 410	1444
<i>Албан бус сектор</i>		
Хувийн бизнес эрхэлдэг	108 005 122 987	474
Тохиолдлын ажил эрхэлдэг	69 303	173

Тэмдэглэл: Дараахь 3 категорин хувьд давтамж цөөнтэй байсан учраас дундаж цалингийн түвшинг харуулахад ашиглаагүй болно. Үүнд:

Улсын болон хувийн хэд хэдэн байгууллагад ажилладаг N=27, албан сектор

Өөр өрхөд ажилладаг N=7, албан бус сектор

Гадаадад ажилладаг N=41, албан болон албан бус сектор

Албан бус секторт ажилд ороход харьцангуй хялбар, мөн орлого олох боломж илүү байдаг зэргээс хамааран тус секторт ажиллагсдын хүрээ тэлсээр байна. (ОУХБ, Монгол дахь албан бус хэвшил). Энэ нь төр, засгийн зүгээс албан бус секторт ажиллагсдын ажлын нөхцөл, нийгмийн халамж, хамгааллыг сайжруулах чиглэлээр дорвитой ажил зохион байгуулах шаардлагатай болсныг харуулж байна.

4.3 Өрхийн орлогын эх үүсвэрүүд

Улаанбаатар хотын нийт өрхийн 7.7 хувь нь нэг, 92.3 хувь нь нэгээс илүү тооны эх үүсвэрээр орлого бүрдүүлж, амьдралаа залгуулж байна. Нийт өрхийн 82 орчим хувь нь цалингийн орлоготой байхад, ердөө 10 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс орлого олж байна. Мөнгөн тусламж/бэлэг/түрээс/хүүгийн орлоготой өрхүүдийн хувь ХАА-н үйлдвэрлэлээс орлого олдог өрхүүдээс бараг 3 дахин өндөр байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц дараах байдлаар тодорхойлогдож байна (Хүснэгт 4.7).

Хүснэгт 4.7 Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, хувиар, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Орлогын бүтэц					Бүгд	Сарын дундаж орлого /төгрөг/
	Цалин	Тэтгэвэр/Тэтгэмж	Мөнгөн тусламж/бэлэг /түрээс/ хүүгийн орлого	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	ХАА-н үйлдвэрлэлийн орлого		
Байршил							
Гэр хороолол	66.4	9.9	15.8	4.9	3.0	100.0	171287
Байшин хороолол	68.4	7.2	20.0	3.9	0.5	100.0	265238
Шилжилтийн байдал							
Шилжигч	61.8	6.1	24.9	4.2	3.0	100.0	190132
Шилжигч бус	68.2	8.6	17.4	4.4	1.4	100.0	217318
Нийт	67.5	8.4	18.2	4.3	1.6	100.0	214128

Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг нь шилжилтийн байдлаар үзэхэд нэлээд ялгаатай байна. Байшин хорооллын болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй өрхүүдийн сарын дундаж орлого Улаанбаатар хотын өрхийн дундаж орлогоос өндөр байна. Гэр хорооллын нэг өрхийн сарын дундаж орлого байшин хорооллын өрхийн сарын дундаж орлогоос 1.5 дахин, хотын дунджаас 1.3 дахин бага байна. Түүнчлэн шилжих хөдөлгөөнд оролцоогүй өрхийн сарын дундаж орлого нь шилжин ирсэн өрхийн сарын дундаж орлогоос 14.3 хувиар өндөр байна.

Өрхийн сарын дундаж орлого нь цалин, мөнгөн тусламж/бэлэг/түрээс/хүүгийн орлого, тэтгэвэр/тэтгэмж гэсэн голлох эх үүсвэрүүдээс бүрдэж байна.

Гэр хорооллын нийт хүн амын 1/3-с илүү нь цалингийн орлого албан бус секторт ажиллаж олсон буюу зах дээр болон гудамжинд жижиг худалдаа эрхлэх, мод хөрөөдөх, хагалах, хүмүүст ямар нэгэн туслах чанарын үйлчилгээ үзүүлэх зэргээс олсон орлогоос бүрдэж байна. Харин байшин хорооллынхны цалингийн орлогын 3/4 орчим нь албан секторт ажиллаж болсон цалингийн орлогоос бүрдэж байна. Байшин хорооллынхны хувьд байр болон өрөөгөө түрээслүүлэх явдал түгээмэл болсноос мөнгөн тусламж/түрээс/хүүгийн орлогын нийт орлогод эзлэх хэмжээ гэр хорооллынхныг бодвол өндөр хувийн жинтэй гарсан байж болох талтай юм.

Хотод шилжин ирсэн өрхийн нийт орлогын тавны нэгээс илүү хэсгийг ах дүүсийн тусламж, дэмжлэг эзэлж байгаа ба энэ нь шилжигч бус өрхөөс 43.1 хувиар өндөр байна. Шилжигч хүн амын ажил эрхлэлтийн түвшин шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын ажил эрхлэлтээс доогуур байгаатай холбоотойгоор шилжигч өрхийн орлогод цалингийн эзлэх хувийн жин 6.4 пунктээр бага гарчээ. ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувийн жинг шилжилтийн байдлаар харахад 2 дахин зөрүүтэй байна. Үүнээс үзвэл хөдөөгөөс шилжин ирэгсэд малаа зарж, олсон орлогоороо нэг хэсэгтээ амьжиргаагаа залгуулдаг нь харагдаж байна. Бусдаас авдаг тусламж, мал аж ахуйгаас олсон нэг удаагийн орлого зэрэг нь орлогын тогтмол, найдвартай эх үүсвэр биш учраас шилжих хөдөлгөөнд оролцогсод ядууралд өртөх магадлал харьцангуй өндөр байна.

Дүгнэлт

Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны 5 хүн тутмын 2 нь ямар нэгэн орлоготой ажил эрхэлж байгаа бөгөөд ажил эрхлэлт нь эрэгтэйчүүд, өндөр боловсролтой хүмүүс, байшин хороололд оршин суугчид, шилжигч бус хүн амын хувьд өндөр байна.

15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 1/5-с илүү хувь нь ажиллах хүчинд багтаж буй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүйчүүд байна. Гэр хорооллын хүн амын дундах ажилгүйдлийн түвшин нь байшин хорооллынхоос өндөр байгаа нь тэдний боловсролын доогуур түвшинтэй холбоотой юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин хүйсийн хувьд нэлээд ялгаатай байгаа нь эдийн засгийн идэвхгүй хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаагаар тайлбарлагдана. Түүнчлэн, хотын эмэгтэйчүүд гэрийн ажил, хүүхэд, өндөр настан асрах зэрэг өрхийн үнэлгээгүй ажилд эрэгтэйчүүдээс илүүтэй оролцож байна.

Боловсрол өндөртэй, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хотын иргэд албан секторт, харин боловсрол багатай хүн ам, хотод шилжин ирэгсэд албан бус секторт зонхилон ажиллаж байна. Гэтэл боловсрол, мэргэжлийн ур чадвар бага шаарддаг, нийгмийн халамж, хамгаалал хангалтгүй байгаа албан бус секторт ажиллаж буй 2 ажилчин тутмын нэг нь л эрүүл мэндийн даатгалд хамрагджээ.

Улаанбаатар хотын нийт өрхийн 10 өрх тутмын 9 нь нэгээс илүү тооны эх үүсвэрээр орлого бүрдүүлж, амьдралаа залгуулж байна. Өрхийн орлогын голлох эх үүсвэрүүд нь цалин, мөнгөн тусламж/бэлэг/түрээс хүүгийн орлого болон тэтгэвэр, тэтгэмж байна.

Өрхийн орлогын нэг гол эх үүсвэр болох мөнгөн тусламж/бэлэг/түрээс хүүгийн орлого нь байшин хорооллын өрхүүдийн хувьд байр болон өрөөгөө түрээслүүлснээс олж буй мөнгөн орлогоос, шилжин ирсэн өрхүүдийн хувьд ах дүүсийн тусламж, дэмжлэг болон малаа зарж олсон орлогоос голчлон бүрдэж байна.

БҮЛЭГ 5. БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хүн амын боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн талаар Бүлэг 5-д өгүүлнэ. Энэхүү бүлэгт хотын хүн амын боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний байдлыг авч үзсэн болно. Боловсролын үйлчилгээг насанд хүрэгсдийн боловсрол, сургуульд хамрагдалтын түвшин, сургууль завсардалт, түүний шалтгаан, ерөнхий боловсролын сургуулийн байршил, түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын эрүүл мэнд, эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн ажилтны хүрэлцээ, өрхийн эмнэлгийн байршил зэргээр харуулахыг зорилоо.

Түлхүүр асуултууд

- Хэн боловсрол багатай байна вэ?
- Хэн нийгмийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй байна вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Гэр хорооллын эрэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байна.
- 26-35 насны залуучуудын 38.4 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Тэд мэргэжил шаардсан ажил хийх боломжоор хязгаарлагдмал байна.
- Хотын захын гэр хороололд амьдарч буй шилжин ирсэн өрхүүдийн хүүхдүүдийн 1/3 нь хоёроос илүү километр зайг туулж байж сургуульдаа хүрч байна.
- Хотын ерөнхий боловсролын сургуулиудад анги дүүргэлт өндөр, хотын захын хорооллуудад ерөнхий боловсролын сургууль цөөн байгаа нь сургуулийн ачааллыг ихэсгэж байна.
- Албан бус секторт ажиллагсад, эрэгтэйчүүд болон гэр хороололд оршин суугчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин хангалтгүй байна.
- Гэр хороололд амьдарч буй шилжин ирсэн өрхийн 28 хувь нь өрхийн эмнэлгээс 3 ба түүнээс дээш километр зайд алслагдан суурьшжээ.
- Анхаарал хандуулах бүлгийнхний нийгмийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Гэр хороололд шинээр сургууль, цэцэрлэг барьж байгуулахад хөрөнгө оруулалтыг түлхүү хийх шаардлагатай байна.

5.1 Боловсрол

5.1.1 Насанд хүрэгсдийн боловсролын түвшин

Бүлэг 3.1.2-д өгүүлснээр судалгаанд хамрагдсан насанд хүрсэн (15 ба түүнээс дээш насны) хүн амын боловсролын түвшин хотын гэр болон байшин хороололд ялгаатай, ялангуяа дээд боловсрол эзэмшсэн хүн амын хувьд ялгаа нэлээд өндөр байгаа талаар дурьдсан билээ.

Боловсролын түвшинг насны үелрэлээр Хүснэгт 5.1-д харуулав.

15-26 насны залуучууд боловсрол эзэмших насандаа байгаа учраас бид илтгэлдээ энэ насны үелрэлийнхнийг онцгойлон авч үзээгүй болно.

Хүснэгт 5.1 Насанд хүрэгсдийн боловсролын түвшин, насны бүлгээр


Боловсролын түвшин	Насны бүлэг					Нийт
	15-26	26-35	36-45	46-55	55+	
Огт боловсролгүй	2.4	0.9	0.7	1.2	10.9	2.7
Бага	13.7	2.0	2.1	5.7	23.6	9.4
Бүрэн бус дунд	28.3	18.9	16.5	21.1	13.3	21.5
Бүрэн дунд	41.1	38.4	31.8	21.1	11.3	32.8
Мэргэжлийн сургууль	1.7	5.5	8.0	3.5	3.2	4.1
Тусгай дунд/ББД	0.9	7.5	13.7	17.7	13.7	8.2
Дээд	11.8	26.8	27.3	29.6	24.0	21.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	1864	1065	910	592	622	5053

26-35 насны хүн амын 38.4 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа нь бусад үелрэлийнхээс хамгийн өндөр байна. Энэ насныхан илүү эрсдэлтэй байж болох юм. Учир нь тэд цаашид үргэлжлүүлэн суралцаж дээд боловсрол эзэмших эсвэл хөдөлмөрийн зах зээл рүү орох болно. Мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамрагдаагүй бол тэдгээр залуучууд нь ажилгүйчүүд эсвэл мэргэжил шаардсан ажил олж хийж чадахгүй юм. Гэтэл 26-35 насны залуучуудын мэргэжлийн боловсрол эзэмшсэн байдал бусад насны бүлэгтэй харьцуулахад нэлээд доогуур байна. Эдийн засгийн хөгжлийн дорой байдлаас үүдэн мэргэжлийн боловсрол эзэмшээгүй хөдөлмөрийн насны хүн амд ажил олох боломж улам бүр бага байна. Эдийн засгийн бүтцийн хямралаас болоод улсын томоохон аж үйлдвэрүүд хаагдсан, барилга, газар тариалан гэх мэт салбаруудын хөдөлмөрийн эрэлт байхгүй болсон нь мэргэжилтэй боловсон хүчний нийлүүлэлтийг хязгаарлахад нөлөөлж байна. 1990-ээд оноос техник мэргэжлийн боловсрол олгох сургуулиудын нэлээд нь хаагдсан. Үүнтэй зэрэгцэн хуучин социалист системийн орнуудад бүхий л түвшний мэргэжлийн сургуулиудад 8, 10-р анги төгсөгчид олноор нь сургадаг байсан суваг хаагдсан билээ. Түүнчлэн улсын болон хувийн их дээд сургуулиуд борооны дараах мөөг адил олноор байгуулагдаж эхэлсэн бөгөөд ямар нэгэн мэргэжилтэй болохын тулд 10-р анги төгсөгчид эдгээр сургуулиудад л суралцахаас өөр гарцгүй болсон юм. Иймээс ч дээд боловсролтой хүн амын хувийн жин бүх насанд ижил байна.

5.1.2 Боловсрол дахь хүйсийн харьцаа

Насанд хүрэгсдийн боловсрол дахь хүйсийн харьцааг боловсролын түвшин, байршлаар Зураг 5.1-д харуулав.

Бүрэн бус дунд, техник мэргэжлийн боловсролд эрэгтэйчүүд давамгайлж байгаа ба техник мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшсэн гэр, байшин хорооллын хүн амын хүйсийн харьцаа нэлээд ялгаатай байна. Тухайлбал, байшин хорооллын боловсролгүй 100 эмэгтэйд 46 эрэгтэй ногдож байхад гэр хорооллын боловсролгүй 100 эмэгтэйд 63 эрэгтэй, харин дээд боловсролтой 100 эмэгтэйд байшин хороололд 81 эрэгтэй ногдож байхад гэр хороололд 58 эрэгтэй ногдож байв. Энэ нь гэр хороололд амьдарч буй эрэгтэйчүүдийн боловсролын түвшин гэр хорооллын эмэгтэйчүүд болон байшин хорооллын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс доогуур байгааг харуулж байна.



5.1.3 Сургуульд хамрагдалт

Судалгаанд хамрагдсан 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтын түвшинг хүйс, байршлаар Хүснэгт 5.2-д үзүүлэв. Энэ насны бүлгийн эрэгтэйчүүдийн 58.5 хувь, эмэгтэйчүүдийн 61.6 хувь нь ямар нэг шатны сургуульд суралцаж байна. Бүх шатны сургуульд хамрагдалтын түвшин байшин хороололд гэр хорооллынхоос 13-16 пунктээр өндөр байна. “Боловсролын тухай” Монгол улсын хуульд зааснаар сургуульд анх элссэн байвал зохих нас найм боловч 6-7 насандаа сургуульд суралцаж буй охидын (охид 48.3 хувь, хөвгүүд 35.3 хувь) болон байшин хорооллын (байшин хороолол 60.3 хувь, гэр хороолол 32 хувь) хүүхдүүдийн хувь өндөр байна. Өөрөөр хэлбэл, охид болон байшин хорооллынхон харьцангуй эрт сургуульд элсэн орж байна. Найман настай хүүхдүүдийн сургуульд хамрагдалт байшин хороололд 95 хувь, гэр хороололд 93 хувь байна.

Хүснэгт 5.2 Долоогоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалтын түвшин, байршил, хүйс, насны бүлгээр

Насны бүлэг	Байршил				Нийт	
	Гэр хороолол		Байшин хороолол		Эрэгтэй	Эмэгтэй
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй		
7	45.9	51.5	88.9	100.0	60.0	66.7
8-11	94.7	95.6	97.6	98.9	95.8	96.9
12-15	90.8	98.2	99.2	98.5	93.8	98.3
16-17	75.5	79.3	91.0	96.3	81.5	86.5
18-22	34.9	45.7	69.3	65.0	47.0	53.2
23-29	7.6	12.3	18.2	26.0	11.7	17.6
Бүгд	52.8	56.7	68.4	69.5	58.5	61.6

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Ерөнхийдөө 18-наас дээш насныхны сургуульд хамрагдалтын түвшин байшин хороололд өндөр байна. Тухайлбал, 23-29 насныхны сургуульд хамрагдалтын түвшин байшин хороололд гэр хорооллынхоос хоёр дахин өндөр байлаа.


Хүснэгт 5.3 Долоогоос хорин есөн насны сургуульд суралцаж буй хүн амын хувийн жин, сургуульд суралцаж байх хугацаандаа амьдардаг газар, байршлаар

Суралцах хугацаандаа амьдарч буй газар	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Гэртээ	91.0	87.6	89.5
Дотуур байранд*	0.9	2.2	1.5
Хамаатныдаа	7.1	5.7	6.5
Түрээсийн байранд	1.0	4.5	2.5
Бүгд	100.0	100.0	100.0
7-29 насны сургуульд суралцдаг хүн амын тоо	1169	893	2062

Тэмдэглэгээ: * Халамжийн төвд амьдарч буй нэг хүүхдийг энэ ангилалд оруулав.

Өрхийн төсвийн зарцуулалтад өрхийн ам бүлээс гадна бусад хамаатан садны үзүүлж буй нөлөөллийг тодруулах үүднээс суралцагчдын амьдарч буй газрыг асуусан бөгөөд үр дүнг Хүснэгт 5.3-д харуулав. Суралцагчдын 89.5 хувь нь сургуульд суралцаж байх хугацаандаа өөрийн гэртээ амьдардаг бөгөөд гэр хорооллынхны (91 хувь) хувьд энэ үзүүлэлт байшин хорооллынхоос (87.6 хувь) бага зэрэг өндөр байлаа. Суралцаж байх хугацаандаа суралцагчдын 9 хувь нь айлын байр түрээслэдэг, эсвэл байшинд амьдардаг хамаатныдаа амьдардаг гэжээ.

Судалгаанд хамрагдсан 7-18 насны нийт хүүхдийн 4.8 хувь буюу 88 хүүхэд сургууль завсардсаны дийлэнх нь эрэгтэй хүүхдүүд, мөн гэр хороололд амьдардаг хүүхдүүд болохыг Зураг 5.2-аас харж болно.



Бага (1-4-р ангиас 51 хүүхэд буюу 60 хувь), дунд (5-8-р 30 хүүхэд буюу 34 хувь) ангиасаа хүүхдүүд голдуу сургууль завсарджээ. Ар гэрийн гачигдал (26 хувь), эрүүл

Ажил эрхлэлт ба орлого

мэндийн байдал (25 хувь), мөнгөний боломжгүй (13 хувь) зэрэг нь сургууль завсардах үндсэн шалтгаан болсон байна. Гэр хороололд амьдарч буй 8 хүүхэд бүртгэл, бичиг баримтгүйн улмаас сургууль завсардсан байхад байшин хороололд ийм тохиолдол гараагүй байна. Шилжих хөдөлгөөний улмаас өрхүүд оршин суугаа дүүрэг, хороондоо бүртгэлгүй эсвэл эцэг эхийн хайхрамжгүйгээс хүүхдийнхээ гэрчилгээ, хувийн хэргийг хуучин сургуулиас нь шилжүүлж ирдэггүйгээс хүүхдээ сургууль завсардуулахад хүргэдэг байна.

Сургууль завсардсан хүүхдүүдийн ердөө 21 (24 хувь) нь албан бус сургалтад хамрагджээ. Албан бус сургалтад хамрагдалтын түвшин гэр (23.7 хувь) болон байшин (25 хувь) хороололд ойролцоо байна.

5.1.4 Сургалтын төлбөр, түүний хэлбэр

Бүх шатны сургуульд суралцагчдын 42.3 хувь төлбөртэй сургуульд сурч байгаа бөгөөд байршлын хувьд энэ үзүүлэлт нэлээд ялгаатай байв (Хүснэгт 5.4). Байшин хороололд амьдарч буй хүн амын 57 хувь нь, харин гэр хорооллынхны 30.7 хувь нь төлбөртэй суралцаж байна. Сургалтын чанар, анги дүүргэлт, суралцах орчин зэргээс шалтгаалан ерөнхий боловсролын хувийн, эсвэл гүнзгийрүүлсэн сургалттай (улсын сургуульд ч гэсэн тодорхой төлбөр төлдөг) сургуулиадад эцэг эхчүүд хүүхдээ сургах хүсэл, эрмэлзэлтэй байдаг ч боломжийн орлоготой айлын хүүхдүүд л хувийн сургуулиудад сурч байна.

Хүснэгт 5.4 Сургуульд суралцаж буй хүн амын хувийн жин, сургалтандаа төлбөр төлдөг эсэх, байршлаар

	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Сургалтандаа төлбөр төлдөг эсэх			
Төлбөргүй	69.3	43.0	57.7
Төлбөртэй	30.7	57.0	42.3
Бүгд	100.0	100.0	100.0
Сургуульд суралцаж буй нийт хүн амын тоо	1189	931	2120

Монгол Улсын Үндсэн хуулиар бүх нийтийг үнэ төлбөргүй бүрэн дунд боловсрол эзэмшүүлнэ гэж заасан хэдий ч энэ нь амьдрал дээр тэр болгон хэрэгжихгүй байна. Сурагчдын хувцас, шаардлагатай ном, дэвтэр, эрдмийн баяр, ангийн хуримтлал, ангийн засвар зэрэг олон шалтгаанаар сургуулиас мөнгө хураадаг явдал ялангуяа ядуу өрхүүдэд илүү хүнд тусдаг байна.

“Хүүхдүүдийн орлогын ялгааг харуулдаг нэг зүйл бол эрдмийн баяр байдаг. Гайгүй айлын хүүхдүүд нь ахиухан мөнгөөр нийлье гэснээс болж ядуу айлын хүүхдүүд энэ баяртаа ч оролцож чаддаггүй. Тиймээс ядуурал хүүхдийн сэтгэл зүйн болоод сурах сонирхлыг ихээхэн бууруулдаг”

(Т. эмэгтэй, нас 50, багш, СХД)

“Нэг ачийгаа 2-р ангид шилжүүлэх гээд ирэхэд 20000 төрөг татаж, хөдөөнөөс ирсэн хүүхэд сурлага муутай байдаг, хичээлээ гүйцтэл нь давтлага өгнө гэсэн. Хэрэв өгөхгүй бол хүүхдийг чинь 1-р ангид суулгана гээд. Тэгээд

*ямар 20000 төгрөгнөөс болоод 1 жил алдуулалтай биш, тэр мөнгийг нь өгсөн.
Гэтэл одоо болтол манай хүүхдэд нэг ч давтлага өгөөгүй байгаа”
(Б. эмэгтэй, нас 65, тэтгэвэрт, СХД)*

Төлбөртэй суралцагчдын 74.3 хувь нь өрхөөс, 11 хувь нь төрийн сангийн тусламжаар сургалтын төлбөрөө төлсөн байна. Гэр болон байшин хорооллынхны хувьд сургалтын төлбөрийн эх үүсвэр онцын ялгаагүй байна.

5.1.5 Дунд сургуулийн хүртээмж

Тухайн өрхөөс ерөнхий боловсролын сургуулийн алслагдсан байдлыг дүүрэг, байршил, шилжих хөдөлгөөний байдлаар Зураг 5.3-д харууллаа.



Судалгаагаар тухайн өрхөөс хамгийн ойрхон гэж тодорхойлсон ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-иас хоёр ба түүнээс дээш километр байрлаж байгаа өрхөөр авч үзвэл, Налайх дүүргийн өрхүүдийн 35 хувь, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн өрхүүдийн 26 хувь, Чингэлтэй дүүргийн өрхүүдийн 22 хувь нь ийм хол зайд байршиж байна. Эдгээр дүүргүүд нь гэр хороолол ихтэй, хотын захын дүүргүүд юм. Шилжин ирсэн өрхүүд жилээс жилд захын хорооллын хаяаг тэлж байгаагаас гэр хорооллын зарим өрхийн ерөнхий боловсролын сургуульд сурч буй хүүхдүүд хоёроос илүү километр замыг туулж байж сургуульдаа хүрч байна. Энэхүү байдлыг шилжин ирсэн болон гэр хорооллын өрхүүдийн 34 хувь нь хамгийн ойрхон ЕБС-иас хоёр ба түүнээс дээш километр зайд байршиж байгаа явдал давхар нотолж байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн хүүхдүүдийн 73.8 хувь өөрийн харъяа хороонд байрлалтай сургууль, цэцэрлэгт суралцаж байна. Харин үлдсэн 26.2 хувь буюу 439 хүүхэд сургалтын чанар, материаллаг бааз муу (72.1 хувь), анги дүүргэлт их (13.1 хувь), хуучин сургуулиа өөрчлөхийг хүсээгүй (12.1 хувь), бүртгэл, бичиг баримтгүй (9.3 хувь) зэрэг шалтгаануудын улмаас өөр дүүрэг, хороонд байрладаг сургууль, цэцэрлэгт суралцаж байгаа ажээ.

Өөр дүүрэг, хорооны сургууль, цэцэрлэгт суралцаж буй гэр хорооллын хүүхдүүдийн хувьд бүртгэл, бичиг баримтгүй (12.7 хувь), гэр нь сургууль, цэцэрлэгээс хэт хол (7.4 хувь) гэсэн шалтгаанууд байшин хорооллынхноос (харгалзан 4.3 ба 1.8 хувь) өндөр байна. Бүртгэл, бичиг баримтгүй шилжин ирэгсдийн хувьд танил талаараа, эсвэл мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр элдэв сургуульд хандив өгч хүүхдээ сургах, сургуулиас хол учир гэр хорооллынхон хүүхдээ хамаатан садан, танил айлдаа байлгаж сургуульд суралцуулдаг тухай бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байв. Эндээс сургууль, цэцэрлэгийн хүртээмж шилжин ирсэн хүн ам болон гэр хорооллынхонд илүү хүнд тусч байна гэж хэлж болохоор байна.

Хотын ерөнхий боловсролын сургуулиудад анги дүүргэлт өндөр, ялангуяа хотын захын хорооллуудад ерөнхий боловсролын сургууль цөөн байгаа нь сургуулийн ачааллыг ихэсгэж байна. Шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор нэг ангид 25-30 хүүхэд хичээллэх ёстой боловч 45-50 хүүхэдтэй, нэг ширээн дээр гурваараа шахалдан сууж хичээллэж байна. Ийнхүү нэг ангид хэт олон хүүхэд хичээллэх явдал хүүхдийн сурлагын чанарт муугаар нөлөөлөөд зогсохгүй элдэв халдварт өвчин тархах нөхцөлийг нэмэгдүүлж байна.

“Манай сургууль 3 ээлжээр хичээллэдэг учир хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх боломжгүй байдаг. Ачаалал ихтэй байгаа нь сургалтын чанарт маш муугаар нөлөөлж байгаа. Жишээ нь: нэгдүгээр ангийн хүүхдүүдийг тарахад нь багш нар заавал нэмэлт уншлага хийлгээд эцэг эх нь ирж авахад даалгаврыг нь өгөөд явуулдаг байх ёстой. Гэтэл эхний ээлж нь тараад 5 минутын дараа шууд 2-р ээлжийн хичээл ордог. Тиймд хүүхдүүдийг уншуулж амжилгүй тараадаг”.

(Ц. эмэгтэй, нас 35, багш, БЗД)

Ерөнхий боловсролын сургуулийн сайн багш нар цалин харьцангуй өндөр хувийн сургуулиудад багшилж, захын хорооллын сургуулиудад дөнгөж сургууль төгссөн, дадлага багатай, мэдлэг тааруухан багш нар ажилладаг гэж ганцаарчилсан ярилцлагад оролцогчид онцлон тэмдэглэжээ. Цаашилбал, захын хорооллын сургуулиудын барилга муудсан, сургалтын тоног төхөөрөмж гэхээр юм бараг байдаггүй, бие засах өрөөнүүдийн ариун цэвэр маш муу, суралцах нөхцөл нэн хангалтгүй байдаг талаар сургуулийн багш нар, хороодын иргэд ярьж байв.

5.2 Эрүүл мэнд


5.2.1 Эрүүл мэндийн байдал

Эмч, эмнэлгийн ажилтнаар оношлогдон тогтоогдсон архаг, хууч өвчтэй эсэхийг судалгаанд хамрагдагсдаас асууж лавлахад 15.3 хувь (эмэгтэйчүүдийн 16.3 хувь, эрэгтэйчүүдийн 14.2 хувь) “Тийм” гэж хариулжээ. Байшин хороололд оршин суугчид (16.3 хувь), шилжих хөдөлгөөнд оролцоогүй (17.1 хувь), албан бус секторт ажиллаж буй (15.9 хувь) хүн амын дотор архаг хууч өвчтэй гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь өндөр байна. Түүнчлэн насны бүлэг ахих тусам архаг хууч өвчтэй хүмүүсийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Амьжиргааны түвшин буурах тусам эмч, эмнэлгийн ажилтнаар оношлогдсон архаг хууч өвчтэй хүн амын хувийн жин нэмэгдэж байна (Хүснэгт 5.5-ийн харна уу).

5.2.2 Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт

Эрүүл мэндийн даатгал нь (шинжилгээ, эмчилгээ гэхдээ эмийн төлбөр орохгүй) тухайн бүртгэлтэй дүүргийнхээ харьяа эмнэлэг, өрхийн эмчид үзүүлэхэд үйлчилдэг.

Судалгаанд хамрагдагсдын 82 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагджээ. Гэр хорооллын хүн амын 78 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь байшин хорооллынхоос 8 пунктээр бага буюу эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин гэр хорооллынхны дунд доогуур байна (Зураг 5.4).




Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт гэр хорооллынхны дунд бага байгаа нь гэр хорооллын хүн амд албан бус секторын ажил эрхлэлт зонхилж байгаатай нэг талаас холбоотой боловч энэ нь тэдний эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх боломжийг багасгаж байна гэж өрхийн эмч нар ярьж байна.

“Хоногийнхоо хоолыг яая даа гэсэн ядуу хүмүүс, эсвэл чанартай сайн гэсэн эмнэлгээр үйлчлүүлдэг баян хүмүүс эрүүл мэндийн даатгалын хураамж төлдөггүй. Тэр баян хүмүүст даатгалын хэрэг ч байхгүй байлгүй дээ. Өвдлөө гэхэд аль сайн гэсэн хувийн эмнэлэгт очоод мөнгөө төлөөд үзүүлчихнэ. Харин ядуу хүмүүс нь хоногийн хоолгүй хонож байгаа юм чинь олсон хэдэн төгрөгөөрөө хоолоо залгуулъя гэж бодно шүү дээ”

(О, эмэгтэй, нас 41, өрхийн эмч, БЗД)

Эрүүл мэндийн даатгалд даатгуулах талаар иргэд өөрсдөө туйлын хариуцлагагүй ханддаг байна. Иймээс даатгалд нутаг дэвсгэрийнхээ харьяаллын иргэдийг бүрэн хамруулахыг өрхийн эмнэлгүүдээс шаардаж, түүний үр дүнгээс хамааруулан өрхийн эмч нарын цалин хөлсийг хасах зэргээр хариуцлага тооцдог байна. Харин эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулах мэдээлэл, сурталчилгаа хийх төсөв мөнгийг өрхийн эмнэлгүүдэд хуваарилдаггүй ажээ.

Эрүүл мэндийн даатгалтай хүн амын 74 хувийн даатгалын хураамжийг улс болон байгууллага нь төлж байна. Гэр хорооллынхны (76 хувь) хувьд энэ үзүүлэлт байшин хорооллынхоос (72 хувь) арай өндөр байна (Зураг 5.5). Энэ нь хүүхэд болон ахмадуудын эрүүл мэндийн даатгалын хураамжийг төрөөс хариуцаж байгаатай холбоотой байж болох юм. Учир нь гэр хороололд дээрх насны хүн ам харьцангуй олон байгаа билээ (Бүлэг 3, Хүн амын нас, хүйсийн суварга).



Хэдийгээр эрүүл мэндийн даатгалтай бол үнэ төлбөргүй эмчилгээ хийлгэх эрхтэй гэдэг боловч нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх, ЭХО, рентген зураг авахуулах зэрэгт дүүргийн болон улсын клиникийн эмнэлгүүдэд төлбөрийн тогтсон ханш бий болсноос орлого багатай, ядуу иргэд эдгээр эмнэлэгт үзүүлэх, чанартай эмнэлгийн үйлчилгээ авах боломжгүй байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэх нь өрхийн амьжиргааны түвшингээс шууд хамаарч байна. Ядуу өрхийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ядуу бус өрхийнхөөс илт доогуур байна (Хүснэгт 5.5).

Хүснэгт 5.5 Эрүүл мэндийн байдал, амьжиргааны түвшингээр

Сонгосон үзүүлэлтүүд	Амьжиргааны түвшин					Нийт
	<i>Нэн ядуу</i>	<i>Ядуу</i>	<i>Ядуу бус (доод)</i>	<i>Ядуу бус (дунд)</i>	<i>Ядуу бус (дээд)</i>	
Оношлогдсон өвчин						
Байгаа	86.9	85.2	84.1	84.7	83.5	84.7
Байхгүй	13.1	14.8	15.9	15.3	16.5	15.3
Тоо	685	1573	1974	1472	1143	6847
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ЭМ-ийн даатгал						
Даатгалтай	68.6	80.1	83.9	85.8	87.1	82.6
Даатгалгүй	31.4	19.9	16.1	14.2	12.9	17.4
Тоо	678	1172	1971	1472	1143	6842
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Тухайлбал, нэн ядуу өрхийн 31.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байгаа нь ядуу бус доод түвшингийн өрхөөс 2 дахин өндөр байгаа юм.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүн амын шинж байдлыг хавсралт Хүснэгт 5.6-д харуулав. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй эрэгтэйчүүд (20.2 хувь)

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

эмэгтэйчүүдээс (15.1 хувь) олон байна. Энэ нь эрчүүд өөрсдийн эрүүл мэндэд сул анхаардаг, эмнэлгээр тэр бүр үйлчлүүлдэггүйтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт 5.6 Эрүүл мэндийн даатгалгүй хүн амын шинж байдал, байршлаар

Шинж байдал	Бүгд		Гэр		Байшин	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
Хүйс						
Эрэгтэй	24.2	461	13.7	176	20.0	637
Эмэгтэй	18.2	394	10.6	158	15.1	552
Нас						
17 хүртэл	3.9	54	3.7	29	3.8	83
17-25	31.9	288	17.0	96	26.2	384
26-59	33.6	506	17.4	205	26.5	711
60+	2.7	7	1.6	4	2.2	11
Яс, үндэс						
Халх	21.3	745	12.3	303	17.6	1048
Казак	21.3	33	11.8	2	20.3	35
Дөрвөд	15.6	17	15.3	9	15.5	26
Буриад	23.7	9	10.0	7	14.8	16
Баяд	27.9	24	7.1	4	19.7	28
Бусад	18.8	27	13.2	9	17.0	36
Боловсрол (N=1162)						
Огт боловсролгүй	6.1	32	5.4	14	5.9	46
Бага	10.3	66	4.0	13	8.1	79
Бүрэн бус дунд	30.9	250	16.7	47	27.2	297
Бүрэн дунд	32.1	325	19.0	123	27.0	448
Техник мэргэжлийн	34.9	51	22.0	13	31.2	64
Тусгай мэрг. дунд	28.5	61	15.2	30	22.1	91
Дээд	18.8	55	10.4	82	12.7	137
Эдийн засгийн байдал						
Орлого олдог	28.4	327	13.7	139	21.5	466
Орлогогүй	27.9	492	15.3	172	23.0	664
Ажиллаж буй сектор						
Албан сектор	16.0	116	8.1	60	12.0	176
Албан бус сектор	50.9	209	31.3	76	43.6	285
Шилжилтийн байдал						
Шилжигч	24.1	34	35.6	195	33.3	229
Шилжигч бус	15.2	276	28.1	621	22.3	897
Бүгд	21.0	855	12.0	334	17.4	1189


Боловсролын түвшингээр үзвэл техник мэргэжлийн боловсролтой хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх явдал өндөр байна. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөр олон арван техник мэргэжлийн сургууль төгсөгчид ажилгүй болж, албан бус секторт хувиараа ажил эрхлэх болсон билээ. Харамсалтай нь албан бус секторт ажиллагсдын даатгалд хамрагдаагүй байдал (43.6 хувь) албан секторт ажиллагчдынхаас 31.6 пунктээр доогуур байна.

Мөнгөний боломжгүй (32.7 хувь), ажилгүй (24.0 хувь), бүртгэлгүй (18.7 хувь), даатгуулах шаардлагагүй (13.4 хувь), өөрийн санаачилга гаргаагүй (8.5 хувь) зэрэг нь


Ажил эрхлэлт ба орлого

эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа гол шалтгаан болж байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд дээрх шалтгаан ижил байв. Харин казак үндэстнүүдийн хувьд орлого бага, мөнгөний боломж хомс байгаагаас эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байна гэсэн хариултын хувь бусад ястан, үндэстнээс өндөр байсан юм.

Эмнэлгийн үйлчилгээний хангамжийг өрхийн эмнэлэг тухайн өрхөөс хэр алслагдмал байгаагаар төлөөлүүлэн авч үзлээ. Өрхийн эмнэлэг нь тухайн өрхөөс 3 ба түүнээс дээш километр байршиж байгаа өрхүүдийн эзлэх хувийн жин Баянзүрх дүүрэгт (19 хувь) хамгийн өндөр байгааг Зураг 5.6-гаас харж болно.



Шилжигч өрхийг шилжигч бус өрхтэй харьцуулахад өрхийн эмнэлгээс алслагдмал байдал нэлээд ялгаатай байв. Тухайлбал, шилжигч өрхийн 28 хувь нь өрхийн эмнэлгээсээ 3-аас дээш километр алслагдсан байхад шилжигч бус өрхийн хувьд энэ үзүүлэлт ердөө 10 хувьтай байна.



Өрхийн эмнэлэгт үзүүлж, мэргэжлийн зөвлөгөө, тусламж авах боломж байшин хорооллын оршин суугчид (96 хувь) болон шилжигч бус хүн амд (95 хувь) илүү давуу байна (Зураг 5.7). Харин шилжигч хүн амын 78 хувь нь эмнэлгийн ийм үйлчилгээг авах боломжтой гэжээ.

Өрхийн эмч нарын (ялангуяа гэр хорооллын) ачаалал ихтэйгээс тэр бүр айлуудаар явж өвчтөнгүүдээ үзэх боломжгүй байна. Зарим иргэд өрхийн эмнэлэгт үзүүлэхийн тулд автобусаар хол явж хүрдэг учир ахмад настан болон ядуу иргэд автобусны мөнгө төлөөд өрхийн эмнэлэгт үзүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байдаг байна.

“Өрхийн эмнэлэг нь их хол, над шиг хөгшин хүн тийшээ автобусанд суугаад очихоор мөнгө нэхээд салахгүй, алхаад очих гэхээр хөл өвдөөд байдаг. Жаахан ойрхон байлгаж болоогүй юм байх даа”

(Б. эмэгтэй, нас 65, тэтгэвэрт, СХД)

Гэр хорооллын өрхийн 83 хувь, харин байшин хорооллын 56 хувь нь эрүүл мэндийн зөвлөгөө, тусламжийг өрхийн эмчээс голдуу авдаг байна. Хотын хүн амын эрчимтэй өсөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн үйлчилгээ тэр бүр жигд хүртээмжтэй байж чадахгүй байна.

“Дүүргийн эмнэлэг 1983 онд анх 300 гаруй ортой байгуулагдсан. Орны хүрэлцээ муу хэвтэж эмчлүүлэх шаардлагатай хүмүүсийг хэвтүүлмээр байвч доод тал нь долоо хонож байж хэвтдэг”

(И. эмэгтэй, нас 50, өрхийн эмч, БЗД)

Нэн ядуу өрхийн 16.2 хувь, ядуу өрхийн 9 хувь нь өрхийн эмнэлэгт үзүүлж, мэргэжлийн зөвлөгөө, тусламж авах боломжгүй байхад ядуу бус өрхийн 4-6 хувь нь л боломжгүй гэжээ (Хүснэгт 5.7). Эмнэлэгт үзүүлэхэд наад захын ариун цэвэр хангасан, тухайлбал усанд орж, цэвэр хувцасласан байх шаардлагатай билээ. Гэтэл нэн ядуу хүмүүст ийм боломж байдаггүйгээс тэд ичиж, зовоод эмнэлэгт тэр бүр хандаж чаддаггүй гэж өрхийн эмч нар ярьж байна.

Хүснэгт 5.7 Хүн амын хувийн жин, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломжтой эсэх, амьжиргааны түвшингээр

Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломж	Амьжиргааны түвшин					Нийт
	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус (бага)	Ядуу бус (дунд)	Ядуу бус (дээд)	
	Мэргэжлийн зөвлөгөө авах боломжтой эсэх					
Боломжтой	83.8	91.0	95.0	93.6	95.7	92.8
Боломжгүй	16.2	9.0	5.0	6.4	4.3	7.2
Өрхийн эмнэлгээс алслагдсан зай						
3 км дотор	86.7	84.7	90.0	89.9	85.7	87.7
3 км-ээс дээш	13.3	15.3	10.0	10.1	14.3	12.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Нийт хүн амын тоо	685	1573	1974	1472	1143	6847

5.2.3 Нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ

Эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд нийгмийн халамжийн сангаас авдаг тэтгэвэр, тэтгэмж нь тэдний амьжиргааны гол эх үүсвэр болдог байгаа талаар Бүлэг 4-д өгүүлсэн билээ. Ганц хоёр хүний тэтгэвэр, тэтгэмжээр амьдралаа залгуулдаг айл өрхүүд цөөнгүй байдаг атал өндөр насны тэтгэврийн зөрүү маш их ялгаатай байгаад зарим өндөр настангууд ихээхэн эмзэглэж байна.

“Тэтгэврийн зөрөөг арилгах хэрэгтэй. Би улсад 37 жил ажилласан хэрнээ 20000 төгрөгийн тэтгэвэр авдаг. 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг өндөр тогтоосон байна лээ. Хэрвээ би 1995 оноос хойш тэтгэвэрээ тогтоолгосон бол 50.000 орчим төгрөгний тэтгэвэр авах байсан”

(Шилжин ирсэн бүртгэлтэй иргэдийн бүлгийн ярилцлагаас)

Нийгмийн халамжийн үйлчилгээ эмзэг бүлгийн зарим хүмүүст хүрч чадахгүй байна. Нийгмийн халамжийн хууль, тогтоомжоор эмзэг бүлгийн гэр хороололд амьдардаг иргэдэд түлээ нүүрс, харин байшин хороололд амьдардаг иргэдэд байрны мөнгөнд хөнгөлөлт үзүүлэх заалттай атал ахуй нөхцөл нь гэр хорооллынхонтой ижилхэн байшинд амьдардаг айлуудад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэхгүй байгаа тухай иргэд шүүмжилж байв.

“Манай хороог байшин хороо гээд халамжийн хуулиар олгогдог түлээ нүүрсийг өгдөггүй. Гэтэл яг үнэндээ манай хорооны гурван бранк байранд амьдардаг иргэд халаалт байхгүй, яг гэр хорооллын нөхцөлд амьдардаг”

(Д. эмэгтэй, нас 53, хороон Засаг дарга, СХД)

5.2.4 Эрүүл аж төрөх орчин ахуй

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын даац хэтэрч хүн ам олноор суурьших болсноор байгаль экологи болон ахуйн нөхцлийн хувьд олон сөрөг нөлөөлөл гарч ирэх боллоо. Бүлгийн ярилцлагад оролцогсдын дийлэнх нь хотын агаарын бохирдол, хог хаягдал, эмх замбараагүй байшин, барилга, хашаа, үерийн усны хамгаалалт зэрэг хүрээлэн байгаа орчны сөрөг үзэгдлүүдэд сэтгэл зовниж байлаа. Гэр хороолол болон захын байшин хорооллын иргэдийн хамгийн тулгамдаж байгаа нэг асуудал бол агаарын бохирдол гэдэгтэй бүгд санал нийлж байв. Агаарын бохирдол нь нийслэлийн хүн амын эрүүл мэндэд маш муугаар нөлөөлж, цаашилбал хүний аюулгүй амьдрах эрхийн асуудал болоод байна.

“Гэр хорооллын хувьд агаарын бохирдол үнэхээр хэцүү. Орой гараад дэлгүүр орох хооронд үсэнд утааны үнэр дүүрэн шингэчихдэг. Өглөө эрт бол манан татсан юм шиг бүрэлзээд юм ч сайн харагдахгүй байдаг. Амьсгалж болохгүй маш төвөгтэй”

(Шилжиж ирсэн бүртгэлгүй иргэлийн бүлгийн ярилцлагаас)

Үйлдвэрийн хог хаягдал, үйл ажиллагааны нөлөө иргэдийн амар тайван амьдрал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Улаанбаатар хотод байрладаг үйлдвэрүүд ихэвчлэн хүн ам олноор суудаг бүсэд байдаг болохоор оршин суугчдын тав тух, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Тодруулбал, дулааны цахилгаан станцын дуу, чимээ, үнс утаа, арьс ширний үйлдвэрийн үнэр, бохир ус зэргийг нэрлэж болох юм.

“Баруун тийшээ орбитод цэвэрлэх байгууламж байдаг болохоор баруун талаас салхилахад өмхий үнэртдэг. Бас ойрхон дулааны цахилгаан станц байдаг, аймаар чанга дуугардаг. Заримдаа нэг өрөөнд байгаа бид хоорондоо хашигирч ярьдаг. Ер нь цахилгаан станцыг шөнө дуугарахыг болиулаад өдөр дуугардаг болговол таарна. Үнэхээр хүний эрх зөрчсөн хэрэг болж байдаг. Ажиллаж, ажиллаж гэртээ амрахаар очиход шөнөжин дуугараад унтуулдаггүй”

(Э. эмэгтэй, нас 29, нийгмийн ажилтан, СХД)

Гэр хорооллын иргэдийн усан хангамж харьцангуй муу байгаа нь тэднийг байнга бухимдуулж байна. Зарим үед нэгээс хоёр цаг дугаарлаж байж ус авдаг. Заримдаа дугаарт зогсож байхад ус нь дуусчихдаг. Усгүй хонох тохиолдол байнга гардаг ажээ.

Ил задгай хог хаягдал, гудамж талбай, хүрээлэн буй орчин, ахуй нөхцлийг бохирдуулж байна. Ялангуяа, хотын захын гэр хороололд хог хаягдлын асуудал нэн хурцадмал байна. Иргэдийн өөрсдийн ухамсар сул байгаад иргэд, олон нийт, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд нэлээд шүүмжлэлтэй хандаж байлаа.

Дүгнэлт

Гэр хороололд оршин суугчдын, гэр дундаа эрэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй доогуур байгаа нь анхаарал татаж байна. Сургуульд хамрагдалтын түвшин байшин хороололд гэр хорооллынхоос хавьгүй өндөр, охидын сургуульд элсэн орох нас хөвгүүдийнхээс эрт байна. Залуучуудын (23-29 настай) сургуульд хамрагдалт гэр хорооллынхны хувьд байшин хорооллынхоос хоёр дахин доогуур байна. Төлбөртэй, чанартай сургуулиудад хүүхдээ сургах боломж гэр хорооллынхонд бага байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцахтай холбоотой зардлууд ядуу өрхийн хүүхдэд маш хүндээр тусч байгаа төдийгүй зарим өрхийн хүүхдүүдийн сургууль завсардах үндсэн шалтгаан болжээ.

Хотын хүн амын эрчимтэй өсөлтийг дагасан нийгмийн салбарын хөрөнгө оруулалт ялангуяа гэр хорооллын хүн амд маш бага хийгдэж байна. Тухайлбал, хотын захын гэр хороололд шилжин ирсэн өрхүүдийн хүүхдүүдийн 1/3 нь хоёроос илүү километр зайг туулж байж сургуульдаа хүрч байна. Өвлийн хүйтэн улиралд ялангуяа, бага ангийн сурагчдад энэ нь нэлээд хүнд нөхцөл юм. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж шилжигч болон гэр хорооллын хүн амд тааруу байна. Сургалтын чанар, материаллаг бааз муу, анги дүүргэлт хэтэрснээс өрхүүд хүүхдээ өөрийн харъяа дүүрэг, хороодын сургуульд суралцуулж чадахгүй байна.

Шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор нэг анги ердийн нормоосоо хоёр дахин илүү ачаалалтайгаар сургалтаа явуулж байна. Гэр хорооллын эрэгтэй хүүхдүүд илүү сургууль завсардаж байна. Сургууль завсардалтад өрхийн эдийн засгийн хүнд нөхцлөөс гадна сургуулийн шилжүүлгийг нь орон нутгаас хийлгэлгүй ирдэг эцэг, эхийн хайхрамжгүй байдал ч нөлөөлж байна. Сургууль завсардалттай тэмцэх олон арван төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа ч сургууль завсардсан хүүхдийн ердөө 1/5 нь албан бус сургалтад хамрагджээ.

Хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин (ялангуяа, албан бус секторт ажиллагсад, гэр хорооллынхон болон эрэгтэйчүүдийн хувьд) хангалтгүй байна. Цаашилбал, эмнэлгийн нарийн мэргэжлийн үйлчилгээнд улсын эмнэлгүүд хувийн эмнэлгийн нэгэн адил ханшаар төлбөр тогтоосон нь өдрийнхөө хоолыг арай ядан

Ажил эрхлэлт ба орлого

залгуулж буй хүн амд, тэр дундаа ядуу бүлгийнхэнд эмнэлгийн үйлчилгээнээс хүртэх боломжийг бүрмөсөн хязгаарласан гэхэд хилсдэхээргүй байна.

Шилжигчдийн эмнэлгийн үйлчилгээ хүртэх боломж тааруу байгаагаас гадна 1/3 нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, харин даатгалд хамрагдсан хүмүүсийн талаас илүү хувь нь даатгалын хураамжаа хувиараа төлдөг ажээ. Гэхдээ шилжигчдийн эрүүл мэндийн байдал шилжигч бус хүн амынхаас арай дээр байна. Үүнийг шилжих хөдөлгөөнд харьцангуй эрүүл мэнд сайтай хүмүүс орох магадлал өндөр байдагтай холбон тайлбарлаж болох боловч уугуул нутагтаа эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдах боломж муугаас шилжигчид өөрсдийнхөө эрүүл мэндийг тодорхойлуулж чадаагүй байж болох юм.

Гэр хороололд амьдарч буй шилжигч өрхүүдийн 28 хувь өрхийн эмнэлгээс 3 ба түүнээс дээш километр зайд алс байрлаж байгаагаас эмнэлгийн үйлчилгээ, ялангуяа өрхийн эмнэлгийн үйлчилгээг жинхэнэ утгаар нь хүртэх боломжгүй байна. Түүнчлэн өрхийн эмчийн, ялангуяа гэр хорооллын өрхийн эмчийн ачаалал их байгаа нь эмнэлгийн үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

БҮЛЭГ 6. МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ БА НИЙГМИЙН КАПИТАЛ

Бүлэг 6-д Улаанбатар хотын хүнамын мэдээллийн хүртээмж, нийгмийн капиталын асуудлыг хөндсөн. Энэхүү бүлэгт өрхийн орлого нэмэгдүүлэх, амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийн талаарх хотын иргэдийн мэдлэг, мэдээлэл, тэдгээрийн үр шимээс хүртэж буй байдал болон олон нийтийн ажилд оролцох иргэдийн оролцоог авч үзэх болно. Түүнчлэн өрхийн амьжиргаанд нөлөөлж буй төрөл садан, найз нөхөд, танил хүрээллүүдийн хоорондын харилцаа, холбоо буюу сүлжээний талаар тодорхой мэдээллийг хүргэх юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэхэд нийгмийн нөөц, бололцоо ямар байна вэ гэдгийг тодруулах болно.

Түлхүүр асуултууд

- Хотын иргэдийн дунд төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, хүртээмж ямар байна вэ?
- Хотын иргэдийн нийгмийн оролцоо ямар байна вэ?
- "Нийгмийн сүлжээ" хүн амын бүлгүүдэд ямар байна вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төр, засгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн талаар өрхүүдийн талаас илүү хувь нь мэдээлэл авсан боловч 1/10 хүрэхгүй хувь нь л төслийн үр шимээс хүртжээ.
- Нийслэлийн өрхүүдийн бараг тал хувь нь нийгмийн оролцооны идэвх сул аж төрж байна.
- Ялангуяа, орлого өндөртэй өрхүүдийн олон нийтийн ажилд оролцох оролцоо хамгийн доогуур байна.
- Амьжиргаагаа дээшлүүлэхэд ард иргэдийн өөрсдийн идэвх, оролцоо хангалтгүй байна. Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамрагдсан өрхүүдийн хувь амьжиргааны түвшингээр онцын ялгаагүй байгаа ч сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан нэн ядуу өрхийн хувь чинээлэг өрхийнхөөс бараг гурав дахин бага байна.
- Өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхэн өрхийн амьжиргаанд тус дэм үзүүлж байна. Гэвч шилжигч, гэр хороололд амьдарч буй, ядуу, нэн ядуу өрхүүдийн амьдралд туслахуйц хүрээллийнхэн харьцангуй хязгаарлагдмал байна.

6.1. Нийгмийн оролцоо

6.1.1 Төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл ба хүртээмж

Сүүлийн жилүүдэд хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олон тооны хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлж байгаа билээ. Эдгээр хөтөлбөр, төслүүдийн талаар Улаанбаатар хотын өрхүүд ямар мэдлэг, мэдээлэлтэй байдгийг тодруулах зорилго бүхий асуултуудыг судалгаанд оруулсан бөгөөд үр дүнг Хүснэгт 6.1-д харуулав.

Амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаанд хамрагдсан нийт өрхийн гуравны хоёр нь ямар нэг байдлаар мэдээлэл авчээ. Нэг өрх дунджаар 2 хөтөлбөр, төсөл мэдэж байгаа ба давхардсан тоогоор өрхүүдийн 1/3 орчим нь томоохон хөтөлбөр, төслүүдийг мэдэж байв.

Мэдлэг, мэдээлэл ба нийгмийн капитал

Тэдгээрээс Ногоон хувьсгал хөтөлбөрийн талаарх мэдлэг хамгийн өндөр буюу бусад хөтөлбөр, төслүүдээс бараг хоёр дахин (60.2 хувь) илүү хувьтай байв. Харин өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдлэг хамгийн бага (27.4 хувь) хувьтай байна.

Дүүргүүдээр үзвэл, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн өрхүүд хөтөлбөр, төсөл хэрэгжиж байгаа талаар бусдаас өндөр мэдлэгтэй, Баянзүрх, Налайх дүүргийн өрхүүд бага мэдлэгтэй байв. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт нэг өрх дунджаар 1.8 хөтөлбөр, төсөл мэдэж байсан нь нийслэлийн дунджаас 1.3 дахин доогуур байхад, Хан-Уул дүүргийнхний мэдлэг (дунджаар 3.1) нийслэлийн дунджаас 1.3 дахин өндөр байлаа. Ямар ч төсөл, хөтөлбөр мэдэхгүй өрхийн хувь Баянзүрх дүүрэгт хамгийн өндөр (40.5 хувь), Хан-Уул дүүрэгт хамгийн бага (20.0 хувь) байна.

Хүснэгт 6.1. Өрхүүдийн хувь, хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий хөтөлбөр, төслүүдийн талаар мэдээлэл авсан байдал, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлт	<i>Мэдэж буй хөтөлбөр, төсөл</i>							Мэдэхгүй	Мэдэж буй хөтөлбөр/төслүүдийн дундаж тоо	Нийт өрхийн тоо
	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих	Ногоон хувьсгал	Цагаан хувьсгал	Малжуулах төсөл	Хадгаламж, зээлийн төсөл	Ажил эрхлэлтийг дэмжих	Бусад*			
Дүүрэг										
Баянзүрх	16.5	52.0	30.5	27.5	30.5	20.0	2.5	40.5	1.8	200
Налайх	21.0	62.0	25.0	33.0	40.0	33.3	7.0	30.0	2.2	100
Сүхбаатар	33.1	63.1	37.4	40.5	44.5	37.1	2.8	28.0	2.6	350
Сонгинохайрхан	27.8	60.6	34.4	38.2	37.6	30.2	3.2	30.6	2.3	500
Хан-Уул	45.0	72.0	34.0	56.0	53.0	47.0	1.0	20.0	3.1	100
Чингэлтэй	22.8	56.4	33.6	34.0	34.4	28.0	1.2	33.6	2.1	250
Байршил										
Гэр хороолол	25.6	57.7	29.9	33.8	34.1	26.8	3.2	33.1	2.1	816
Байшин хороолол	29.5	63.2	38.3	41.8	44.7	36.8	2.3	28.6	2.6	684
Амьжиргааны түвшин										
Нэн ядуу	15.1	36.8	15.1	21.7	18.9	20.7	4.7	50.0	1.3	106
Ядуу	21.9	53.8	26.5	28.7	26.2	18.3	3.9	37.6	1.8	279

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Ядуу бус (бага)	60.	32.	35.	39.						
	27.6	7	6	1	1	29.1	2.5	30.1	2.3	402
Ядуу бус (дунд)	62.	34.	40.	38.						
	28.7	6	4	2	2	32.5	1.4	31.1	2.4	366
Ядуу бус (чинээлэг)	69.	45.	49.	55.						
	34.0	4	8	3	6	46.1	3.2	21.0	3.0	347
Шилжилтийн байдал										
Шилжигч	55.	31.	42.	32.						
	27.8	7	2	0	9	30.1	1.1	33.5	2.2	176**
Шилжигч бус	61.	31.	36.	40.						
	30.7	4	6	7	8	33.0	3.2	29.8	2.4	1139**
Бүгд	60.	33.	37.	38.						
	27.4	2	7	5	9	31.4	2.8	31.1	2.3	1500

Тэмдэглэгээ: * "Тогтвортой амьжиргаа", "Гэр", Дэлхийн зөн болон бусад олон улсын байгууллагаас

хэрэгжүүлж буй жижиг төслүүд

** Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Байршлаар үзвэл, хөтөлбөр, төслүүдийн талаар мэдээлэл авсан байдал гэр хороололд амьдарч байгаа өрхүүдийн хувьд (25.6-57.7хувь) байшин хорооллынхоос (29.5-63.2 хувь) бага байна.

Өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл авсан байдал нэмэгдэж байна. Тухайлбал, эдгээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа талаар нэн ядуу өрхүүдийн тал хувь нь мэдээлэлтэй байхад, чинээлэг өрхүүдийн 80 хувь нь мэдээлэлтэй байна. Мөн нэн ядуу нэг өрхийн мэдэж буй хөтөлбөр, төслийн дундаж тоо (1.3) чинээлэг өрхийнхөөс 2 дахин бага байлаа.

Шилжигч өрхийн хөтөлбөр, төслүүдийн талаарх мэдээлэл авсан хувь шилжигч бус өрхийнхөөс бага боловч малжуулах төслийн талаар мэдээлэл авсан байдал нь өндөр байна. Үүнийг малжуулах төсөл зөвхөн хөдөө, орон нутагт төвлөрөн хэрэгждэгтэй холбон тайлбарлаж болох юм.

Өөр нэг сонирхол татаж буй үр дүн бол бусад жижиг төслүүдийн талаарх мэдлэг гэр хорооллын (3.2 хувь), хотын төвөөс алслагдсан Налайх дүүргийн (7.0 хувь), нэн ядуу (4.7 хувь), ядуу өрхүүд (3.9 хувь)-ийн дунд бусдаас өндөр хувьтай байгаа явдал юм. Эндээс, жижиг төсөл, хөтөлбөрүүд томоохон төсөл, хөтөлбөрүүдээс илүүтэйгээр дээрх өрхүүдэд хүрч байна гэсэн дүгнэлтийг хэлж болох юм.

Өрхүүдийн хөтөлбөр, төслүүдийн талаарх мэдлэгийг өндөр хувь эзэлж байгаа байдлаар нь дараалуулбал, *нэгдүгээрт*, ногоон хувьсгал (60.2 хувь), *хоёрдугаарт*, хадгаламж, зээл төсөл (38.9 хувь), *гуравдугаарт*, малжуулах төслүүд (37.5 хувь) орж байна. Харин өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих, ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг бүх бүлгүүдийн хувьд харьцангуй доогуур байна. Энэ нь уг төслүүдийн сурталчилгаа нийслэлд тодорхой сонгосон дүүрэг, хороонд явагдсантай холбоотой байж болох юм.

Мэдлэг, мэдээлэл ба нийгмийн капитал

Өрхүүдийн хөтөлбөр, төслүүдийн үр шимээс хүртсэн байдлыг авч үзвэл (Хүснэгт 6.2), дийлэнх буюу 91 хувь нь ямар ч үр шим хүртээгүй гэжээ. Ийм өрхүүдийн хувийн жин хотын төвийн гэгдэх Чингэлтэй (93.6 хувь), Сүхбаатар (93.4 хувь) дүүргүүдэд бусад дүүргээс (80-92 хувь) өндөр, байшин хороололд гэр хорооллоос өндөр байна. Ялангуяа хотын захын байшин хороололд амьдарч буй өрхүүд төсөл, хөтөлбөрт хамрагдахгүй орхигдох явдал их байдаг тухай бүлгийн ярилцлагад оролцогчид ярьж байлаа.

“... Манай хороонд ядуурал харьцангуй өндөр түвшинтэй. Гэр хорооллуудтай харьцуулахад арай гайгүй ч байшин хорооллуудаас хамаагүй өндөр байдаг. Гэтэл хүн амын амьжиргааг дэмжсэн аливаа төсөл, хөтөлбөрүүд дандаа гэр хорооллынхонд чиглэсэн байдаг. Манайх ядуу өрх олонтой ч тэр бүр төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжгүй яг завсрын хороо болчихоод байна”

(Д, эмэгтэй, нас 53, хорооны Засаг дарга, СХД)

Ямар нэгэн хөтөлбөр, төслөөс үр шим хүртээгүй гэж шилжигч өрхийн 93.8 хувь хариулсан бөгөөд энэ нь шилжигч бус өрхийнхөөс 3.5 пунктээр өндөр байна. Ерөнхийдөө төсөл, хөтөлбөрүүд хороодоор дамжин өрхөд хүрдэг тул бүртгэлгүй, эсвэл шинээр шилжин ирсэн өрхүүд суурин өрхтэй харьцуулахад тэр бүр хамрагдах боломж бага байж болох талтай.

Улаанбаатарт Ногоон хувьсгал хөтөлбөрийн үр шимээс хүртсэн өрх харьцангуй (4.7 хувь) олон байна. Үүний дараагаар хадгаламж, зээлийн төслөөс үр шим хүртсэн өрх (2.9 хувь) орж байгаа юм. Харин өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих, ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдээс үр шим хүртсэн өрх нэг хүрэхгүй хувийг эзэлж байна.

Хүснэгт 6.2. Өрхүүдийн хувь, хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий төсөл, хөтөлбөрүүдийн үр шимээс хүртсэн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлт	Үр шимийг нь хүртсэн хөтөлбөр/төсөл					Үр шим хүртээгүй	Нийт өрхийн тоо
	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих	Ногоон хувьсгал	Хадгаламж зээлийн төсөл	Ажил эрхлэлтийг дэмжих	Бусад*		
Дүүрэг							
Баянзүрх	1.5	5.0	3.5	0.0	1.0	89.0	200
Налайх	2.0	8.0	5.0	1.0	8.0	80.0	100
Сүхбаатар	0.3	3.4	2.9	0.3	0.0	93.4	350
Сонгинохайрхан	0.8	4.4	2.0	0.8	2.0	91.0	500
Хан-Уул	1.0	3.0	5.0	0.0	1.0	92.0	100
Чингэлтэй	1.2	2.4	2.4	1.6	0.4	93.6	250
Байршил							
Гэр хороолол	0.7	5.8	2.5	0.6	2.3	90.6	816
Байшин хороолол	1.2	3.4	3.4	0.7	0.4	91.7	684
Амьжиргааны түвшин							
Нэн ядуу	1.9	1.9	0.9	0.0	4.7	90.6	106
Ядуу	0.7	3.9	1.8	0.7	3.2	91.4	279
Ядуу бус (бага)	0.2	4.5	3.2	0.5	1.5	91.0	402
Ядуу бус (дунд)	1.4	3.3	2.5	1.1	0.5	92.3	366
Ядуу бус (чинээлэг)	1.2	5.2	4.6	0.6	0.0	89.6	347

Шилжилтийн байдал

Шилжигч	1.0	2.8	2.8	0.0	0.1	93.8	176**
Шилжигч бус							1139*
	1.7	4.0	3.4	0.7	1.7	90.3	*
Бүгд	0.9	4.7	2.9	0.7	1.5	91.1	1500

Тэмдэглэгээ: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн дунд Цагаан хувьсгал, Малжуулах төслүүдийн үр шимээс хүртсэн өрх байхгүй.

* "Тогтвортой амьжиргаа", "Гэр", Дэлхийн зөн, бусад олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй жижиг төслүүд

** Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Гэтэл эдгээр төсөл, хөтөлбөрт хамрагдахыг хүсч буй айл өрх, ард, иргэд харьцангуй олон байдгийг чанарын судалгааны үр дүн баталж байгаа юм.

“... Ажил олоход үнэхээр бэрхшээлтэй. Мэргэжил, боловсрол гээд гайгүй ажилд орох боломж байхгүй. Олдсон ажлыг нь хийе гэхээр эндээс хотын төв рүү автобусны мөнгөө өгсөөр байтал цалин маань дуусна шүү дээ. Тэгснээс хэдэн хүүхдүүдийнхээ хоолыг хийгээд л байж байсан нь хамаагүй дээр гэж боддог. Ажлын байр л хэрэгтэй байна”

(Ж, эмэгтэй, нас 43, ажилгүй, СХД)

Байшин хороололд амьдардаг, шилжигч бус өрхүүд ногоон хувьсгалаас бусад томоохон хөтөлбөр, төслүүдийн үр шимийг илүүтэй хүртэж байна. Харин Ногоон хувьсгал хөтөлбөрийн үр шимийг ядуурал өндөртэй, хотын захын Налайх (8.0 хувь), Баянзүрх (5.0 хувь), Сонгинохайрхан (4.4 хувь) дүүргүүд, гэр хорооллынхон (5.8 хувь), мөн шилжигч бус өрхүүд (4.0 хувь) илүү хүртэж байгаа ажээ.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг, тэдгээрийн үр шимийг хүртсэн байдлыг өрхийн амьжиргааны түвшингээр харьцуулан Зураг 6.1-д үзүүлэв.



Зургаас харахад, аль ч бүлгийн өрхүүдийн талаас илүү хувь төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар мэдээлэлтэй байгаа боловч тэдгээрийн үр шимийг хүртэгсэд харьцангуй бага (10-аас бага хувь) байна. Хөтөлбөр, төслийн хүртээмж ерөнхийдөө жигд бага байгаа хэдий ч нэн ядуу (9.4 хувь) болон чинээлэг бүлгийнхэн (10.4 хувь) бусдаасаа арай илүү, дундаж түвшингийн амьжиргаатай өрхүүд (ядуу бус (дунд) өрхүүд 7.7%) хамгийн бага хамрагджээ.

6.1.2 Иргэдийн олон нийтийн оролцоо⁴

Хүний амьдралын чанарын асуудал нь өрх, гэр бүл, хувь хүмүүсийн орлого төдийгүй нийгмийн амьдралд оролцох оролцоотой тодорхой хэмжээгээр холбоотой байдаг. Иймээс судалгаагаар өрхийн нийгмийн оролцоонд "ядуурал" байгаа эсэхийг тодруулах зорилго бүхий зарим асуултуудаар мэдээлэл цуглуулсан юм.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 55.7 хувь нь дүүрэг/хорооноосоо зохион байгуулж буй олон нийтийн ажилд оролцдог гэжээ (Хүснэгт 6.3). Энэ үзүүлэлтийг нөгөө талаас нь харвал, нийслэлийн өрхүүдийн бараг тал хувь нь нийгмийн оролцооны идэвх сул аж төрдөг гэж болохоор байна.

Энэхүү оролцоог өрхийн шинж байдлаар судлан үзвэл, гэр болон байшин хороололд амьдардаг өрхүүдийн талаас илүү хувь нь олон нийтийн ажилд оролцдог бөгөөд байршлын хувьд төдийлөн ялгаа байхгүй (харгалзан 55.5 хувь ба 55.8 хувь) байна. Харин шилжигч өрхүүдийн хувьд энэ үзүүлэлт (32.4 хувь) шилжигч бус өрхөөс 25 пунктээр доогуур байлаа. Оршин сууж буй хороондоо бүртгэлтэй өрхүүдийн олон нийтийн ажилд оролцох оролцоо (58.8 хувь) бүртгэлгүй өрхөөс бараг хоёр дахин өндөр байв.

Хүснэгт 6.3. Өрхүүдийн хувийн жин, дүүрэг/хорооноос зохион байгуулдаг олон нийтийн ажилд оролцдог эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Дүүрэг/хорооноос зохион байгуулдаг олон нийтийг хамарсан ажилд оролцдог эсэх		Бүгд	Нийт өрхийн тоо
	Тийм	Үгүй		
Байршил				
Гэр хороолол	55.5	44.5	100.0	816
Байшин хороолол	55.8	44.2	100.0	684
Шилжилтийн байдал				
Шилжигч	32.4	67.6	100.0	176*
Шилжигч бус	57.0	43.0	100.0	1139*
Хороондоо бүртгэлтэй эсэх				
Бүртгэлтэй	58.8	41.2	100.0	1356
Бүртгэлгүй	25.7	74.3	100.0	144
Өрхөд амьдарч буй хүний тоо				
1-2	46.9	53.1	100.0	179
3-5	54.9	45.1	100.0	951
6 ба түүнээс дээш	61.9	38.1	100.0	370
Амьжиргааны түвшин				

⁴ Хорооноос зохион байгуулж буй хурал, нийтийн цэвэрлэгээ, сурталчиганы ажил гэх мэт

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Нэн ядуу	60.4	39.6	100.0	106
Ядуу	57.7	42.3	100.0	279
Ядуу бус (бага орлоготой)	60.4	39.6	100.0	402
Ядуу бус (дунд орлоготой)	54.9	45.1	100.0	366
Ядуу бус (чинээлэг)	47.8	52.2	100.0	347
Өрхийн тэргүүний хүйс				
Эрэгтэй	55.9	44.1	100.0	1144
Эмэгтэй	55.1	44.9	100.0	356
Өрхийн тэргүүний нас				
35 хүртэлх	36.3	63.7	100.0	355
35-44	56.6	43.4	100.0	417
45-54	56.6	43.4	100.0	364
55-64	75.4	24.6	100.0	179
65, түүнээс дээш	69.7	30.3	100.0	185
Нийт	55.7	44.3	100.0	1500

Тэмдэглэгээ: * - Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Нэг өрхөд амьдарч буй өрхийн гишүүдийн тоо нэмэгдэх тутам тухайн өрхийн олон нийтийн ажилд оролцох оролцоо нэмэгдэж байна. Түүнчлэн өрхийн тэргүүний нас нь залуу байх тусам өрхийн олон нийтийн ажилд оролцох оролцоо бага байгаа юм. Тухайлбал, 35 хүртэлх насны тэргүүлэгчтэй өрхийн хувьд дээрх үзүүлэлт 36.3 хувь байхад 65, түүнээс дээш настай тэргүүлэгчтэй өрхийн хувьд 70 орчим хувь байна. Харин өрхийн тэргүүний хүйсээр задлан үзэхэд гойд ялгаа байхгүй байв. Эдгээрээс дүгнэвэл, харьцангуй цөөн гишүүдтэй, залуу өрх, гэр бүлүүд бусдаасаа олон нийтийн ажилд оролцох оролцоогоор бага байна.

Амьжиргааны түвшнээр үзвэл, өрхийн амьжиргаа дээшлэх тусам олон нийтийн ажилд оролцох оролцоо нь багасч байна. Тухайлбал, дүүрэг, хорооноос явуулдаг олон нийтийн ажилд оролцдог гэж нэн ядуу өрхүүдийн 60.4 хувь, ядуу өрхүүдийн 57.7 хувь хариулсан байхад чинээлэг өрхүүдийн тал хүрэхгүй хувь (47.8%) нь ийм хариултыг өгчээ. Үүнийг бага орлоготой өрхүүд дүүрэг, хороодоос зохион байгуулж буй олон нийтийн ажлуудад оролцсоноор өөрсдийгөө бусдад танилцуулах, амьжиргаандаа дэмжлэг авах боломжийг эрэлхийлж байдагтай холбон тайлбарлаж болох юм.

6.1.3 Мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал⁵

Өрх хэн нэгэн гишүүнээ мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамруулсан эсэх нь тухайн өрхөд амьжиргаагаа дээшлүүлэх чадавхи бүрдэхэд нөлөөлнө гэж үзээд бид судалгаагаараа холбогдох мэдээллийг цуглуулсан юм. Үр дүнг Хүснэгт 6.4-т өрхийн шинж байдлаар харуулав.

⁵ Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох богино хугацааны сургалтууд. Тухайлбал, үсчин, тогооч, оёдолчин, мужаан гэх мэт.

Хүснэгт 6.4. Өрхүүдийн хувийн жин, өрхөөс мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалт, дамжаанд хамрагдсан хүн байгаа эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Мэргэжлийн ажил хөдөлмөрийн дадлага олгох сургалт, дамжаанд хамрагдсан хүн байгаа эсэх		Бүгд	Нийт өрхийн тоо
	Гийм	Үгүй		
Байршил				
Гэр хороолол	19.2	80.8	100.0	816
Байшин хороолол	22.4	77.6	100.0	684
Шилжилтийн байдал				
Шилжигч	18.2	81.8	100.0	176*
Шилжигч бус	21.9	78.1	100.0	1139*
Хороондоо бүртгэлтэй эсэх				
Бүртгэлтэй	21.0	79.0	100.0	1356
Бүртгэлгүй	17.4	82.6	100.0	144
Өрхөд амьдарч буй хүний тоо				
1-2	9.5	90.5	100.0	179
3-5	20.0	80.0	100.0	951
6 ба түүнээс дээш	27.8	72.2	100.0	370
Амьжиргааны түвшин				
Нэн ядуу	17.9	82.1	100.0	106
Ядуу	21.9	78.1	100.0	279
Ядуу бус (бага орлоготой)	17.4	82.6	100.0	402
Ядуу бус (дунд орлоготой)	20.8	79.2	100.0	366
Ядуу бус (чинээлэг)	24.2	75.8	100.0	347
Өрхийн тэргүүний хүйс				
Эрэгтэй	21.1	78.9	100.0	1144
Эмэгтэй	19.4	80.6	100.0	356
Нийт	20.7	79.3	100.0	1500

Тэмдэглэгээ: * - Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Нийт өрхийн тавны нэг нь өрхийн хэн нэгэн гишүүн мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамрагдсан гэж хариулжээ. Өрхийн шинж байдлаар үзвэл, байшин хорооллын (22.4 хувь), шилжигч бус өрхүүд (21.9 хувь) бусдаас илүүтэйгээр дээрх төрлийн сургалтад гишүүдээ хамруулжээ. Түүнчлэн оршин сууж буй хороондоо бүртгэлтэй өрхүүдийн (21.0 хувь) хувьд энэ үзүүлэлт бүртгэлтгүй өрхийнхөөс (17.4 хувь) өндөр байна.

Тухайн өрхөд амьдарч буй хүний тоо нэмэгдэх тусам хэн нэгийгээ сургалтад хамруулсан тохиолдол өндөр байна. Тухайлбал, 1-2 гишүүнтэй өрхүүдийн 10 орчим хувь нь л хэн нэгийгээ мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан байхад 3-5 гишүүнтэй өрхийн хувьд энэ нь 20.0 хувь, 6 буюу түүнээс олон гишүүнтэй өрхийн хувьд 27.8 хувь байна. Энэ нь ядуурал, ажилгүйдлийг бууруулах зорилгоор мэргэжлийн баримжаа олгох богино хугацааны сургалтуудыг явуулахдаа дүүрэг, хороодын эмзэг бүлгийн өрхүүдэд түлхүү анхаарч байгаатай холбоотой байж болох юм. Хүйсээр үзвэл, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдээс сургалтад хамрагдсан гишүүнтэй өрхийн хувь (19.4 хувь) эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (21.1 хувь)-ийнхөөс бага байна.

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Хүн амд мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор явагдаж буй богино хугацааны сургалтууд өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг Хүснэгт 6.5-д өгөгдсөн мэдээллээс харж болно.

Хүснэгт 6.5. Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтанд хамрагдсан гишүүнтэй өрхүүдийн хувийн жин, сургалт, дамжаанд хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан эсэх		Бүгд	Сургалтад хамрагдсан гишүүнтэй өрхийн тоо
	Тийм	Үгүй		
Байршил				
Гэр хороолол	36.3	63.7	100.0	157
Байшин хороолол	49.7	50.3	100.0	153
Шилжилтийн байдал				
Шилжигч	43.8	56.3	100.0	32*
Шилжигч бус	43.4	56.6	100.0	249*
Өрхөд амьдарч буй хүний тоо				
1-2	52.9	47.1	100.0	17
3-5	45.8	54.2	100.0	190
6+	35.9	64.1	100.0	103
Амьжиргааны түвшин				
Нэн ядуу	21.1	78.9	100.0	19
Ядуу	23.0	77.0	100.0	61
Ядуу бус (бага)	40.0	60.0	100.0	70
Ядуу бус (дунд)	51.3	48.7	100.0	76
Ядуу бус (чинээлэг)	57.1	42.9	100.0	84
Өрхийн тэргүүний хүйс				
Эрэгтэй	44.8	55.2	100.0	241
Эмэгтэй	36.2	63.8	100.0	69
Нийт	42.9	57.1	100.0	310

* - Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзэв.

Өрхүүдийн тал хүрэхгүй (42.9) хувь нь сургалтад хамрагдсанаар тодорхой хэмжээгээр амьжиргаагаа дээшлүүлж чадсан гэж үзэж байна. Амьжиргаагаа дээшлүүлж чадсан өрхүүдийн хувь байшин хорооллын (49.7 хувь), цөөн хүнтэй (52.9 хувь), эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд (44.8 хувь)-ийн дунд харьцангуй илүү байна. Харин шилжигч болон шилжигч бус өрхүүдийн хувьд төдийлөн ялгаа байхгүй байна (харгалзан 43.8 ба 43.4 хувь).

Өрхөөс хэн нэг гишүүн нь мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалт, дамжаанд хамрагдсан болон сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадаж буй өрхүүдийн хувийг өрхийн амьжиргааны түвшингээр харьцуулан Зураг 6.2-т харуулав.

6.2. Нийгмийн сүлжээ

Монгол улс цөөн хүн амтай учраас бие биенийгээ сайн таньдаг, тэгээд ч хамаатан садан, найз нөхөд, танилуудын холбоо асар хүчтэй байдаг талаар багагүй ярьж, бичдэг билээ.

Хүснэгт 6.6. Өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох танилтай өрхүүдийн хувь, танилуудын ажил, мэргэжил, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Танил хүмүүсийн ажил, мэргэжил						Нийт өрхийн тоо	
	Эмч	Сувилагч	Дунд сургуулийн багш	Засаг захиргааны ажилтан	Хувийн компаний захирал	Цагдаа		Хар захын байцаагч
Байршил								
Гэр хороолол	39.4	34.2	28.6	21.6	18.1	17.5	9.5	816
Байшин хороолол	53.9	35.8	35.1	30.8	36.1	24.1	7.9	684
Амьжиргааны түвшин								
Нэн ядуу	25.5	25.5	17.9	15.1	10.4	10.4	8.5	106
Ядуу	36.6	29.7	24.0	16.1	15.4	12.9	5.4	279
Ядуу бус (бага)	41.8	34.3	30.8	25.4	21.4	18.2	8.7	402
Ядуу бус (дунд)	49.4	36.0	35.2	25.1	25.1	21.9	10.4	366
Ядуу бус (чинээлэг)	61.4	41.5	38.6	38.0	47.0	31.1	10.1	347
Өрхийн тэргүүлэгчийн шилжилтийн байдал								
Шилжигч	37.5	25.6	28.4	18.2	23.3	19.9	10.2	176*
Шилжигч бус	47.1	36.8	33.0	28.1	28.4	21.9	9.0	1139*
Өрхийн тэргүүлэгчийн хүйс								
Эрэгтэй	47.4	34.4	31.8	25.8	26.8	20.8	8.6	1144
Эмэгтэй	41.9	36.5	30.6	25.8	24.7	19.7	9.6	356
Өрхийн тэргүүлэгчийн боловсрол								
Боловсролгүй	33.3	25.0	16.7	11.1	11.1	11.1	2.8	36
Бага	34.2	29.8	18.4	14.9	13.2	10.5	6.1	114
Бүрэн бус дунд	37.9	31.6	29.0	21.3	19.5	16.2	9.9	272
Бүрэн дунд	41.4	34.2	29.5	19.4	19.9	17.9	7.2	403
Тусгай мэргэжлийн	41.1	36.5	30.8	28.1	25.1	21.7	8.7	263
Дээд	63.6	39.1	40.5	37.9	43.0	28.9	10.9	412
Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт								
Орлого олох ажил эрхэлдэг	50.3	36.8	35.5	29.2	32.1	24.0	10.2	894
Орлого олох ажил эрхэлдэггүй	39.8	32.2	25.7	20.8	17.8	15.3	6.8	606
Бүгд	46.1	35.0	31.5	25.8	26.3	20.5	8.8	1500

* - Шилжих хөдөлгөөнийг тодорхойлох асуулт 15-64 насны хүн амаас асуугдсан тул нийлбэр нь 1500-аас бага

Тэгвэл энэхүү харилцаа, холбоо буюу сүлжээ бодитоор байгаа эсэхийг тодруулах зорилгоор бид судалгаандаа өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох танилууд тухайн өрхөд байдаг эсэх, тэдгээр танил хүрээнийхэн хэн болох, өдөр тутмын амьдралд нь тусалцаа үзүүлдэг эсэх зэрэг асуултаудыг оруулсан юм. Эдгээр асуудалд

Мэдлэг, мэдээлэл ба нийгмийн капитал

хариулт авах нь танилууд буюу "хүрээлэл"-ээр дамжуулан өрхийн амьжиргаанд нөлөөлөх боломж байгаа эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой байж болох юм.

Хүснэгт 6.6-д өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох зарим ажил, мэргэжилтэй танилууд тухайн өрхөд байдаг эсэхийг харууллаа. Ийм ажил, мэргэжилд эмч, сувилагч, дунд сургуулийн багш, засаг захиргааны ажилтан, хувийн компаний захирал, менежер, цагдаа, хар захын байцаагч зэргийг багтааж үзэв. Хүснэгтээс харахад нийт өрхийн 8.8-46.1 хувь нь өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох танилуудтай гэж хариулжээ. Өрхүүдийн дунд эмч (46.1 хувь), сувилагч (35 хувь), дунд сургуулийн багш (31.5 хувь) зэрэг мэргэжил эзэмшсэн танилуудтай өрхийн эзлэх хувь өндөр, харин цагдаа (20.5 хувь), хар захын байцаагч (8.8 хувь) зэрэг ажил, мэргэжил эзэмшсэн танилуудтай өрхийн хувь хамгийн бага байна.

Хүснэгт 6.7. Өрхүүдийн хувийн жин, өдөр тутмын амьдралдаа өрхийн гишүүдийн дотно танил/хүрээллийнхнээс дэмжлэг авдаг эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Дотно танил, хүрээллийнхнээс дэмжлэг авдаг эсэх		Бүгд	Нийт өрхийн тоо
	Тийм	Үгүй		
Байршил				
Гэр хороолол	60.4	39.6	100.0	816
Байшин хороолол	63.6	36.4	100.0	684
Шилжилтийн байдал				
Шилжигч	60.8	39.2	100.0	176*
Шилжигч бус	60.8	39.2	100.0	1139*
Өрхөд амьдарч буй хүний тоо				
1-2	69.8	30.2	100.0	179
3-5	65.8	34.2	100.0	951
6+	47.8	52.2	100.0	370
Амьжиргааны түвшин				
Нэн ядуу	45.3	54.7	100.0	106
Ядуу	54.5	45.5	100.0	279
Ядуу бус (бага)	59.0	41.0	100.0	402
Ядуу бус (дунд)	71.0	29.0	100.0	366
Ядуу бус (чинээлэг)	66.6	33.4	100.0	347
Өрхийн тэргүүний хүйс				
Эрэгтэй	60.3	39.7	100.0	1144
Эмэгтэй	66.9	33.1	100.0	356
Өрхийн тэргүүний ажил эрхлэлт				
Орлого олох ажил эрхэлдэг	62.3	37.7	100.0	894
Орлого олох ажил эрхэлдэггүй	61.2	38.8	100.0	606
Нийт	61.9	38.1	100.0	1500

Тэмдэглэгээ: * Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Өдөр тутмын амьдралд нь чухал нөлөө үзүүлж болох танилуудтай өрхийн хувь байшин хорооллын (24.1-53.9 хувь), шилжигч бус (21.9-47.1 хувь), ажил эрхэлдэг тэргүүлэгчтэй өрхүүдэд (24-50.3 хувь) бусад өрхөөс илүүтэй байна. Түүнчлэн өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин нэмэгдэх тусам танилтай өрхүүдийн хувийн жин нэмэгдэж байгаа юм. Тухайлбал, өрхийн тэргүүлэгч нь боловсролгүй өрхүүдийн 11.1-33.3 хувь нь өрхийн өдөр тутмын амьдралд нь чухал нөлөө үзүүлж болох танилтай гэж байхад өрхийн тэргүүлэгч нь дээд боловсрол эзэмшсэн өрхийн хувьд энэ үзүүлэлт хоёр дахин өндөр байна.

Амьжиргааны түвшингээр үзвэл, орлого өндөртэй, чинээлэг өрхүүдийн танилын цар хүрээ (31.1-61.4%) дунд түвшингийн амьжиргаатай болон ядуу өрхүүдээс бараг 3 дахин их байна.

Эдгээр байдлаас харахад шилжигч, гэр хороололд амьдарч буй, ядуу болон нэн ядуу өрхүүд амьдралдаа тусламж авах чухал шаардлага гарсан нөхцөлд тусламж, дэмжлэг эрэн хандаж болох танилын цар хүрээ харьцангуй хязгаарлагдмал байна. Өрхийн амьдралд дотно танил, хүрээнийхний тусламж, дэмжлэг хэр байдаг талаарх мэдээллийг Хүснэгт 6.7-д харуулав.

Нийт өрхийн бараг гуравны хоёр нь өдөр тутмын амьдралдаа өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхнээс тусламж, дэмжлэг авдаг байна. Энэ хувь байшин хорооллын өрхүүдэд (63.6 хувь) гэр хорооллынхоос 3.2 пунктээр, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд (66.9 хувь) эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс 6.6 пунктээр илүү байна. Харин шилжигч болон шилжигч бус өрхүүдийн хувьд энэ нь ижилхэн хувьтай байгаа юм (60.8 хувь). Энд нэг сонирхол татсан үзүүлэлт бол өрхийн гишүүдийн тоо цөөхөн байх тутам бусдаас дэмжлэг авах явдал өндөр байгаа явдал юм.

Амьжиргааны түвшингээр үзвэл, өдөр тутмын амьдралдаа бусдаас дэмжлэг авдаг нэн ядуу өрх (45.3 хувь)-ийн хувийн жин ядуу бус боловч бага орлоготой өрхийнхөөс 3.7 пунктээр, ядуу бус дунд орлоготой өрхийнхөөс 25.7 пунктээр, чинээлэг өрхийнхөөс 21.3 пунктээр тус тус бага гарчээ. Ийнхүү өрхийн амьжиргаа доогуур байх тусам гэдэнд туслах танилын хүрээ хумигддаг болох нь харагдаж байна.

Дээрхээс харахад байшин хороололд амьдардаг, цөөхөн ам бүлтэй, орлого өндөртэй, ажил эрхэлдэг зэрэг "давуу талтай" өрхүүд өдөр тутмын амьдралдаа бусдаас харьцангуй илүү дэмжлэг, туслалцаа авдаг ажээ. Гэвч эдгээр өрхүүд үнэхээр төрөл садан, танилуудын холбоо, харилцаагаа ашиглан илүү "сайн сайхан" амьдарч байна уу гэдгийг тодруулан судлах шаардлагатай юм.

Өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхэн өдөр тутмын амьдралд нь хэрхэн яаж, ямар хэлбэрээр тусалж байгаа талаар энэ түүвэр судалгааны асуулгаар мэдээлэл цуглуулаагүй ч чанарын судалгаагаар түүнийг тодруулах зарим мэдээллийг авсан юм. Ялангуяа шилжин ирэгчдийн дунд хийсэн ярилцлагуудаар энэ асуудалтай холбоотой мэдээлэл нэлээд гарч ирсэн билээ.

“... Шилжин ирэгчдийн хувьд амьжиргааны эх үүсвэр нь гэр хорооллынхтой нэлээд ойролцоо байгаа боловч ах дүү болон хөдөөгөөс ямар нэг хэлбэрээр тусламж авдаг, тэр тусламж нь тодорхой хэмжээгээр амьжиргаанд нь нөлөөлдөг байна. Түүнчлэн хотод танил тал, түшиж тулах ах дүүтэй шилжин ирэгчдийн хувьд бэрхшээл харьцангуй бага байдаг, харин ах дүү, танил тал багатай иргэдийн хувьд бэрхшээлийг даван туулах нь нэн хүндрэлтэй байдаг ажээ.”

(Чанарын судалгааны тайлан).

Чанарын судалгааны үр дүнгээс харахад өрхийн гишүүдийн танил, хүрээнийхний дэмжлэг маш өргөн хүрээтэй байгаа ч өрхийн гишүүд ажил олох, шилжигчид өөр газраас шилжин ирээд шинэ газарт "хөлөө олох" зэрэгт нь илүүтэйгээр тус болдог байна.

*“Ах дүү нараасаа мөнгө зээлээд наймаа хийж хувиараа жижиг бизнес эхэлсэн. Нийт сая гаруй төгрөг 8-9 хувийн хүүтэйгээр зээлээд одоо эргүүлээд өгч байгаа, бараг дууссан. 1 жил орчим болж байна”
(Д, эмэгтэй, нас 29, хувийн бизнес эрхэлдэг, бүртгэлгүй шилжигч, СХД)*

*“Хотод таньдаг хүн байхгүй бол ажил олдоход их хэцүү. Жишээ нь манай нөхөр одоо болтол ажилгүй байгаа. Ажил ерөөсөө олдохгүй байгаа”
(С, эмэгтэй, нас 26, үсчин, СХД)*

*“Булган аймгаас ирээд 2 жил болж байгаа. Би хөдөөнөөс ирээд шууд ажилд орсон. Гэхдээ таньдаг хүнээрээ дамжуулж орсон болохоор хамаагүй амар байсан”
(Ц, эмэгтэй, нас 39, СХД)*

Түүнчлэн өрхүүдэд хүүхдээ сургуульд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад ч өрхийн гишүүдийн танил, хүрээллийнхэн байнга дэмжлэг үзүүлдэг байна.

“Шилжиж ирээд хүүхдээ сургуульд оруулах бол хамгийн хэцүү асуудал. Багтахгүй, ачаалал ихтэй байна гээд ер халгаадаггүй. Тэгээд таньдаг хүнээ гуйж байгаад гэрээсээ хол, харьяалалын бус сургуульд хүүхдээ оруулсан”

(Ц, эмэгтэй, нас 39, СХД)

“Үзүүлье гэсэн үедээ таньдаг эмч дээрээ очиж үзүүлдэг. Харин яг харьяаллын өрхийн эмнэлэгтээ очиж үзээгүй”

(Ч, эмэгтэй, нас 33, ажилгүй, бүртгэлгүй шилжигч, СХД)

Өрхийн өдөр тутмын амьдралд хамгийн их тус дэм үзүүлдэг танил, хүрээллийнхэн ямар хүмүүс байгааг Хүснэгт 6.8-аас тодруулан харж болно.

Өрхийн өдөр тутмын амьдралд хамгийн их дэмжлэг үзүүлдэг гэж нэрлэсэн хүмүүсийн дотор өрхийн гишүүдийн хамаатан садан (89.4 хувь), дотно найзууд (29.1 хувь), хамт ажиллагсад (28.8 хувь) бусдаас өндөр хувь эзэлж байна. Энэ хандлага бүх өрхүүдийн хувьд ижил байгаа ба нэг өрхийн өдөр тутмын амьдралд дунджаар танил хүрээллийнх нь 2 хүн дэмжлэг, тусламж үзүүлдэг ажээ.

Гэр хороололд амьдардаг өрхүүд байшин хорооллын өрхүүдтэй харьцуулахад багын болон дотны найзууд, нэг оны цэргийнхэн, төрсөн нутаг усныхан гэсэн хүрээллээс илүүтэй дэмжлэг авдаг байна. Харин байшин хороололд амьдарч буй өрхүүд хамаатан садан, хамт суралцаж байсан нэг ангийнхан, хамт ажиллагсаасаа илүүтэй дэмжлэг авдаг ажээ.

Өрхийн гишүүдийн тоогоор үзвэл, цөөн (1-2) гишүүнтэй өрхүүд дундаж болон олон гишүүнтэй өрхүүдтэй харьцуулахад хамаатан садангаасаа илүүтэй дэмжлэг авдаг бол олон гишүүдтэй өрх дунд сургуулийн нэг ангийнхан, дотны найзууд, хамт ажиллагсад, төрсөн нутаг усныхнаас илүү дэмжлэг авдаг ажээ. Түүнчлэн өрхийн гишүүдийн тоо нэмэгдэх тусам өрхөд нь дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо нэмэгдэж байна.

Хүснэгт 6.8. Өрхийн өдөр тутмын амьдралд өрхийн гишүүдийн дотно танил/хүрээллийнхнээсээ дэмжлэг авдаг өрхүүдийн хувь, дэмжлэг үзүүлдэг хүрээлэл, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлт	Өрхийн амьдралд дэмжлэг үзүүлдэг хүрээллийнхэн									Бусдаас дэмжлэг авдаг өрхийн тоо
	Хамаатан садан	Дунд сургуулийн нэг ангийнхан	Их сургуулийн нэг ангийнхан	Багын/дотно найзууд	Нэг оны цэргийнхэн	Төрсөн нутаг, усныхан	Хамт ажилладаг/ ажиллаж байсан хүмүүс	Бусад*	Дэмжлэг үзүүлдэг хүрээний дундаж тоо	
Байршил										
Гэр хороолол	88. 4	8.3	5.1	29. 4	3. 4	6.9	26.2	1.8	1.7	493
Байшин хороолол	90. 6	10.9	9.4	28. 7	1. 4	6.2	32.2	0.7	1.8	435
Шилжилтийн байдал										
Шилжигч	87. 8	7.5	4.7	34. 6	0. 9	13. 1	17.7	0.0	1.6	107**
Шилжигч бус	89. 0	10.8	8.4	31. 2	3. 2	5.9	33.9	1.0	1.8	693**
Өрхөд амьдарч буй хүний тоо										
1-2	90.4	9.6	6.4	24.8	1.6	4.8	21.6	1.6	1.6	125
3-5	89.1	8.9	7.7	29.1	2.1	6.4	28.7	0.6	1.7	626
6 ба түүнээс дээш	89.8	10.2	5.6	32.2	4.5	8.5	33.9	1.7	1.9	177
Амьжиргааны түвшин										
Нэн ядуу	83. 3	0.0	2.1	18. 7	0. 0	2.1	10.4	4.2	1.2	48
Ядуу	86. 8	4.6	4.6	23. 7	2. 0	5.3	20.4	2.0	1.5	152
Ядуу бус (бага)	93. 2	5.9	1.3	26. 2	1. 7	7.2	30.8	1.3	1.7	237
Ядуу бус (дунд)	89. 2	13.5	8.8	28. 8	3. 5	8.5	31.1	0.0	1.8	260
Ядуу бус (чинээлэг)	88. 7	13.0	13.8	37. 2	3. 0	5.6	35.1	0.0	2.0	231
Нийт	89.4	9.3	7.1	29.1	2.5	6.6	28.8	1.0	1.7	928

Тэмдэглэгээ: * Хөрш айлууд болон бусад танилууд

** Шилжилтийн байдлыг 15-64 насны хүн амын хувьд авч үзсэн

Өрхөд дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо шилжигч өрхүүдийн хувьд (1.6) шилжигч бус өрхөөс (1.8) цөөн байна. Харин тэд шилжигч бус өрхүүдтэй харьцуулахад төрсөн нутаг усныхан, дотно найзуудаасаа илүүтэй дэмжлэг авдаг байна.

Амьжиргааны түвшингээр үзвэл, нэн ядуу болон ядуу өрхүүдэд дэмжлэг үзүүлдэг хамаатан садан, танилуудын хүрээлэл бага байна. Ядуу бус боловч бага орлоготой, орлогын ядууралд өртөх эрсдэл өндөртэй бүлгийн хувьд бусад бүлгийнхэнтэй харьцуулахад хамаатан садангуудаас илүүтэй дэмжлэг авдаг ажээ. Өдөр тутмын амьдралдаа бусдаас дэмжлэг авдаг нэг өрхөд дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо амьжиргааны түвшин дээшлэх тутам нэмэгдэж байна. Тухайлбал, нэн ядуу нэг өрхийн

Мэдлэг, мэдээлэл ба нийгмийн капитал

хувьд дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо нь 1.2 байхад чинээлэг өрхийн хувьд 2.0 байгаа юм. Өөрөөр хэлбэл, чинээлэг өрх найз нөхөд, хамаатан садны хүрээлэл ихтэй байна. Ийнхүү цөөхөн гишүүнтэй, байшин хороололд амьдардаг, шилжигч бус, амьжиргааны түвшин дээгүүр өрхүүд өдөр тутмын амьдралдаа бусдаас илүү дэмжлэг авдаг ба тэдгээр хүрээнийхэн нь хамаатан садан, дотно найзууд, хамт ажиллагсад болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Дүгнэлт

Хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төр, засгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн талаар өрхүүдийн талаас илүү хувь мэдээлэл авсан боловч 1/10 хүрэхгүй хувь нь түүний үр шимээс хүртжээ. Ногоон хувьсгал, хадгаламж, зээлийн төслүүдийн үр шимээс хүртсэн өрхийн хувь бусад хөтөлбөр, төслөөс өндөр байна. Харин өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих, ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр шимийг хүртсэн өрх бараг байхгүй байна. Энэ нь хотод хэрэгжиж буй хүн амын амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төслүүдийн хүртээмж бага байгааг харуулж байна.

Нийслэлийн өрхүүдийн бараг тал хувь нь нийгмийн оролцооны идэвх сул аж төрж байна. Ялангуяа, орлого өндөртэй өрхүүдийн олон нийтийн оролцоо хамгийн сул байгаа нь чинээлэг өрхүүд уг асуудалд ач холбогдол бага өгдгийг харуулж байна. Харин ядуу өрхүүд дүүрэг, хороодоос зохион байгуулж буй олон нийтийн ажлуудад харьцангуй идэвхтэй оролцдог байна. Өөрөөр хэлбэл, дүүрэг, хороодоос зохион байгуулж буй хурал, цуглаан, олон нийтийн ажлуудад ядуу хүн ам идэвхтэй оролцсоноор эмзэг бүлгийнхэнд зориулагдсан төсөл, хөтөлбөр, зохион байгуулалттай ажлуудад хамрагдан амьжиргаагаа дээшлүүлэх боломжийг эрэлхийлдэг байж болох юм. Хэн нэгэн гишүүнээ мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хамруулсан өрхийн хувь амьжиргааны аль ч түвшингийн өрхүүдэд ойролцоо байгаа хэдий ч нэн ядуу өрхөөс сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан гишүүдийн хувь чинээлэг өрхийнхөөс бараг гурав дахин бага байна. Энэ нь доогуур орлоготой, ядуу өрхүүд эдийн засгийн нөөц боломжоор төдийгүй чадавхийн хувьд "ядмаг" байгааг харуулж байна. Нөгөө талаас, амьжиргаагаа дээшлүүлэхэд ард иргэдийн өөрсдийн идэвх, оролцоо ихээхэн хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна. Ийнхүү, доогуур орлоготой, ядуу өрхүүдийн хувьд дээрх сургалтаас үр дүн хүртэх боломж бага байна.

Нийт өрхүүдийн тодорхой хувь нь (гэхдээ талаас бага) өрхийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлж болох эмч, багш, засаг захиргааны ажилтан, хувийн компанийн захирал, бараан захын байцаагч зэрэг танилуудтай боловч шилжигчид, гэр хорооллынхон, нэн ядуу, ядуу өрхүүдийн амьдралд туслахуйц хүрээллийнхэн харьцангуй хязгаарлагдмал байна. Нийт өрхийн бараг 2/3 нь өдөр тутмын амьдралдаа өрхийн гишүүдийн дотно танил, хүрээллийнхнээс тусламж, дэмжлэг авдаг байна. Өрхөд өрхийн гишүүдийн хамаатан садан, дотно найз, хамт ажиллагсад хамгийн их дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Ерөнхийдөө, байшин хороололд амьдардаг, цөөхөн гишүүнтэй, орлого өндөртэй, ажил эрхэлдэг зэрэг "давуу талтай" өрхүүд өдөр тутмын амьдралдаа бусдаас харьцангуй илүү дэмжлэг, туслалцаа авдаг байна. Өрхөд дэмжлэг үзүүлдэг хүрээллийн дундаж тоо өрхийн амьжиргааны бүлэг дээшлэх тутам нэмэгдэж байна. Ийнхүү өрх болон өрхөд амьдарч буй хүмүүсийн дотно танил, хүрээллийнхний хоорондын холбоо, харилцаа нь бодитой оршиж, өрхийн амьжиргаанд тус дэм үзүүлж байна.

БҮЛЭГ 7. ЯДУУРАЛ

Энэ бүлэгт Улаанбаатар хотын ядуурлын түвшин, төлөв байдал, ялгааг харуулна. Мөн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг чиглүүлэх зорилтот бүлгүүдийг тодорхойлох болно. Түүнчлэн ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай вэ гэдэг талаар өгүүлэх юм. Үүний зэрэгцээ чадавхи болон хүртээмжийн ядуурал гэсэн ойлголт дээр тулгуурлан ядуурлыг тодорхойлох боломжит аргуудыг судалсан. Юуны өмнө энэ бүлэгт ядуурлын стандарт хэмжүүрүүдийг танилцуулах болно. Түүнчлэн тэгш бус байдлыг тодорхойлсон хэмжүүрүүд болох 80-20 децилийн дисперсийн харьцаа болон Жини коэффициентийг тооцож гаргасан. Мөн ядуу хүн амын нийгэм, эдийн засгийн ялгаатай байдлыг тодруулахыг зорилоо. Ингэхдээ ядуу хүмүүсийг тодорхойлох шинж байдлыг тодруулснаар зорилтод бүлгийг тогтоох юм. Дараагийн хэсэгт бид ядуу болон ядуу бус хүн амын амьжиргааны түвшнийг илүү нарийн судлах юм. Ахуй нөхцөл, боловсрол, эрүүл мэнд гэх мэт асуудлуудын хувьд гол ялгаануудыг харуулна. Энэ нь үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход дөхөм болох учиртай. Өөрөөр хэлбэл, ямар үйл ажиллагааг нэн түрүүнд хийх вэ? Зөвхөн ядуу хүмүүст чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулах вэ? гэдэгт хариулт өгөх юм.

Эцэст нь чадавхи, хүртээмжийн ойлголт дээр тулгуурлан ядуурлыг тодорхойлсон. Бид эдгээр үзүүлэлтүүд нь ядуурлын уламжлалт үзүүлэлтүүдтэй хэрхэн хамааралтай байгааг судална.

Түлхүүр асуултууд

- Улаанбаатар хотод ядуурлын түвшин ямар байна вэ?
- Хэн ядуу байна вэ?
- Энэ талаар юу хийх шаардлагатай вэ?

Хариулт ба дүгнэлтүүд

- Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүн амын 33 хувь нь ядуурлын шугамаас (25300 төгрөг) доогуур амьжиргаатай, түүврийн 10 хувь нэн ядуу (өөрөөр хэлбэл зардал нь ядуурлын шугамаас 60 хувиар доогуур) байна.
- Гэр хороололд амьдрагсад болон шилжигчид илүү ядуу байна (харгалзан 45 хувь ба 37 хувь).
- Тэгш бус байдал гэр хороололд амьдрагсдын дунд харьцангуй гайгүй байна. Харин шилжигчдийн хувьд нэлээд ялгаатай байна.
- Залуу насны, бага боловсролтой болон гэрлээгүй хүмүүс илүү ядуу байна. Тэдний дийлэнх гэр хороололд, ялангуяа Баянзүрх дүүрэгт амьдарцгааж байна. Эдгээр хүмүүсийн өрх олон ам бүлтэй, мөн дийлэнх нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.
- Ядуурлыг бууруулах үйл ажиллагааг явуулах зорилтот бүлэг нь ам бүл олон, гэр хорооллын өрхүүд юм. Түүнчлэн, өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас бага боловсролтой өрхүүдэд анхаарах нь зүйтэй.
- Нэн тэргүүнд хийгдэх үйл ажиллагаа нь ахуйн болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах асуудал юм. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн боловч чанарын асуудалд түлхүү анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- Бүртгэлтэй эсэх нь ядууралтай хамааралтай асуудал биш байна. Ядуу хүмүүс ядуу бус хүмүүсийн нэгэн адил бүртгэлтэй байна. Ядуучуудын 90 хувь бүртгэлтэй байв.
- Нийт хүн амын 4.3 хувийг эзэлж буй казак хүн амын 60 хувь ядуу байна. Энэ цаашид судлах шаардлагатай асуудлуудын нэг юм.

7.1 Ядуурлын уламжлалт үзүүлэлтүүд

Ядуурлын хамрагдалт, гүнзгийрэлтийн талаар ойлголттой болоход ядуурлын уламжлалт үзүүлэлтүүдийг судлах шаардлагатай байдаг. Энэхүү хэсэгт бид эдгээр үзүүлэлтүүдийг харуулах бөгөөд үр дүнг хүснэгтээр үзүүлсэн.

Ядуурлын үзүүлэлтүүдийн тайлбар

Орлого/зарлагын ядуурлыг ядуурлын хамрагдалтын индекс (P0), гүнзгийрэлтийн индекс (P1), ялгааны индекс (P2) гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлов. Энэ хэсэгт эдгээр үзүүлэлтүүдийн товч тайлбар болон тооцсон үр дүнг харуулав.

Ядуурлын хамралтын индекс (P0) нь нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин юм. Ядуурлын шугамыг хоол хүнсний наад захын хэрэгцээг (насанд хүрсэн нэг хүн өдөрт 2100 калори) хангах хэрэглээний сагс болон хүнсний бусад хэрэглээнд үндэслэн тодорхойлно. Монголын хувьд ҮСГ ядуурлын шугамыг энэ онд 25300 төгрөгөөр тогтоосон. Энэхүү судалгаанд хүнсний болон хүнсний бус хэрэглээг өрхийн хувьд асуусан бөгөөд тоо мэдээг ашиглан ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амыг тодорхойлсон. Энэ нь P0 утгыг илэрхийлэх юм⁶.

P0 нь ядуурлыг харуулах хамгийн энгийн үзүүлэлт юм. Энэ нь ядуурлын гүнзгийрэлтийн талаар мэдээллийг өгдөггүй. Ядуу хүмүүс ядуурлын шугамнаас хэр хол байна вэ? Нөгөөтэйгүүр, хэрэв ядуурлын шугамны дөнгөж дээд талд олон хүн байх нөхцөлд ядуурлын шугамыг жаахан өөрчлөхөд P0-ийн утга ихээхэн өөрчлөгдөж болох талтай. Үүнийг тусгах P1 үзүүлэлт байдаг бөгөөд энэ үзүүлэлтийг ядуурлын гүнзгийрэлт гэж нэрлэдэг.

Ядуурлын гүнзгийрэлтийн индекс P1 нь хүмүүс ядуурлын шугамнаас хэр хол байгааг тооцохоос гадна бага орлоготой хүмүүсийг тодруулах ач холбогдолтой⁷. Энэ үзүүлэлт нь P0-той харьцуулахад илүү нарийвчилсан үзүүлэлт бөгөөд нийт хүмүүсийн байдлыг ядуурлын шугамтай харьцуулан нэг хүнд ногдох зайг харуулдаг. P1 өндөр гарах тусам ядуурал илүү гүнзгий байгааг илэрхийлнэ.

⁶ Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин.

$$P0 = \frac{P_{UPL}}{P_{total}} * 100\%$$

P_{UPL} – Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын тоо

P_{total} – Нийт хүн амын тоо

⁷ Ядуурлын гүнзгийрэлтийн хэмжүүр P1 нь ядуурлын шугамны доогуур байгаа хүн амын ядуурлын шугам хүртэл дундаж зайг харуулна.

$$P1 = \frac{1}{n} \sum_{i=1}^{npl} \frac{(PL - AC)}{PL} * 100$$

PL – Ядуурлын шугам

C_i – Ядуу хүн i-ийн хэрэглээ

n - нийт түүврийн хэмжээ

npl - ядуурлын шугамны доогуур байгаа хүн ам

Ядуурлын гүнзгийрэлт ч ядуурлын байдлыг бас цогцоор нь харуулж чаддаггүй. Магадгүй нэн ядуу хүмүүс ядуу хүмүүст орлогоо алдаж байж болно. Ийм нөхцөлд ядуурлын гүнзгийрэлт (P1) өөрчлөгдөхгүй (зөвхөн шугам даван орлогын шилжилт явагдсан нөхцөлд энэ үзүүлэлт өөрчлөгдөнө). Тиймээс өөр хэмжүүрээр ядуурлын ялгааг (P2)-г тооцдог⁸. Энэ нь ядуу хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлогч үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтийн утга бага гарах тусам ялгаа бага байгааг илэрхийлнэ.

Насанд хүрэгсдийн тэгшитгэл

ҮСГ-ын тооцсон ядуурлын шугам нь зардал дээр үндэслэн тооцогдсон. Тиймээс, энэ судалгаанд ядуурлыг мөн зардал үндэслэн тооцсон юм. Ядуурлыг тооцоходоо насанд хүрэгсдийн тэгшитгэл гэсэн ойлголтыг ашиглаагүй. Энэ талаар Марк Д.Бреннэр “Монголд ядуурлыг бууруулах стратеги”-д тодорхой тэмдэглэсэн байдаг. Үр дүнг тайлбарлахад юуны өмнө дараах зүйлийг санах хэрэгтэй. Үүнд, ам бүл олуулаа өрхүүд ядууралд илүү өртдөг. Тэд ядуу байгаа ч өргөжилтийн үр өгөөж болон өрхөд хүүхдүүд байгаа нөхцлийг нарийн тусгаагүйгээс олон ам бүлтэй өрхүүдийн ядуурлын түвшин бага зэрэг өндөр гарсан байж болох талтай.

Ядуурлын түлхүүр үзүүлэлтүүд: үр дүн

Улаанбаатар хотын ядуурлын төлөв, байдлыг ядуурлын үзүүлэлтүүдээр Хүснэгт 7.1-д харуулав. Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүн амын 33.0 хувь нь ядуурлын шугамаас доогуур түвшинд аж төрж байна.

Хүснэгт 7.1 Хүн амын хувийн жин, ядуурлын үзүүлэлтүүд, байршил, шилжилтийн байдлаар

Байршил, шилжилтийн байдал	Ядуурлын үзүүлэлтүүд				Тоо
	P0	Нэн ядуу (ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй хэрэглээтэй хүн ам)	P1	P2	
Бүгд	33	10	9.9	4.3	6847
Байршил					
Гэр хороолол	45	14	13.8	6.0	4070
Байшин хороолол	16	5	4.3	1.8	2777
Шилжилтийн байдал*					
Шилжигч	37	12	11.2	4.9	688
Шилжигч бус	31	9	8.9	3.8	4024

Тэмдэглэл: * 15-64 насны хүн ам (n=4712)

Гэр хорооллын оршин суугчдын ядууралд хамрагдалтын түвшин байшин хорооллынхоос эрс өндөр байна. Ядууралд хамрагдалтын түвшин шилжигч бус хүн амтай харьцуулахад шилжигч хүн амын хувьд өндөр байгаа ч зөрүү харьцангуй бага байлаа.

⁸ Ядуурлын ялгааны хэмжүүр P2 нь ядуу хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг илэрхийлнэ

$$P2 = \frac{1}{n} \sum_{i=1}^{npl} \left(\frac{(PL - AC)}{PL} \right)^2 * 100$$

Ядуурал

Тэгш бус байдлыг хэмжих


Өөр нэгэн чухал асуудал бол нийгэм дэх тэгш бус байдал юм. Бид 80-20 децилийн дисперсийн харьцаа болон Жини коэффициент гэсэн хоёр хэмжүүрийн ашиглан үүнийг судлах болно.

Тэгш бус байдлын хэмжүүрүүдийн тайлбар

80-20 децилийн дисперсийн харьцаа гэсэн энэ үзүүлэлт энгийн хялбар үзүүлэлт юм. Энэ нь хүн амын хамгийн өндөр хэрэглээтэй 20 хувийн дундаж хэрэглээг хамгийн ядуу 20 хувийн дундаж хэрэглээнд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ. Энэ харьцаа их байх тусам ялгаа их буйг харуулна. Тухайлбал, энэ харьцаа 4 байна гэдэг нь баячуудын хэрэглээ ядуучуудын хэрэглээнээс дөрөв дахин өндөр байна гэсэн үг.

80-20 децилийн дисперсийн харьцааны энэхүү арга хамгийн ядуу болон хамгийн баян хүмүүсийн ялгааг харуулдаг бол дунд хэсэгт байгаа хүмүүс ямар байна вэ? Баячууд бусдаас илүү өндөр хэрэглээтэй тусдаа бүлэг үү? Эсвэл баян, дунд болон ядуу хэрэглээтэй хүн амын ялгаа харьцангуй жигд байна уу? гэсэн асуултууд аяндаа гарч ирэх болно.

Зураг 7.1 Лоренцийн муруй, Улаанбаатар



Жини коэффициент болон Лоренцийн муруйн нь нийгэм төгс тэгш хуваарилалтаас хэр хол байгааг харуулдаг. Төгс тэгш хуваарилалтын үед бүлэг тус бүрийн хүн амын 10 хувь нийт хэрэглээний 10 хувийг хэрэглэх ёстой. Бодит байдал дээр гэтэл нэн ядуу 10 хувь нийт хэрэглээний 10 хүрэхгүй хувийг хэрэглэсэн байдаг. Ийнхүү ядуу хүн амын 10 хувь тус бүрийн хэрэглээг тооцон дүрслэн харуулна.

45⁰ ташуу шугам нь төгс тэгш хуваарилалтыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл хүн амын 10 хувь нь нийт хэрэглээний 10 хувийг хэрэглэж байна. Харин муруй үргэлж 45⁰ шулууны доор байрладаг. Энэ нь ядуу хүн амын 10 хувь нийт хэрэглээний 10 хүрэхгүй хувийг хэрэглэж байгааг харуулж байгаа юм. Зургаас харахад ядуу хүн амын 20 хувь нь ч нийт хэрэглээний 10 хувьд хүрэхгүй байна. Муруй шугамд ойр байх тусам хуваарилалт илүү тэгш байна гэсэн үг. Муруй болон шугам хоорондын дундаж зай нь Жини коэффициент болно. Энэ нь 0-оос 1-ийн хооронд утгатай байх бөгөөд утга нь хэдий чинээ бага байна хуваарилалт төдий чинээ тэгш байгааг илэрхийлнэ.

Тэгш бус байдлын хэмжүүрүүд: үр дүн

Тэгш бус байдлын хэмжүүрүүдийг тооцоход гэр болон байшин хороололд амьдрагсдын хувьд сонирхолтой дүн гарсан. Гэр хороололд оршин суугчид илүү ядуу, түүнчлэн хуваарилалт илүү тэгш байгаа нь ажиглагдлаа.

Хүснэгт 7.2 Тэгш бус байдлын хэмжүүр

Сонгосо н үзүүлэл түүд	Нэг хүнд ногдох хэрэглээнд үндэслэн тооцсон тэгш бус байдал				Тоо
	80-20 децилийн дисперсийн харьцаа	Хамгийн баян 20 хувийн хэрэглээний зардал (төгрөгөөр)	Хамгийн ядуу 20 хувийн хэрэглээний зардал (төгрөгөөр)	Жини коэффициент	
Нийт	5.6	81 900	14 500	0.34	6847
Байршил					
Гэр хороолол	4.4	56 200	12 800	0.28	4070
Байшин хороолол	5.4	108 800	20 700	0.33	2777


Тэмдэглэл: * 15-64 насны хүн ам (n=4712)

Үүнийг бид баян 20 хувийн хэрэглээ харьцангуй доогуур байгаа дүнд үндэслэн хэлж болно. Түүнчлэн Жини коэффициент бага гарсан нь үүний нэг илрэл болж байгаа юм. Хэрэглээний зардлын тархалтын харьцуулалтыг гаргахад дийлэнх оршин суугчид ядуурлын шугаманд ойрхон байгаа нь харагдаж байна. Ядуу бус хүн ам ч ядуурлын шугамнаас төдийлэн хол байж чадахгүй байна. Харин байшин хороололд оршин суугчид илүү чинээлэг бөгөөд ядуурлын шугамнаас нэлээд хол байна. Олон улсын жишигтэй харьцуулахад Улаанбаатарт тэгш бус байдал харьцангуй бага байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Ядуурал

Зураг 7.2 Хэрэглээний зардлын хуваарилалт, байршлаар

Нэг хүнд ногдох зардлын тархалт: Гэр хороололд тэгш бус байдал бага байна



ГЭР ХОРООЛОЛ: нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээний зардал

БАЙШИН ХОРООЛОЛ: нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээний зардал

Ядуурлын үзүүлэлтүүдийн харьцуулалт

Улаанбаатар хотыг дэлхийн бусад улс оронтой харьцуулахад тэгш бус хуваарилалт, ядуурлын ялгаа харьцангуй бага байна. Гэвч эндээс гарах өөр нэг асуулт бол ядуурал болон тэгш бус байдал өнгөрсөн хугацаанд хэр зэрэг өөрчлөгдөв, өөрчлөлт гарав уу? гэсэн асуулт юм. Энэхүү судалгаа Улаанбаатар хотын ядуурлыг судалсан анхны судалгаа бөгөөд өмнө нь хийгдсэн зарим судалгааны дүнтэй харьцуулж үзье. Амьжиргааны түвшний 1998 оны судалгааны дүнгээс харахад Улаанбаатарт ядуурлын түвшин 34 хувь байсан бол энэ судалгаагаар 33 хувь гарлаа. Магадгүй ядуурлын түвшин нэг хэвийн хадгалагдаж эсвэл бага зэрэг буурсан байж болох юм. Гэхдээ тоо мэдээ, арга зүйн ялгаатай байдлаас хамааран эдгээр үзүүлэлтүүдийг шууд харьцуулах боломжгүй гэдгийг анхаарна уу⁹.

7.2 Ядуучуудын шинж байдал

Энэ хэсэгт Ядуучууд гэж хэн бэ? Тэдгээрийн шинж байдал ямар байна вэ? гэсэн асуултуудад хариу өгөх болно.

Хэсгийн бүтэц

Ядуучуудын хувийн жингийн тархалтыг зарим үзүүлэлтүүдээр харуулсан хэснэгтээр энэ хэсэг эхлэнэ. Энэ нь ямар шинж байдал ядуучуудыг тодорхойлж байгаа талаар анхны ойлголтыг өгөх юм. Дараагийн хэсэгт ядууралтай зарим шинж байдал хэр ойр хамааралтай байгааг судлана. Эцэст нь ядуурлыг бууруулахад анхаарах зорилтот

⁹ Арга зүйн ялгаатай байдал дараах хүчин зүйлсээс хамаарна: Үүнд, асуулт, хэрэглээний сагсны бүтэц өөр, хүүхэд, насанд хүрэгсдийг жинэлсэн байдал өөр, гэх мэт орно. Тиймээс, ядуурлын үзүүлэлтүүд буурсан нь ядуурал бодитоор буурсны үр дүн үү ялгаатай арга зүйн үр дүн үү гэдгийг хэлэхэд хэцүү юм.

бүлгүүдийг тодорхойлох болно. Ийнхүү шинжлэхдээ ямар шинж байдал ядууралтай хамааралтай байгааг тодорхойлохын зэрэгцээ тухайн шинж байдалд хамаарч буй бүлгийн хэмжээг тооцож үзсэн. Үйл ажиллагааг боловсруулахад зорилтот бүлгүүд хангалттай хэмжээний байх шаардлагатай.

7.2.1 Ядуучуудын шинж байдал

Хэн ядуу байгааг доорх хүснэгтэнд харуулав. Энд “ядуу эмэгтэй хүн хэд байна вэ?”, ”Баянзүрх дүүрэгт хэдэн хүн ядуу байна вэ?” гэх мэт асуултанд хариу өгөх юм. Тооцоог хувь хүмүүс дээр үндэслэн хийсэн бөгөөд ядуу өрх бус ядуу хүмүүсийн шинж байдлыг харуулахыг зорьсон. Ингэснээр ядууралтай хамааралтай шинж байдлын талаар анхны ойлголттой болох юм.

Хүснэгт 7.3 Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, хэрэглээний зардлын ядуурал, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хэрэглээний зардлын ядуурал		
	Ядуу	Ядуу бус	Бүгд
Шилжилтийн байдал**			
Шилжигч	37.2	62.8	688
Шилжигч бус	30.6	69.4	4024
Байршил			
Гэр хороолол	44.9	55.1	4070
Байшин хороолол	15.5	84.5	2777
Дүүрэг			
Баянзүрх	40.3	59.7	909
Налайх	46.1	53.9	492
Сүхбаатар	23.4	76.6	1448
Сонгинохайрхан	34.6	65.4	2344
Хан-Уул	21.0	79.0	481
Чингэлтэй	35.3	64.7	1173
Нас			
17 хүртэл	37.9	62.1	2190
17-25	34.9	65.1	1468
26-59	28.9	71.1	2683
60 ба түүнээс дээш	27.7	72.3	506
Хүйс			
Эрэгтэй	32.9	67.1	3193
Эмэгтэй	33.1	66.9	3654
Яс, үндэс			
Халх	32.3	67.7	6035
Казак	59.5	40.5	173
Дөрвөд	19.3	80.7	171
Буриад	26.8	73.2	112
Баяд	29.6	70.4	142
Бусад	46.7	53.3	214
Гэрлэлтийн байдал*			
Огт гэрлээгүй	35.1	64.9	1909
Баталгаатай гэр бүл	25.0	75.0	2052
Баталгаагүй гэр бүл	36.9	63.1	491

Ядуурал

Сонгосон үзүүлэлтүүд	Хэрэглээний зардлын ядуурал		
	Ядуу	Ядуу бус	Бүгд
Тусгаарласан	41.5	58.5	82
Салсан	37.5	62.5	120
Бэлэвсэн	33.8	66.2	399
Өрхөд амьдарч буй хүний тоо			
1-2	4.2	95.8	306
3-4	16.6	83.4	2393
5-6	34.9	65.1	2425
7+	58.1	41.9	1723
Боловсролын түвшин*			
Боловсролгүй/ бага	48.0	52.0	613
Бүрэн бус дунд	45.5	54.5	1087
Бүрэн дунд	30.0	70.0	1659
Мэргэжлийн/тусгай дунд/дээд	17.1	82.9	1694
Бүртгэлийн байдал			
Бүртгэлтэй	32.7	67.3	6241
Бүртгэлгүй	36.1	63.9	606
Ажил эрхлэлтийн сектор***			
Албан	23.2	76.8	1471
Албан бус	27.4	72.6	654
Гадаадад	17.1	82.9	41
Сууцны төрөл			
Гэр	54.1	45.9	1356
Бусад	27.8	72.2	5491
Бүгд	33.0	67.0	100.0
Тоо	2258	4589	6847

* 15 ба түүнээс дээш насны хүн ам (n=5053)

** 15-64 насны хүн ам (n=4712)

*** 7 ба түүнээс дээш насны хүн ам (n=2166)

Гэр хороололд болон Баянзүрх, Налайх дүүргүүдэд амьдрагсад, түүнчлэн гэрт амьдрагсад болон боловсролын түвшин доогуур хүн амын дунд ядуу хүмүүсийн эзлэх хувийн жин ядуурлын дундаж үзүүлэлтээс өндөр байгааг Хүснэгт 7.3 харуулж байна. Мөн ядуу хүмүүс илүү олон хүүхэдтэй байгаа нь олон хүүхэдтэй болон ам бүл олуулаа өрхүүд ядуу байгааг илчилж байгаа юм.

Ихэнх улс оронд ядууралтай хамааралтай байх зарим шинж байдал тус судалгааны дүнгээр хамааралгүй гарч байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, хүйс болон ажиллаж буй сектор зэрэг хүчин зүйлсийг нэрлэж болох юм. Хэдийгээр ядуурлыг хэрэглээнд үндэслэн тодорхойлохдоо өрхийн эмэгтэй, эрэгтэй гишүүдийн хэрэглээг тус тусд нь тооцоогүй боловч Монголд жендэрийн тэгш байдал харьцангуй хангагдсан гэж хэлж болох болов уу. Ажиллаж буй секторын хувь үзэхэд ихэнх улс орнуудад албан бус салбарт ажиллагчдыг илүү эмзэг байдалд байдаг гэж үздэг. Гэвч ажил эрхлэлтийн талаарх бүлэгт албан бус секторт ажиллагсдын дунд хувийн бизнес эрхлэгчдийн орлогын түвшин харьцангуй өндөр байдаг гэж дурдсан. Энэ байдал нь албан бус секторт ажиллагсдын дунд ядуучуудийн хувийн жин бага байгаагаар тайлбарлагдах болов уу.

Эцэст нь, казах үндэстний хүмүүсийн дунд ядуучуудын хувийн жин өндөр байгаа юм. Монгол улс ястан, үндэстний бүтцийн хувьд харьцангуй жигд, ястан, үндэстний соёл, заншлын зөрүү харьцангуй бага байдаг онцлогтой орон. Хэдий тийм ч судалгааны дүнгээс харахад казакуудын 60 орчим хувь ядуу өөрөөр хэлбэл, ерөнхий дүнгээс 30 орчим пунктээр өндөр байна. Энэ нь нэг талаас судалгаанд хамрагдсан казак иргэдийн (173) тооноос хамаарч болох хэдийч Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын улсын дүнтэй (нийт хүн амд казак үндэстний эзлэх хувийн жин 4.3 хувь, ҮСГ, 2001) харьцуулахад харьцангуй сайн төлөөлөлтэй байгаа юм. Иймд ястан, үндэстнүүдийн ядуурлын ялгавартай байдлыг илүү нарийвчлан судлах нь зүйтэй байна.


7.2.2 Үйл ажиллагааны зорилтот бүлгийг тодорхойлох нь

Зорилтот бүлгийг тодорхойлохдоо дараах асуудлуудыг авч үзэх нь чухал:

1. Ядуу болон ядуу бус хүмүүсийн ялгаа мэдэгдэхүйц их байх;
2. Тухайн шинж байдал илрэх тохиолдлын тоо хангалттай их байх. Зарим эрсдэлтэй бүлгүүд тухайлбал, өнчин хүүхдүүд эсвэл тахир дутуу хүмүүс нь төдийлөн их байдаггүй ч эдгээр бүлгүүд тус судалгаагаар судлаагүй.

Дараах зургуудад дээрх нөхцлийг хангах үзүүлэлтүүдийг харуулж дүгнэлт гаргасан болно. Зураг 7.3-г ядуу болон ядуу бус өрхүүдийн хамгийн их ялгаа илрэх үзүүлэлтүүдийг харуулав.

Зураг 7.3 Нийгэм, эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус өрхүүдийн хамгийн их ялгаа




Зургаас харахад:

- Ихэнх ядуу өрхүүд (79 хувь, нийт ядуучуудын 81 хувь) гэр хороололд амьдарч байна;
- Зургаа ба түүнээс дээш гишүүдтэй болон гэр хороололд амьдарч байгаа өрхүүд нийт ядуу өрхүүдийн 40 хувийг (нийт ядуу хүмүүсийн 52 хувь) эзэлж байна;


Ядуурал

- Нийт түүврийн гуравны нэг нь ядуу байхад гэр хороололд ядуу 6 ба түүнээс дээш хүнтэй өрх байх магадлал 10-т 6 байгаа нь ихээхэн өндөр үзүүлэлт юм.

Зураг 7.4 Нийгэм, эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус ялгаа харьцангуй бага үзүүлэлтүүд



Зураг 7.5 Нийгэм, эдийн засгийн шинж байдал: ядуу болон ядуу бус ялгаа харьцангуй бага үзүүлэлтүүд



Зураг 7.2 болон 7.3-аас харахад гэр хорооллын олон ам бүлтэй өрхүүдээс гадна боловсролын түвшин доогуур хүмүүст анхаарах нь зүйтэй. Боловсролын түвшин доогуур хүмүүсийг мөн зорилтот бүлэг гэж үзэж болохоор байна.

Бусад үзүүлэлтүүдийн хувьд үзэхэд зорилтот бүлгийн шинж байдлыг төдийлөн тодорхой гаргаж чадахгүй болов уу. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийн тоо тийм ч их биш байна. Түүнчлэн шилжигсдийн хувьд ч ижил дүн гарчээ.

Гэрлэлтийн байдлын хувьд ядуу болон ядуу бус өрхүүдийн ялгаа бага байгаа юм. Гэхдээ гэрлээгүй залуучуудыг тодорхой хэмжээгээр анхаарах нь ядуурлыг бууруулахад тодорхой ач холбогдолтой байх болов уу. Казак үндэстний хувьд тоо бага байгаа тул тусгай бодлого хөтөлбөр болвсруулах нь олон хүмүүст хүртэж чадахгүй байх болно. Гэхдээ ядуу казакуудын хувийн жин нэлээд өндөр байгаа дүн гарсан.

Ийнхүү зорилтод бүлгийг тодорхойлоход:

- Олон ам бүлтэй гэр хорооллын өрхүүд
- Өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас бага боловсролтой өрхүүд мөн байж болох юм.

7.3 Хэрэглээ ба амьжиргааны түвшин

Энэ бүлэгт ядуу болон ядуу бус хүн амын хэрэглээ, амьжиргааны түвшинг тус тус тодорхойлох болно. Ядуу болон ядуу бус хүн амыг дэд бүлгүүдэд хувааснаар ялгаж ойлгоход илүү дөхөмтэй болох юм.

Судалгаанд хамрагдсан хүн амын амьжиргааны түвшинг дараах таван бүлэгт ангилан авч үзэв. Үүнд:

- 1) *Нэн ядуу*: Сарын дундаж хэрэглээний зардлын түвшин нь ядуурлын шугамын 60 хувьд хүрэхгүй буюу 15180 төгрөг хүртэлх хэрэглээний зардалтай хүн ам;
- 2) *Ядуу*: Сарын хэрэглээний зардлын түвшин нь 15181 төгрөгөөс ядуурлын шугам болох 25300 төгрөг хүртэлх хэрэглээний зардалтай хүн ам;
- 3) *Ядуу бус (бага орлоготой)*: Ядуурлын шугамаас 60 хүртэл хувиар өндөр буюу 25301-40480 төгрөгийн хэрэглээний зардалтай хүн ам;
- 4) *Ядуу бус (дундаж орлоготой)*: Ядуу бус (бага орлоготой) хүн амын хамгийн өндөр хэрэглээний зардлаас 60 хүртэл хувиар өндөр буюу 40481-64768 төгрөгийн хэрэглээний зардалтай хүн ам;
- 5) *Ядуу бус(чинээлэг)*: Ядуу бус (дундаж орлоготой) хүн амын дээд хэрэглээний зардлаас өндөр буюу 64769 төгрөгөөс дээш хэрэглээний зардалтай хүн амыг тус тус хамруулав.

Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшинг хэрэглээний зардлаар нь ангилж Хүснэгт 7.4-д харуулав.

Хүснэгт 7.4 Хүн амын хувийн жин, амьжиргааны түвшингээр

Амьжиргааны түвшин	Хүн амын хувь	Нийт хүн амын тоо
Нэн ядуу	10.0	685
Ядуу	23.0	1573
Ядуу бус, бага орлоготой	28.8	1974
Ядуу бус, дунд орлоготой	21.5	1472
Ядуу бус, чинээлэг	16.7	1143
Бүгд	100.0	6847

Ядуурал

Нийслэл хотын нийт хүн амын 33 хувь нь амьжиргааны доод түвшингээс доогуур хэрэглээтэй буюу ядуу хүмүүс байна. Ядуу хүмүүсийн 30 хувь нь нэн ядуучууд буюу сард 15180-аас доош төгрөгийн хэрэглээтэй, амьжиргааны наад захын хэрэглээгээ хангах боломжгүй аж төрж байна.

Хүн амын амьжиргааны түвшинг нийгэм, хүн ам зүйн шинж байдлаар Хүснэгт 7.5-д задлан үзүүлэв. Судалгаанд хамрагдсан 65 ба түүнээс дээш насны хүн амын дунд ядуурал хамгийн бага буюу 26.4 хувь байна. Энэ нь нэг талаас тэдний дийлэнх нь тэтгэврийн болон тодорхой хэмжээний орлоготой байдаг, нөгөө талаас үр хүүхдүүд нь эцэг, эхдээ эдийн засгийн хувь нэмэр оруулж байдагтай холбоотой юм.

Хүснэгт 7.5 Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтүүдээр

Үзүүлэлтүүд	Амьжиргааны түвшин					Бүгд	
	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус, бага орлоготой	Ядуу бус, дунд орлоготой	Ядуу бус, чинээлэг		
<i>Нас</i>							
20-оос доош	12.7	25.4	28.0	20.3	13.6	100.0	2714
20-34	8.5	22.5	31.9	18.9	18.2	100.0	1930
35-44	8.9	19.4	23.7	27.9	20.1	100.0	914
45-54	7.4	22.6	31.1	21.8	17.1	100.0	634
55-64	8.6	19.4	29.0	22.6	20.4	100.0	314
65 ба түүнээс дээш	6.2	20.2	27.3	27.3	19.0	100.0	341
<i>Хүйс</i>							
Эрэгтэй	9.6	23.3	28.9	21.5	16.7	100.0	3193
Эмэгтэй	10.4	22.7	28.7	21.5	16.7	100.0	3654
<i>Гэрлэлтийн байдал*</i>							
Огт гэрлээгүй	9.8	25.3	31.2	19.6	14.1	100.0	1909
Батлуулсан гэр бүлтэй	6.6	18.4	28.8	25.0	21.2	100.0	2052
Батлуулаагүй гэр бүлтэй	13.8	23.0	24.0	20.8	18.4	100.0	491
Тусгаарласан	14.6	26.8	24.4	15.9	18.3	100.0	82
Салсан	14.2	23.3	32.5	20.0	10.0	100.0	120
Бэлэвсэн	8.0	25.8	28.6	21.6	16.0	100.0	399
Нийт	10.0	23.0	28.8	21.5	16.7	100.0	6847

Тэмдэглэл: *- 15 ба түүнээс дээш хүн амын хувьд тооцогдсон.

Ядуу, ядуу бус бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүн амын эзлэх хувийн жин адил байна. Харин гэрлэлтийн байдлын хувьд тусгаарласан, салсан хүн амын амьжиргааны түвшин хамгийн доогуур байхад баталгаатай гэр бүлтэй хүн амын амьжиргааны түвшин хамгийн өндөр байна.

Ядуурал


Тухайн өрхийн хүүхдийн тоо, өрхөд амьдарч буй нийт хүн амын тоо, өрхөд амьдарч байгаа гэр бүлийн тоо зэрэг гэр бүлийн шинж байдлын үзүүлэлтүүд хүн амын, цаашлаад өрхийн амьжиргааны түвшинд ихээхэн нөлөөтэй болох нь Хүснэгт 7.6-аас харагдаж байна. Хүүхдийн тоо, өрхөд амьдарч байгаа хүн амын тоо нэмэгдэхэд амьжиргааны түвшин буурч байна. Тухайлбал, хүүхэдгүй өрхийн ердөө 9.3 хувь нь ядуу, гурваас дээш хүүхэдтэй өрхийн 44.3 хувь нь ядуу амьдарч байна.

Хүснэгт 7.6 *Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, өрхийн шинж байдлаар*


Өрхийн байдал	шинж	Амьжиргааны түвшин						
		Нэн ядуу	Ядуу	Ядуу бус, бага орлоготой	Ядуу бус, дунд орлоготой	Ядуу бус, чинээлэг		
Бүгд								
<hr/>								
<i>Хүүхдийн тоо</i>								
Хүүхэдгүй		0.8	8.5	20.8	28.4	41.5	100.0	234
1-2		5.0	14.7	25.7	27.8	26.8	100.0	801
3+		13.8	30.5	31.7	16.4	7.6	100.0	465
<i>Өрхөд амьдарч буй хүний тоо</i>								
1-2		1.1	2.8	13.4	30.7	52.0	100.0	179
3-5		4.8	15.9	26.8	27.2	25.3	100.0	951
6+		15.7	33.2	33.2	14.1	3.8	100.0	370
<i>Өрхөд амьдарч буй гэр бүлийн тоо</i>								
1		6.0	16.9	25.0	26.0	26.1	100.0	1252
2+		12.5	27.0	35.9	16.5	8.1	100.0	248
<i>Хороондоо бүртгэлтэй эсэх</i>								
Бүртгэлтэй		6.6	18.9	27.9	24.0	22.6	100.0	1356
Бүртгэлгүй		11.8	16.0	16.7	27.8	27.7	100.0	144
Нийт		7.1	18.6	26.8	24.4	23.1	100.0	1500

Холимог буюу нэгээс дээш гэр бүл амьдардаг өрхийн амьжиргааны түвшин дан буюу ганцхан гэр бүл амьдардаг өрхийнхөөс харьцангуй доогуур байна. Энэ нь холимог өрхийн 2/3 нь 6 ба түүнээс дээш хүнтэй өрхүүд байгаатай холбоотой юм.

Оршин суугаа хорооныхоо засаг захиргаанд бүртгэлгүй нэн ядуу өрхүүдийн хувь хороондоо бүртгэлтэй өрхүүдээс өндөр байна. Гэхдээ бүртгэлгүй өрхүүдийн хувийн жин ерөнхийдөө бага байгаа юм.



Гэр, байшин хорооллын хүн амын амьжиргааны түвшин эрс ялгаатай байгааг Зураг 7.6-аас харж болно. Гэр хороололд оршин суугчдын 45 хувь нь ядуу байхад, байшин хороололд оршин суугчдын ердөө 15 хувь нь ядуу амьдарч байна.



Амьжиргааны түвшин нь шилжилтийн байдлаар ялгаа багатай байгааг Зураг 7.7-с харж болно. Ерөнхийдөө шилжин ирсэн хүн амын 37.3 хувь, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын 30.6 хувь нь ядуу амьдарч байна. Бүлгийн ярилцлагаар энэ дүр зураг бас батлагдсан юм.

“Манай хорооны ядуу иргэдийн 30-40 хувийг хөдөөнөөс шилжиж ирсэн иргэд эзэлж байгаа бөгөөд эдгээр иргэд хөдөө цас, зуднаар малаа алдсаны улмаас хот, суурин газарт ирж зөвшөөрөлгүй газар ганц гэрээ барин буусан, төрөөс гуйлга гуйсан хүмүүс л байна.”

(Д, Эмэгтэй, нас 40, хорооны Засаг дарга, СХД)

Ядуурал

Хүснэгт 7.7 Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, дүүргээр

Дүүрэг	Амьжиргааны түвшин					Бүгд	Нийт өрхийн тоо
	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус, бага орлоготой	Ядуу бус дунд орлоготой	Ядуу бус, чинээлэг		
Баянзүрх	9.0	21.5	24.5	25.0	20.0	100.0	200
Налайх	10.0	27.0	36.0	17.0	10.0	100.0	100
Сүхбаатар	4.0	14.9	19.1	23.4	38.6	100.0	350
Сонгинохайрхан	7.4	19.6	29.8	27.2	16.0	100.0	500
Хан-Уул	5.0	13.0	27.0	28.0	27.0	100.0	100
Чингэлтэй	8.8	18.4	29.6	21.2	22.0	100.0	250
Нийт	7.1	18.6	26.8	24.4	23.1	100.0	1500

Хотод шилжин ирэгсдийн 72.7 хувь нь (Хүснэгт 7.7) Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд харьяалагдаж байна. Эдгээр дүүргүүд нь хотын захад байрладаг, мөн хөдөөгөөс шилжин ирсэн өрхүүд зөвшөөрөлгүйгээр оршин суух буюу газар нутгийн хувьд тэлэх боломжтой нь шилжин ирэгсдийг хүлээн авах гол бүс болоход нөлөөлж, улмаар эдгээр дүүргүүдэд ядуурал өндөр байх үндэс болж байна. Эдгээр дүүргүүдийн гэр хороололд нийслэлийн нийт гэр хорооллын 74.6 хувь нь харьяалагдаж байна.

Харин Налайх дүүргийн хувьд шилжин ирэгсэд хамгийн бага буюу ердөө 2.8 хувийн эзэлж байгаа боловч ядуурлын түвшин хамгийн өндөр, өрхүүдийн амьжиргааны түвшин маш доогуур байна. Налайх дүүрэг хотын төвийн дүүргүүдтэй харьцуулахад хөгжлөөр хоцрогдмол дүүрэг бөгөөд тус дүүргийн нийт өрхийн 40 орчим хувь нь ядуу амьдарч байна. Эдгээр хүмүүс чухам яагаад ядуу амьдарч байгаа талаар дараа авч үзэх болно.

Байшин хороололд амьдарч байгаа өрхүүдийн амьжиргааны түвшин харьцангуй өндөр байгаагаас хамааран байшин хороололд оршин суугчид олонтой дүүрэгт амьжиргааны түвшин өндөр байна. Тухайлбал, Сүхбаатар дүүргийн нийт өрхийн 18.9 хувь нь ядуу байгаа ба энэ нь ядуурал хамгийн өндөр байгаа Налайх дүүрэгтэй харьцуулахад 18.1 пунктээр бага үзүүлэлт юм. Ядуу бус чинээлэг амьдарч байгаа өрхүүдийн хувь Сүхбаатар дүүрэгт хотын дунджаас хамгийн өндөр байхад, Налайх дүүрэгт хамгийн бага байна. Энэ нь Налайх дүүрэгт өрхийн амьжиргааны түвшин доогуур байгааг давхар баталж байна.

Хүн амын боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлыг амьжиргааны түвшингээр Хүснэгт 7.8-д харуулав.

Хүснэгт 7.8 15 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Амьжиргааны түвшин					Бүгд	15-аас дээш насны хүн амын тоо
	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус бага орлоготой	Ядуу бус дунд орлоготой	Ядуу бус чинээлэг		
<i>Боловсролын түвшин</i>							
Огт боловсролгүй	16.9	33.1	28.7	16.2	5.1	100.0	136
Бага (4-р анги)	17.6	29.8	25.8	18.7	8.2	100.0	477
Бүрэн бус дунд (8-р анги)	13.7	31.8	27.2	18.6	8.6	100.0	1087
Бүрэн дунд (10-р анги)	8.3	21.8	34.2	20.7	15.1	100.0	1659
Мэргэжлийн	9.3	26.3	33.2	21.5	9.8	100.0	205
Тусгай дунд, бүрэн бус дээд	3.9	20.9	32.5	26.2	16.5	100.0	412
Дээд	2.1	8.5	23.1	28.1	38.1	100.0	1077
<i>Ажил эрхлэлт</i>							
Ажил эрхэлдэг	5.8	18.5	29.4	22.6	23.7	100.0	2166
Ажил эрхэлдэггүй	11.3	25.1	29.1	21.5	13.0	100.0	2887
<i>Ажиллаж буй сектор*</i>							
Албан	5.7	17.5	31.1	21.8	23.9	100.0	1471
Албан бус	6.3	21.1	25.7	23.5	23.4	100.0	654
Нийт	8.9	22.3	29.3	22.0	17.6	100.0	5053

Ажил эрхэлдэг хүн амын 5.8 хувь нь нэн ядуу амьдарч байхад ажил эрхэлдэггүй хүн амын 11.3 хувь нь нэн ядуу амьдарч байна. Ойролцоогоор ажил эрхэлдэг 10 хүн тутмын 8 нь ядуу бус байхад ажил эрхэлдэггүй 10 хүн тутмын 6 нь ядуу бус байна. Хүмүүсийн хөдөлмөрийн хөлс буюу түүнтэй адилтгах орлого нь тэдний амьжиргааны чухал эх үүсвэр бөгөөд ямар нэгэн ажил эрхлэх нь ядуурлаас ангид аж төрөхийн төлөө хийж буй нэг алхам гэдгийг бүлгийн ярилцлагын дүн харуулж байна.

“Хүн ер нь зөв аргаа олоод хичээж чадвал сайхан амьдарч, ажиллах боломж байдаг гэж би боддог. Нөхөр бид 2 анх хөдөөнөөс амьдралаа дээшлүүлэх гэж энд ирээд эхэндээ үнэхээр хэцүү байсан. Зарим үед шантарч байсан. Зах дээр хувцас хийж зардаг ажлаас эхлээд одоо урдаас бараа авчирч зардаг болсон. Анх хөдлөхдөө хүнээс зээл авч хөдлөж байсан одоо бүх өрөө төлчихсөн, дажгүй байгаа. Хөдөө амьдарч байснаас хамаагүй дээр байна.”

(Д. эмэгтэй, нас 29, хувиараа наймаа эрхлэгч, СХД)

Ядуу өрхийн гишүүд ажилд орох боломжоор хязгаарлагдмал байдаг нь ядуурал нэмэгдэхэд нөлөө үзүүлж байна.


“Насны хязгаарлалт тавьсан байдаг, бас царай зүс харна. Аль болох гайгүй хувцсаа өмсөөд л очно. Гэвч цэвэрлэгчээр ч тоож авахгүй. Өнөө үед ажилд ороход хүртэл мөнгөтэй хүнтэй л харьцдаг болжээ. Эцэст нь би яаж ч хөөцөлдөөд ажилд орж чадахгүй юм байна гэдгийг ойлгосон шүү”

(Н. эмэгтэй, нас 49, ажилгүй, БЗД)

Ядуурал

Албан бус секторт ажилладаг хүн амын 27.4 хувь нь ядуу байхад албан секторт ажиллагсдын 23.2 хувь нь ядуу амьдарч байна. Энэ нь секторууд дахь цалингийн ялгаатай байдлын илрэл болж байна (Хүснэгт 7.8-г харна уу).

Ерөнхийдөө, хүн амын амьжиргааны түвшин доройтохын хэрээр сууцны нөхцөл муудсан байна. Хүмүүс ахуй нөхцөл муутай орчинд амьдрах тусам өвчлөмтгий болдог ба энэ нь эргээд хүмүүс ядуу амьдрахын бас нэг үндсэн нөхцөл болж байна. Ахуй нөхцлийн хувьд аж төрөхөд манайдаа л хамгийн орчин үеийн гэж хэлж болохуйц сууц буюу нийтийн сууцны доторхи сууцанд амьдарч байгаа хүн амын ядуурал хамгийн бага байна. Нийтийн сууцны доторх сууцанд амьдарч байгаа ядуусын дийлэнх нь хотын захын байшин хорооллынхон байна (Зураг 7.8).



Сууцны эзэмшил нь амьжиргааны түвшингээр төдийлөн ялгаатай бус дүр зураг ажиглагдсан байна (Хүснэгт 7.9). Амьдарч буй сууцнаас гадна ямар нэгэн амбаар, гарааш, зорьтой эсэхээр хүмүүсийн амьжиргааны түвшинг судлахад ялгаа бага гарсан ба энэ нь амьжиргааны түвшинг тодорхойлоход нэг их нөлөөтэй үзүүлэлт биш байв. Харин эдгээр нь тухайн хүний амьжиргааны түвшингээс хамааран барьсан материал, үнэ өртөг, үзэмж, зориулалт, хэмжээ зэргээрээ нэлээд ялгаатай байгааг дурьдах нь зүйтэй болов уу.

Хүснэгт 7.9 *Өрхийн хувийн жин, амьжиргааны түвшин, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Амьжиргааны түвшин					Бүгд	
	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус, бага орлоготой	Ядуу бус, дунд орлоготой	Ядуу бус, чинээлэг		
Сууцны эзэмшил*							
Өөрийн эзэмшлийн	6.6	18.6	28.0	24.4	22.4	100.0	1288
Өөрийн эзэмшлийн бус	5.6	17.8	19.4	26.1	31.1	100.0	180
Илүү гэр/амбаар/ гарааштай эсэх*							
Байдаг	4.8	19.3	26.8	22.0	27.1	100.0	482
Байдаггүй	7.3	18.2	27.0	25.9	21.6	100.0	986
Зурагт, хөргөгчтэй эсэх							
Аль аль нь байгаа	3.6	14.6	27.0	26.4	28.4	100.0	1098
Аль нэг нь байгаа	12.8	29.4	29.0	19.4	9.4	100.0	310
Аль аль нь байхгүй	29.3	30.4	17.4	17.4	5.5	100.0	92
Нийт	7.1	18.6	26.8	24.4	23.1	100.0	1500

Тэмдэглэл: * сууцны бус байранд амьдарч буй өрхүүдээс асуугаагүй.

Амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр ахуйн хэрэглээний зүйлс дундаас хөргөгч, зурагтын хэрэглээ нэмэгдсэн зүй тогтол ажиглагдсан байна.

Эдгээр зүйлс байгаа эсэх нь тухайн өрхийн амьжиргааны түвшинг харуулах үзүүлэлт болохыг Хүснэгт 7.9-өөс харж болно. Нэн ядуу өрхийн 29.3 хувьд нь эдгээр хэрэгслүүд байхгүй байхад, зурагт, хөргөгчийн аль аль нь байгаа өрхийн ердөө 3.6 хувь нь л ядуучууд байна. Үүнээс чинээлэг өрхүүдэд хөргөгчөөс эхлээд тээврийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн хэрэглээний зүйлстэй байна, харин ядуу хүмүүс амьдралын наад захын ахуйн хэрэглээний зүйлсээр дутмаг амьдарч байна гэж үзэж болохоор байна (бараг 4 өрх тутмын нэг нь тээврийн хэрэгсэлтэй ба тэдний 3/4 орчим нь ядуу бус дундаас дээш амьдралтай өрхүүд байв).

7.4 Ядуучуудад чиглэсэн үйл ажиллагаа


Өмнөх хэсэгт ядуу болон ядуу бус өрхүүдийн амьдралын нөхцлийг харьцуулан харуулсан. Энэ хэсэгт ч эдгээрийг нэлээд дэлгэрэнгүй харуулахыг гол зорилгоо болгосон. Энд ахуйн нөхцөл, боловсрол, эрүүл мэнд гэх мэт гол үзүүлэлтүүдийг графикаар харуулах юм. Графикууд нь ядуу өрхүүд ямар хэмжээгээр амьдралын нөхцлийн тодорхой үзүүлэлтүүдээр хязгаарлагдаж байгааг, эдгээр хязгаарлалт нь

Ядуурал

ядуурлын үзүүлэлт болж байгаа эсэх, түүнчлэн энэ нь ядуу бус өрхүүдийн хувьд ч гэсэн тулгамдсан асуудал мөн эсэхийг харуулах юм. Эдгээр асуудлууд нь ядуу, ядуу бус бүлэгт аль алинд нь нөлөөлж болох үйл ажиллагааны ижил хэмжигдэхүүн байж болно. Гэвч ядуучуудад чиглэсэн үйл ажиллагааг тооцохын тулд ядуу өрхүүдэд эдгээр хязгаарлалт ямар байгааг ядуу бус өрхүүдэд хэр байгаагаас илүүтэйгээр анхаарч үзэх хэрэгтэй. Дараах зурагнууд ямар асуудлууд эдгээр хоёр бүлэгт аль алинд нөлөөлж байгаа, мөн ямар асуудлууд зөвхөн ядуу бус өрхөд нөлөөлж байгааг харуулах юм.

Ядуу өрхүүдийн 85 хувь нь эрүүл ахуйн хүртээмж дутмаг (боловсон жорлон дутмаг байдлаар тодорхойлогдсон) байна. Түүнчлэн ядуу бус өрхүүдийн хувьд ч гэсэн зөвхөн тал хувь нь л боловсон бие засах газартай байгаа нь зурагнаас харагдаж байна. Ядуу, ядуу бус бүлгийн хоорондох ялгаа маш их, эрүүл ахуйн нөхцөл ядуу өрхүүдэд илүү их хүндээр тусаж байна. Өөр нэг жишээ бол цэвэр усны хүртээмжийн асуудал юм. Үүнийг ядуучуудын хувьд ихээхэн хэмжээгээр нөлөөлхүйц тулгамдсан асуудал биш гэж үзэж байна. Ядуу өрхүүдийн 17 хувь нь цэвэр ус хүртэх боломжгүй гэсэн бол ядуу бус өрхүүдийн 8 хувь нь мөн л цэвэр ус хүртэх боломжгүй байгаа ажээ. Иймд усны нөөцийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна.

Зураг 7.9 Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Ахуйн нөхцөл



Зураг 7.10 Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Боловсрол


Боловсрол: ядуу ба ядуу бус бүлгүүдийн хоорондын ялгаа



Энэ аргаар бид бусад үзүүлэлтүүд, тухайлбал боловсролыг авч үзэж болох юм. Хэдийгээр сургуульд суралцах боломж сайн ч гэсэн боловсролын түвшинг нь анхаарч үзэх хэрэгтэй. Хөгжиж байгаа бусад орнуудтай харьцуулахад Монголд сургуульд хамрагдалтын түвшин харьцангуй өндөр байдаг. Зарим орнуудад хэрэв бүх хүүхдүүд сургуульд хамрагдаад анхан шатны сургууль төгссөн бол нэлээн амжилтанд хүрсэн гэж үздэг. Энэ нь боловсролд цааш нь нэг их анхаарал хандуулах шаардлага байхгүй гэсэн үг үү? Гэхдээ хараахан тэгж хэлж болохгүй юм. Эдгээр зурагнууд анги дүүргэлт (сурагчдын тоо хэт их) болон боловсролын чанарын талаар ямар нэгэн зүйлийг өгүүлээгүй.

Зураг 7.11 **Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Эрүүл мэнд**

Эрүүл мэнд: ядуу ба ядуу бус бүлгүүдийн хоорондын ялгаа




Тэмдэглэл: ядуу: n=2258 хүн
ядуу бус: n=4589 хүн

Ядуурал

Судалгааны дүнгээс үзэхэд эрүүл мэндийн үйлчилгээгээр харьцангуй сайн хангагджээ. Харин хамгийн их ялгаа эрүүл мэндийн даатгалын асуудалд байна.


Боловсролтой адил, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чамлалтгүй харагдаж байна. Ядуучуудын 75 хувь нь эрүүл мэндийн даатгалтай байгаа нь нэлээд том амжилт гэж хэлж болно. Нөгөө талаас хүн амын дөрөвний нэг нь (бүх ядуучууд гэхгүйгээр) даатгалгүй байгааг анхааралдаа авч, төр засгийн зүгээс ажил хэрэг болгох хэрэгтэй. Ядуу болон ядуу бус өрхүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын ялгаа бага байгаа болохоор зөвхөн ядуу өрхүүдэд анхаарлаа хандуулна гэсэн үг биш юм. Зурагнаас мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг харж болохыг тэмдэглэх хэрэгтэй. Үйлчилгээний чанар бол өөр асуудал бөгөөд тоон судалгаанд ороогүй.

Зураг 7.12 **Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Ажил эрхлэлт ба нийгмийн оролцоо**



Ажил эрхлэлтийг авч үзвэл ядуу, ядуу бус бүлгийн хооронд нэлээд ялгаатай байна. Ажил эрхлэлтийг ядуурлаас гарах арга гэж үздэг. Ийм ч учраас ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 7.13 Ядуу болон ядуу бус бүлгийн хоорондох ялгаа: Бүртгэл ба орлогын эх үүсвэр



Энд нэг сонирхол татсан үзүүлэлт бол өөрийн амьдарч буй сууцнаас гадна өөр байр, гэр, саравчтай байгаа талаар авч үзэхэд ядуу, ядуу бус өрхүүдийн хувьд нэг их ялгаа байхгүй байгаа явдал юм. Ер нь ядуу бус өрхүүд өөрийн амьдарч буй сууцнаас гадна өөр байр, гэр, саравчтай байх боломж өндөр байдаг. Гэтэл ядуу өрхүүдийн хувьд ч мөн энэ боломж ижил байна. Ядуучуудын хувьд оршин суугаа газартаа бүртгүүлэх нь бага, үүнээс шалтгаалан нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй, нэлээд хэцүү гэж зарим хүмүүс үздэг. Судалгааны үр дүнгээс үзэхэд бүртгэлийн асуудал ядууралтай холбоотой асуудал гэдэг нь төдийлэн ялгарч харагдахгүй, ядуу бус өрхүүд ч ядуу өрхтэй ижил хэмжээтэйгээр бүртгэл хийлгээгүй байлаа. Харин шилжих хөдөлгөөний бүртгэлийн асуудал нийгмийн үйлчилгээ хүртэхэд нэлээд хүндрэл учруулж болзошгүй тул бүртгэлийг хялбар, олон шат дамжлагагүй болгох хэрэгтэй (8.6-р хэсгээс үзнэ үү).

7.5 Үйл ажиллагааны хамгийн чухал хэсгүүд

Ядуучуудын асуудлуудад чиглэгдсэн дээрх үр дүнг яаж үйл ажиллагааны чухал хэсэг болгох вэ? Энд авч үзсэн үзүүлэлт тус бүр (орон сууц, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, бүртгэл) нь маш олон төрлийн үйл ажиллагааг яаралтай хийх шаардлагатайг харуулж байна. Мэдээж эдгээр бүх асуудлыг нэгэн зэрэг хийж чадахгүй ойлгомжтой. Иймээс бүх хүрээний асуудлуудаас хамгийн гол, чухлыг нь тодорхойлон гаргах хэрэгтэй. Үүнийг яаж хийх вэ?

Ядуучуудад чиглэгдсэн үйл ажиллагааны хамгийн чухал хэсгийг дараах хоёр үзүүлэлтээр тодорхойлох хэрэгтэй. Үүнд:

- Хязгаарлагдмал байдлын зэрэг: **Ядуучуудын хувьд ямар үйлчилгээ дутмаг байна вэ?**

Ядуурал

- Ядуу болон ядуу ядуу бусын хоорондох ялгаа: **Ямар асуудлууд, ялангуяа ядуучуудад чиглэгдэж байна вэ? Ядуу болон ядуу бусын хоорондох ялгаа хэр байна вэ?**

Зураг 7.14 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд 1*

Ахуй нөхцөл: Ядуучуудын байдал, ядуу болон ядуу бус хүмүүстэй харьцуулах нь



Зураг 7.15 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд 2*


Ядуучуудын дунджаар 66 хувь нь 10 үндсэн үзүүлэлтийн (орон сууц, эрүүл мэнд, боловсрол) хувьд хүртээмж сайн байна. Ядуу болон ядуу бус хүмүүсийн ялгаа 15 хувь.



Үзүүлэлтүүдийг нэгэн зэрэг хамтад нь авч үзсэнээр хамгийн чухал хэсгүүдийг тодорхойлох боломжтой болно.


Зураг 7.16 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд 3*

Дөрвөн тэгш өнцөгтөд үйл ажиллагааны чиглэлийг ач холбогдлын хувьд харуулав. Зүүн дээд тэгш өнцөгтөд хүртээмж хамгийн муу бөгөөд ялгаа хамгийн их байгаа үзүүлэлтийг харуулна.




Зураг 7.17 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Ахуйн нөхцөл*

Баруун талын тэгш өнцөгтөд харуулсан үзүүлэлтүүдийн хувьд хүртээмж харьцангуй сайн бөгөөд ядуучууд болон ядуу бус хүмүүсийн ялгаа бага байна.




Зураг 7.18 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Боловсролын хүртээмж*

Боловсрол: Боловсролын асуудалд тодорхой анхаарал хандуулах шаардлагатай байна.




Зураг 7.19 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Эрүүл мэндийн хүртээмж*

Эрүүл мэндийн бүх үзүүлэлтүүд сайн байна (гэхдээ зөвхөн хүртэх боломжийг илэрхийлж байгаа).



Зураг 7.20 *Оролцооны хамгийн чухал хэсгүүд: Орон сууц, боловсрол ба эрүүл мэнд*

Цогц байдлаар харахад ахуйн нөхцлийг сайжруулах болон боловсролд тодорхой анхаарлыг хандуулах нь зүйтэй байна.



7.5.1 Хэсгийн дүгнэлт

Үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг нь сууцны ахуйн нөхцөл болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах явдал юм. Хэдийгээр бид эдгээр үйлчилгээний чанарыг тоогоор хэмжиж чадахгүй ч эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа нь харагдаж байна. Харин чанарын судалгааны үр дүнгээс (5-р бүлгийн нийгмийн үйлчилгээний хүртээмж хэсэг) мэдэгдэхүйц чанарын асуудал байгааг харж болно.

7.6 Ядуурлыг судлах

Ядуурлыг судлахад гардаг түгээмэл бэрхшээлийн нэг бол ядуурлыг тодорхойлох асуудал байдаг. Амьжиргааны түвшин буюу ядуурлыг тодорхойлох ихэнх аргууд нь орлоготой холбоотой аргууд байдаг билээ. Хүн амын амьжиргааны түвшинг зөвхөн орлого, эсвэл хүнсний болон хүнсний бус хэрэглээгээ хангаж буй зарлагаар хэмжиж тодорхойлох нь дэндүү хязгаарлагдмал юм. Нобелийн шагналт эдийн засагч Амартия Сэн ядуурлыг зөвхөн бага орлогоор бус, харин чадавхийн (сургуульд суралцах, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломж, хүртээмж) дутагдлаар илэрхийлэх нь чухал гэжээ.

7.6.1 Хүртээмжийн ядуурал

Тухайн хүн амын сайн сайхан амьдралыг тодорхойлогч үндсэн үзүүлэлтүүдэд тэдний боловсрол, эрүүл мэндийн байдал болон орчин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд зүй ёсоор багтдаг бөгөөд эдгээр нь нийгмийн хүртээмжийг тодорхойлдог. Нөхцөл байдлын ядуурлыг тодорхойлохдоо сууцны ахуйн нөхцөл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэх бүлэг үзүүлэлтүүдийг багтаасан индексээр тодорхойлсон. Үнд дараах есөн хувьсагчийг оруулав.

- Сууцны төрөл,

Ядуурал

- Цахилгааны хангамж,
- Ундны усны эх үүсвэр,
- Хог хаягдлыг хэрхэн зайлуулдаг,
- Бие засах газрын төрөл;
- Эмч, эмнэлгийн байгууллагад хандан тусламж авах боломж,
- Эрүүл мэндийн даатгалтай эсэх,
- Өрхийн эмнэлгээс алслагдсан байдал;
- Ерөнхий боловсролын сургуулиас алслагдсан байдал.

Ахуйн болон боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнүүд хувь хүний хувьд ижил ач холбогдолтой гэж үзэн дээрх асуултуудын хоёрны гуравт нь эерэг хариулт өгсөн хүнийг *ядуу бус*, гуравны нэгээс бага асуултад эерэг хариу өгсөн хүнийг *ядуу* гэсэн ангилалд багтаан авч үзлээ. Энэхүү индексийг тодорхойлох үзүүлэлтүүдийг гагцхүү бидний судлаачийн байр сууринаас хандан сонгосон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн индекст тусч буй асуудлуудын жингийн талаар асуудал гарч байгаа юм. Тухайлбал, боловсролын хүртээмжийг нэг асуултаар төлөөлүүлсэн байхад ахуйн нөхцлийн таван асуултыг авч үзсэн. Бид хүртээмжийг тодорхойлох зарчмыг баримталсан бөгөөд юуны түрүүнд үүнийг сургууль хэр ойрхон байгаагаар тодорхойлж болно гэж үзсэн. Хүртээмжийг сургууль төгсөлтийн хувь буюу боловсролын чанартай илүү хамааралтай байх болов уу. Түүнчлэн зарим хүмүүс боловсролын хүртээмж гэдэг нь чанартай боловсролын хүртээмж байх ёстой гэж үздэг байж болно. Тэгвэл чанартай боловсрол гэж бид юуг хэлэх вэ? 25-аас илүүгүй сурагчтай ангийг хэлэх үү? Эсвэл энэ нь багшийн мэргэжлийн ур чадвараас хамаарах уу? Ийнхүү асуудлыг улам өргөжүүлж болох боловч бид тухайн хүн хүссэн үедээ хамгийн наад захын боловсрол, эмнэлгийн үйлчилгээг хүртэх боломжийг л авч үзсэн болно.

Тухайн индексэд орсон зарим үзүүлэлтүүдийг тусд нь тооцож үзэхэд харьцангуй сайн үзүүлэлтүүд гарсан. Энэ нь Монгол улс сургууль, эмнэлгийн тоо болон нэг эмч, нэг багшид ногдох хүний тоо, сургуульд хамрагдалт, бичиг үсэг тайлагдалт зэрэг үзүүлэлтээрээ эрүүл мэнд, боловсролын тогтолцооны харьцангуй өндөр хөгжилд хүрч чадсантай холбоотой юм (Монгол улсын Засгийн газар, НҮБХХ, 2003).

Хүмүүс ямар нөхцөлд амьдарч байгаа нь тэдний амьдралын сайн сайхан байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлт юм. Энэхүү индексийн үр дүнг судалгаанд хамрагдагчдын хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн ялгавартай байдлаар Хүснэгт 7.10-т харуулав.

Хүснэгт 7.10 Хүн амын хувийн жин, хүртээмжийн ядуурал, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хүртээмж		
	Ядуу	Ядуу бус	Тоо
Шилжилтийн байдал**			
Шилжигч	54.8	45.2	688
Шилжигч бус	20.7	79.3	4024
Байршил			
Гэр хороолол	39.3	60.7	4070
Байшин хороолол	2.9	97.1	2777
Дүүрэг			
Баянзүрх	37.3	62.7	909
Налайх	31.7	68.3	492
Сүхбаатар	14.4	85.6	1448
Сонгинохайрхан	28.2	71.8	2344

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Хан-Уул	13.7	86.3	481
Чингэлтэй	21.1	78.9	1173
Нас			
17 хүртэл	22.7	77.3	2190
17-25	28.4	71.6	1468
26-59	25.1	74.9	2683
60 ба түүнээс дээш	18.0	82.0	506
Хүйс			
Эрэгтэй	24.9	75.1	3193
Эмэгтэй	24.2	75.8	3654
Яс, үндэс			
Халх	23.9	76.1	6035
Казак	45.7	54.3	173
Дөрвөд	31.0	69.0	171
Буриад	9.8	90.2	112
Баяд	23.9	76.1	142
Бусад	27.1	72.9	214
Өрхөд амьдарч буй хүний тоо			
1-2	22.5	77.5	306
3-4	19.6	80.4	2393
5-6	24.7	75.3	2425
7+	31.5	68.5	1723
Боловсролын түвшин*			
Боловсролгүй/ бага	32.8	67.2	613
Бүрэн бус дунд	34.7	65.3	1087
Бүрэн дунд	26.5	73.5	1659
Мэргэжлийн/тусгай дунд/дээд	14.8	85.2	1694
Бүртгэлийн байдал			
Бүртгэлтэй	22.1	77.9	6241
Бүртгэлгүй	49.5	50.5	606
Ажил эрхлэлтийн сектор***			
Албан	19.6	80.4	1471
Албан бус	30.4	69.6	654
Гадаадад	12.2	87.8	41
Орлого олдог эсэх*			
Тийм	22.7	77.3	2166
Үгүй	26.9	73.1	2887
Сууцны төрөл			
Гэр	72.0	28.0	1356
Бусад	12.8	87.2	5491
Тоо	1680	5167	6847
Бүгд	24.5	75.5	100.0
*	15 ба түүнээс дээш насны хүн ам (n=5053)		
**	6 ба түүнээс дээш насны хүн ам (n=6200)		
***	15-64 насны хүн ам (n=4712)		
****	7 ба түүнээс дээш насны хүн ам (n=2166)		

Ядуурал

Хүртээмжийн ядуурал шилжигчдийн дунд эрс өндөр байна. Хотод шилжин ирэгчдийн бараг тал илүү хувь (54.8 хувь) нь хүртээмжийн ядууралд өртөж шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амынхаас 2 дахин өндөр байлаа. Өөрөөр хэлбэл, шилжигч хүн ам нийгмийн үйлчилгээнээс тэгш хүртэж чадахгүй байгаа байдал энд илүүтэй илэрч байна.

Дүүргүүдийн хувьд Баянзүрх (37.3 хувь), Налайх (31.7 хувь) дүүргүүдэд амьдарч буй хүн амын дунд хүртээмжийн ядуурал хамгийн өндөр байна. Эдгээр дүүргүүдэд ядуурлын бүхий л төрөл хамгийн илүүтэй илэрч байгааг харж болохоор байна. Харин Сүхбаатар (хотын төвийн дүүрэг), Хан-Уул дүүргүүдийн хүн амын дунд хүртээмжийн ядуурал (14 орчим хувь) бусад дүүргүүдээс бага байна. Эдгээр дүүрэгт орон нутгаас шилжин ирэгчэд харьцангуй бага амьдардагтай холбоотой байж болох юм.

Хүртээмжийн ядуурлын хувьд нас, хүйсийн хувьд онц ялгаа ажиглагдахгүй байна. Ястан, үндэстний хүртээмжийн ядуурлын ялгаа нэлээд тод харагдаж байна. Тухайлбал, казакуудын 45.7 хувь ядуу байхад буриадуудын 10 хүрэхгүй хувь ядуу байна. Түүнчлэн дөрвөдүүдийн багагүй хувь (31 хувь) ядуу байна. Магадгүй хүртээмжийн ядуу байдал ястан, үндэстний соёл, зан заншлаас хамаарч болох боловч ядуурлын ястан, үндэстний ялгавартай байдлыг илүү нарийвчлан судлах шаардлага байгааг дахин харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад боловсрол ядуурлын бүх үзүүлэлтэд ихээхэн нөлөөлж байна. Бүрэн бус дунд боловсролтой хүн амын дунд хүртээмжийн ядуурал хамгийн өндөр буюу 34.7 хувь байхад тусгай дунд, бүрэн бус дээд болон дээд боловсролтой хүн амын 14.8 хувь ядуу байна.

Оршин суугаа хороондоо бүртгэлгүй хүн амын тал хувь хүртээмжийн ядуу байдалд амьдарцгааж байна. Бүртгэл нь хүмүүсийн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнээс хүртэх боломжийг боогдуулж байдгийг өмнөх судалгаануудын нэгэн адил манай судалгааны үр дүн мөн нотолж байна.

Хүртээмжийн ядуурлын индексийг судалгаанд хамрагдагсдын амьдарч буй сууцны төрлөөр авч үзэхэд эрс ялгаатай байна. Хэдийгээр уламжлалт сууц болох гэр нь нүүдэлчин ахуйтай ард түмэнд чухал ач холбогдолтой билээ. Гэхдээ хот, суурин газар амьдарч буй хүмүүст аж төрөх зохистой нөхцлийг гэр төдийлөн хангаж чадахгүй байгаагаар холбоотой юм.

7.6.2 Нийгмийн оролцооны ядуурал

Тухайн хүн мэдлэг мэдээлэл авдаг, тодорхой хамт олны хүрээлэлтэй, нийгэмд эзлэх тодорхой байр суурьтай байх явдал ядуу эсэхийг нь тодорхойлогч үндсэн үзүүлэлт юм. Судалгаанд нийгмийн оролцооны ядуурлыг тодорхойлохдоо гурван асуудлыг авч үзсэн. Үүнд өрхийн өдөр тутмын амьдралд танил хүрээллийнхэн тусалдаг эсэх, тухайн өрхийн гишүүд дүүрэг/хорооноос зохион байгуулдаг олон нийтийн ажилд оролцдог эсэх, хүн амын амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар мэддэг эсэх зэрэг асуултууд багтсан.

Хүмүүс тодорхой хүрээлэлтэй буюу нөхөрлөлтэй байгаа эсэх нь танил, хамаатан садангийн холбоо амьдралд нь хэр чухал байгаагаар тодорхойлогдоно гэж үзсэн. Учир нь хувь хүний тодорхой хүрээлэл нь өрхийн сайн сайхан амьдралд зохих хувь нэмэр үзүүлдэг билээ.

Ер нь, тухайн хувь хүн найз нөхөд, хамаатан садангийн туслалцаа дэмжлэгийг аваад зогсохгүй өөрөө нийгмийн амьдралд идэвхтэй оролцсноор нийгэмд эзлэх өөрийн байр суурийг тодорхойлж, үг хэлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж буй явдал гэсэн утгаар олон нийтийн ажилд оролцож буй байдлыг нийгмийн оролцооны ядуурлын нэг чухал үзүүлэлтэд багтаан авсан юм.

Хүмүүс цаг үеэсээ хоцрохгүй мэдээлэл авдаг эсэх нь ядуурлыг тодорхойлогч нэг үзүүлэлт болдог. Хүн амын сайн сайхан амьдралд мэдээлэл чухал үүрэгтэй билээ. Тиймээс судалгаагаараа хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийн талаарх мэдлэгийг асуусан юм.

Ийнхүү нийгмийн оролцооны ядуурлын индексийг хүрээ, нийгмийн оролцоо, мэдээллийн хэртээмжээр тодорхойлон гаргасан. Танил, хамаатан садангийн хүрээг ач холбогдлын хувьд өндөрт үзэж, “*тийм*” гэж хариулсан хүмүүсийг *ядуу бус* ангилалд багтаан тодорхойлсон болно. Харин “*үгүй*” гэж хариулсан хүмүүсийг бусад хоёр асуултанд хоёуланд нь “*тийм*” гэж хариулаагүй бол *ядуу* гэж авч үзсэн.

Энэхүү индексийг хүртээмжийн индексийн нэгэн адил ямар нэгэн загвар тогтсон арга зүйд үндэслээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Магадгүй эдгээр гурван асуудлыг нэгтгэх учиргүй гэсэн үзэл санаа байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал, олон нийтийн оролцоо орлого нэмэгдэхийн хэрээр буурдаг гэж үзэж болно. Тэгвэл чинээлэг хүмүүсийн нийгмийн оролцоо хангалтгүй, салангид байдаг гэж үзэж болох уу? Хэрэв тэд ямарч хүрээлэлгүй бол тийм гэж хэлж болох юм. Монголд дотно хүрээ ямар чухал нөлөөтэй болохыг судалгааны дүн харууллаа.

Индексийг хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн ялгавартай байдлаар Хүснэгт 7.11-д харуулав.

Хүснэгт 7.11 Хүн амын хувийн жин, нийгмийн оролцооны ядуурал, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Нийгмийн оролцоо		
	Ядуу	Ядуу бус	Тоо
Шилжилтийн байдал**			
Шилжигч	30.7	69.3	688
Шилжигч бус	23.6	76.4	4024
Байршил			
Гэр хороолол	26.1	73.9	4070
Байшин хороолол	21.6	78.4	2777
Дүүрэг			
Баянзүрх	28.4	71.6	909
Налайх	29.7	70.3	492
Сүхбаатар	25.1	74.9	1448
Сонгинохайрхан	24.4	75.6	2344
Хан-Уул	10.6	89.4	481
Чингэлтэй	23.4	76.6	1173
Нас			
17 хүртэл	24.9	75.1	2190
17-25	24.7	75.3	1468
26-59	24.5	75.5	2683
60 ба түүнээс дээш	19.4	80.6	506

Ядуурал

Хүйс			
Эрэгтэй	24.0	76.0	3193
Эмэгтэй	24.6	75.4	3654
Яс, үндэс			
Халх	23.7	76.3	6035
Казак	41.0	59.0	173
Дөрвөд	19.3	80.7	171
Буриад	21.4	78.6	112
Баяд	28.2	71.8	142
Бусад	31.8	68.2	214
Өрхөд амьдарч буй хүний тоо			
1-2	24.2	75.8	306
3-4	22.9	77.1	2393
5-6	21.4	78.6	2425
7+	30.3	69.7	1723
Боловсролын түвшин*			
Боловсролгүй/ бага	30.0	70.0	613
Бүрэн бус дунд	28.7	71.3	1087
Бүрэн дунд	21.6	78.4	1659
Мэргэжлийн/тусгай дунд/дээд	21.7	78.3	1694
Бүртгэлийн байдал			
Бүртгэлтэй	23.1	76.9	6241
Бүртгэлгүй	36.8	63.2	606
Ажил эрхлэлтийн сектор***			
Албан	25.4	74.6	1471
Албан бус	25.1	74.9	654
Гадаадад	26.8	73.2	41
Орлого олдог эсэх*			
Тийм	25.3	74.7	2166
Үгүй	23.3	76.7	2887
Сууцны төрөл			
Гэр	31.5	68.5	1356
Бусад	22.5	77.5	5491
Тоо	1664	5183	6847
Бүгд	24.3	75.7	100.0

* 15 ба түүнээс дээш насны хүн ам (n=5053)

*** 15-64 насны хүн ам (n=4712)

**** 7 ба түүнээс дээш насны хүн ам (n=2166)

Судалгаанд хамрагдсан хүн амын 24.3 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу гэсэн ангилалд багтаж байна. Хотод шилжин ирэгчдийн 30.7 хувь, харин шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын 23.6 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу гэсэн дүнтэй гарч байна. Шилжин ирэгчдэд шинэ газар дасан зохицох, тухайн газарт өөрийн гэсэн хүрээлэл, найз нөхөдтэй болоход багагүй цаг хугацаа шаардагддаг ажээ. Тиймээс ч тэд нийгмийн оролцооны хувьд тодорхой хугацаанд илүү эмзэг байдалд байх нь аргагүй юм. Гэхдээ шилжих хөдөлгөөнд хамаатан садангийн сүлжээ ихээхэн нөлөөтэй (НХХЯ, ХАССТ, НҮБХАС, 2001) байдаг нь магадгүй шилжигч болон шилжигч бус хүн амын

нийгмийн оролцооны ядуурлын зөрүү харьцангуй бага байхад нөлөөлсөн байж болох талтай юм.

Байршлаар үзэхэд нийгмийн оролцооны ядуурлын ялгавартай байдал гэр, байшин хорооллынхны дунд харьцангуй бага (харгалзан 26.1 хувь ба 21.6 хувь) байна. Өөрөөр хэлбэл, гэр хорооллын оршин суугчдын амьжиргааны түвшин байшин хорооллын оршин суугчидтай харьцуулахад илт доогуур байгаа ч тэд найз нөхөд, танил хүрээлэл, олон нийтийн ажлын оролцоо, мэдээллийн хүртээмжээр гачигдах байдал байшин хорооллынхонтой ойролцоо түвшинд байна.

Нийгмийн оролцоог дүүргүүдээр үзэхэд Хан-Уул дүүргээс бусад дүүрэгт ойролцоо түвшинд байна. Харин Хан-Уул дүүрэгт амьдарч буй хүн амын дийлэнх буюу 89.4 хувь нь ядуу бус гэсэн ангилалд багтаж байна.

Насны бүлгүүд болон хүйсийн хувьд нийгмийн оролцооны түвшин нийт хүн амын ерөнхий хандлагатай адилхан байна. Харин 60-аас дээш насны хүн амын 80 гаруй хувь ядуу бус байгаа нь нас ахих тусам танилын хүрээлэл илүү өргөжиж, олон нийтийн оролцоо ч нэмэгдэж байдагтай холбоотой юм.

Ястан үндэстнүүдийн нийгмийн оролцоон дахь ядуурлын ялгаа нэлээд байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, нийгмийн оролцоогоор хүн амын дийлэнх хувийг бүрдүүлж буй халхуудын 24 орчим хувь нь ядуу байхад казакуудын 41 хувь нь ядуу бүлэгт багтаж байна. Үүнийг зарим судлаачид хэлний бэрхшээлээр тайлбарлан таамагласан байдаг. Гэсэн хэдий ч үндэстэн, ястны ялгаварлал байгаа эсэхийг илүү нарийвчлан судлах шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Хэдийгээр монголчуудын түүхэн хөгжилд ястан, үндэстнүүдийн хоорондын хагарал, тэмцэл бараг гараагүй гэж хэлж болно. Гэхдээ сүүлийн 20 орчим жилд ихээхэн хувьсал өөрчлөлтийг гэтэлж буй нийгмийн нөхцөлд энэ асуудлыг нягтлан судлах нь зүйтэй гэж үзэж байна.

Оршин суугаа хороондоо бүртгэлгүй өрхөд амьдарч буй хүн амын 36.8 хувь, бүртгэлтэй хүн амын 23.1 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу гэсэн дүнтэй гарчээ. Энэ нь өргөн хүрээлэл, танил нөхөдтэй хүмүүсийн хувьд бүртгэлийн асуудал ч илүү хялбар шийдэгдэж болохыг харуулж байж болох юм.


7.6.3 Хүртээмж, нийгмийн оролцооны ядуурлын үзүүлэлтүүд ядуурлын стандарт үзүүлэлтүүдтэй хэрхэн холбоотой байна вэ?

Өмнөх хэсэгт, ядуурлыг хэрэглээ, нийгмийн оролцоо, хүртээмжийн талаас нь салангид байдлаар авч үзлээ. Одоо бид эдгээр хүчин зүйлийг хамтад нь нэгтгэн зангидаж үзье. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан хүн амын аль хэсэгт ядуурлын хүчин зүйл давхар нэрмээс болдгийг илрүүлж, нийгмийн эмзэг бүлгийн шинж байдлыг тодруулан гаргахыг зорьсон юм.

Зураг 7.21-т ядуу хүн амын хэрэглээ, нийгмийн оролцоо, хүртээмжийн байдлыг харуулав.

Зураг 7.21 Ядуурлын гурван цагираг

Нийт түүврийн 33 хувь орлогын хувьд ядуу байна.




Нийт түүврийн 24 хувь хүртээмжийн хувьд ядуу байна.

Нийт түүврийн 24 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу байна.

Ядуурлын асуудлууд хэрхэн давхцаж байна вэ? Хэдэн хүний хувьд ядуурлын нэгээс илүү асуудал давхцан илэрч байна вэ? Нэгээс илүү ядуурлын асуудал давхцаж буй хүмүүсийг *нийгмийн эмзэг бүлэг* гэж нэрлэсэн.

Зураг 7.22 Ядуурлын гурван цагираг

Нийт түүврийн 33 хувь орлогын хувьд ядуу байна.



Түүврийн 44 хувь аль ч талаараа ядуу бус байна.

Нийт түүврийн 24 хувь хүртээмжийн хувьд ядуу байна.


Нийт түүврийн 24 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу байна.

Түүврийн 21 хувьд ядуурлын хоёроос гурван хүчин зүйл давхар илэрч байна. Энэ бүлэг хүмүүсийг *нийгмийн эмзэг бүлэг* гэж нэрлэсэн болно.

Үүний зэрэгцээгээр амьжиргааны хувьд нэн ядуу бүлгийнхэн ямар бүлэгт хамаарах вэ? Хэрэглээний хувьд нэн ядуу хүмүүс гэж хэн бэ? Доорх зурагт нэн ядуу 10 хувийн 60 хувь нь нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж байна. Нэн ядуу үлдсэн 40 хувийг дэмжлэг туслалцаа шаардлагатай гэж үзэн нийгмийн эмзэг бүлэгт оруулсан.

Зураг 7.23 Нийгмийн эмзэг бүлгийнхэн ба нэн ядуу хүмүүс

Орлогын хувьд нэн ядуу 10 хувь



Нийт түүврийн 24 хувь хүртээмжийн хувьд ядуу байна.

Нийт түүврийн 24 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу байна.

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

Харин нийт эрсдэлтэй бүлгийн хүн амын 3 хувь ядуурлын шугамнаас дээгүүр амьжиргаатай байгааг бас анхаарах ёстой.

Нийгмийн эмзэг бүлгийн хүн амын хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн шинж байдлыг бусад бүлгийнхэнтэй харьцуулан Хүснэгт 7.12-д харуулав.

Шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын 39.1 хувь нийгмийн эмзэг бүлэгт багтаж, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүстэй харьцуулахад 17 пунктээр өндөр байна. Бид өмнөх хэсгүүдэд ядуурлын хүчин зүйлийг судлан үзэхэд шилжигч болон шилжигч бус хүн амын ялгаа хүртээмжийн ядуурлын үзүүлэлтийг эс тооцвол харьцангуй бага байсныг тэмдэглэсэн билээ. Харин ядуурлын хүчин зүйлийг цогц байдлаар шинжилж үзэхэд шилжин ирэгчид илүү эмзэг, эрсдэл ихтэй байгааг судалгааны дүн харуулж байна.

Хүснэгт 7.12 Хүн амын хувийн жин, хүртээмжийн ядуурал, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хүртээмж		
	Бусад	Нийгмийн эмзэг бүлэг	Тоо
Шилжилтийн байдал**			
Шилжигч	60.9	39.1	688
Шилжигч бус	78.0	22.0	4024
Байршил			
Гэр хороолол	63.0	37.0	4070
Байшин хороолол	92.7	7.3	2777
Дүүрэг			
Баянзүрх	66.8	33.2	909
Налайх	61.8	38.2	492
Сүхбаатар	85.3	14.7	1448
Сонгинохайрхан	73.1	26.9	2344
Хан-Уул	87.9	12.1	481
Чингэлтэй	72.9	27.1	1173
Нас			
17 хүртэл	72.1	27.9	2190
17-25	73.4	26.6	1468
26-59	76.9	23.1	2683
60 ба түүнээс дээш	82.2	17.2	506
Хүйс			
Эрэгтэй	74.9	25.1	3193
Эмэгтэй	75.2	24.8	3654
Яс, үндэс			
Халх	76.3	23.7	6035
Казак	43.4	56.6	173
Дөрвөд	78.4	21.6	171
Буриад	84.8	15.2	112
Баяд	69.0	31.0	142
Бусад	62.6	37.4	214
Өрхөд амьдарч буй хүний тоо			
1-2	89.5	10.5	306
3-4	87.1	12.9	2393

Ядуурал

5-6	75.3	24.7	2425
7+	55.4	44.6	1723
<i>Боловсролын түвшин*</i>			
Боловсролгүй/ бага	60.4	39.6	613
Бүрэн бус дунд	62.4	37.6	1087
Бүрэн дунд	77.5	22.5	1659
Мэргэжлийн/тусгай дунд/дээд	89.3	10.7	1694
<i>Бүртгэлийн байдал</i>			
Бүртгэлтэй	76.4	23.6	6241
Бүртгэлгүй	61.2	38.8	606
<i>Ажил эрхлэлтийн сектор***</i>			
Албан	82.3	17.7	1471
Албан бус	75.7	24.3	654
Гадаадад	95.1	4.9	41
<i>Орлого олдог эсэх*</i>			
Тийм	80.5	19.5	2166
Үгүй	72.8	27.2	2887
<i>Сууцны төрөл</i>			
Гэр	43.5	56.5	1356
Бусад	82.8	17.2	5491
<i>Тоо</i>			
Бүгд	5138	1709	6847
	75.0	25.0	100.0

* 15 ба түүнээс дээш насны хүн ам (n=5053)

*** 15-64 насны хүн ам (n=4712)


**** 7 ба түүнээс дээш насны хүн ам (n=2166)

Нийгмийн эмзэг бүлгийнхний хувьд байршлын ялгаа илүү тод илэрч байна. Тухайлбал, гэр хорооллын оршин суугчдын гуравны нэг буюу 37.0 хувь нь өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарч байхад байшин хорооллынхны 7.3 хувь нь энэ бүлэгт хамрагдаж байна.


Дүүргүүдээс Налайх дүүрэгт ядуурлын аль ч хүчин зүйл бусад дүүргүүдтэй харьцуулахад илүү хурц тодорч байгааг өмнөх үр дүнгүүдэд харуулсан билээ. Нийгмийн эмзэг бүлэгт багтах хүн амын хувийн жингээр Налайх хамгийн өндөр буюу 38.2 хувь байна. Үүний дараагаар Баянзүрх дүүрэг (33.2 хувь) багтаж байна.

Залуу насны бүлгийн хүн ам ядууралд илүү нэрвэгдэж байгаа хандлагыг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, 25-аас доош насны хүн амын 27 орчим хувь өндөр эрсдэлтэй бүлэгт хамрагдаж байгаа нь 60-аас дээш насны хүн амтай харьцуулахад 10 орчим пунктээр өндөр байна.

Нийгмийн эмзэг хүн амын хувийн жингийн тархалтыг ястан үндэстнээр үзэхэд судалгаанд хамрагдсан нийт 173 казах хүн амын талаас илүү (56.6 хувь) нь эрсдэл өндөр байдалд байна. Өмнө дурдсанчлан хэдийгээр казак хүн амын тоо бага боловч нийт хүн амд эзлэх хувийн жинтэй харьцуулан үзэхэд хангалттай сайн төлөөлөлтэй байсан билээ. Түүнчлэн баяд болон бусад ястны хувьд өндөр эрсдэлтэй хүн амын эзлэх хувийн жин өндөр буюу 31.0-37.4 хувь байна.



Зургаас харахад ядуучууд болон нийгмийн эмзэг бүлгийнхний хооронд ялгаа харьцангуй бага байна. Харин гэрт амьдардаг хүмүүсийн хувьд ялгаа хамгийн их байв.



7.6.4 Хэсгийн дүгнэлт

Ядуурлын стандарт хэмжүүр нь хүртээмж болон нийгмийн оролцооны асуудлыг тусгаж чаддаггүй. Энэхүү шалтгааны улмаас ядуурлыг тодорхойлох хоёр төрлийн индексийг судалсан. Түүнчлэн эдгээр нь хэрхэн давхцаж байгааг харуулав. Зөвхөн нэг ядуурлын хэмжүүрийн хувьд ядуу хүмүүсийн (56 хувь) гуравны нэгд (21 хувь) нь ядуурлын хоёр асуудал зэрэг илэрч гарсан тул эдгээр хүмүүсийг нийгмийн эмзэг бүлэг гэж тодорхойлсон. Түүнчлэн нийгмийн эмзэг бүлгийнхний шинж байдлыг шинжлэн үзэхэд

Ядуурал

хэрэглээний хувьд ядуу хүмүүстэй харьцуулахад ялгаа бага байна. Тиймээс, зорилтот бүлгийн шинж байдалд өөрчлөлт орохгүй гэж хэлж болох юм. Хэдийгээр ядуурлын уламжлалт хэмжүүр үзүүлэлтүүд нь хүртээмж, нийгмийн оролцооны асуудлуудыг тусгадаггүй ч гэсэн Улаанбаатар хотын хувьд эдгээр үзүүлэлтүүд нь ядуурлыг илэрхийлэх хангалттай үзүүлэлтүүд болж өгсөн.

БҮЛЭГ 8. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Бүлэг 8-д шилжигчдын шинж байдал, шилжих хөдөлгөөн ба ядуурлын холбоо, хамаарлыг шинжлэн үзлээ. Энэ бүлгээр хотод шилжин ирэгсэд болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын амьдрал ахуй нөхцлийн ялгаатай байдал, нийгмийн үйлчилгээнээс хүртэх боломж, шилжин ирэгсэдэд тулгарч буй бэрхшээл зэргийг тодруулан харуулахыг зорьсон болно.

Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод сүүлийн 4 жилд шилжин ирсэн 15-64 насны хүнтэй болон энэ насны өрхийн тэргүүлэгч нь шилжих хөдөлгөөнд оролцсон өрхүүдийн шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийг харьцуулан дүгнэсэн болно.

Түлхүүр асуултууд

- Шилжигчид хэн байна вэ?
- Шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаанууд юу байна вэ? Шилжин ирсний дараа амьдралд нь өөрчлөлт гарсан уу?
- Бүртгэл шилжих хөдөлгөөний урсгалд нөлөөлж байна уу?
- Ядуурал ба шилжих хөдөлгөөний хооронд хамаарал байна уу?
- Засгийн газраас нэн тэргүүнд анхаарах ямар асуудлууд байна вэ?


Хариулт ба дүгнэлт

- Хот руу шилжин ирэгчид голчлон гэр хороололд амьдарч байгаа ба тэдний дийлэнх нь бүрэн дундаас доош боловсролтой байна.
- Шилжин ирэгчдийн ихэнх нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, суралцах болон зах зээлд ойртох зорилгоор шилжин иржээ. Шилжин ирсний дараа ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх болон зах зээлд ойртох гэсэн зорилгууд нь биелж байгаа боловч боловсролын байдалд нь ахиц гарсангүй. Эндээс, шилжих хөдөлгөөний зохицуулалтыг улам анхаарах хэрэгтэй байна.
- Шилжин ирэгчдийн ихэнх нь (71 хувь) шилжин ирсэн зорилгоо биелсэн гэж үзэж байна.
- Бүртгэл нь Улаанбаатар руу шилжин ирэх хөдөлгөөнийг багасгахад нөлөөлж чадахгүй байна (шилжигчдийн тал хувь нь бүртгэлгүй байна). Гэвч бүртгэлгүй байдал нь эрүүл мэндийн даатгалгүй шилжигчдийн (1/3) эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа үндсэн шалтгаануудын нэг (эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа шилжигчдийн 1/4 нь бүртгэлгүй гэсэн шалтгаанаар хамрагдаж чадахгүй байна) болж байна.
- Шилжигчид нь шилжих хөдөлгөөнд оролцсон учраас ядуу байгаа биш, тухайлбал, боловсролын түвшин доогуур байгаагаас ядууралд өртөж байна. Шилжигчид шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай адил боломжтой нь харагдаж байгаа бөгөөд тэдний гол бэрхшээл нь мэргэжил, боловсролын байдлаараа шилжигч бус хүн амынхаас бага зэрэг дутмаг байгаа явдал ажээ.
- Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засаг болон боловсролын байдлыг сайжруулах асуудал хамгийн чухал байна.

8.1 Шилжигчдийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 14.6 хувь (нийт өрхийн 13.4 хувь) нь судалгаанаас өмнөх 4 жилийн хугацаанд хотод шилжиж ирсэн хүн ам байлаа. Нийт өрхийн 11.7 хувь нь шилжин ирсэн өрх, 17.8 хувь нь шилжин ирсэн хүнтэй өрх байв. Шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн 79.5 хувь нь гэр хороололд, 20.5 хувь нь байшин хороололд амьдрагч байна. Шилжин ирэгсэд (цаашид *шилжигч* гэж нэрлэнэ) болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй (цаашид *шилжигч бус* гэж нэрлэнэ) хүн амын нас, хүйсийн бүтцийг Зураг 8.1-д харуулав.

Зураг 8.1 Хүн амын нас, хүйсийн суварга
Шилжигч ба шилжигч бус



Хүснэгт 8.1-д шилжигч болон шилжигч бус хүн амын шинж байдлыг байршлаар харуулав. Шилжигч, шилжигч бус хүн амын аль алинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс илүү байна.

Шилжигчдийн талаас илүү буюу 58.7 хувийг 15-29 насны залуучууд эзэлж байна. Энэ үзүүлэлтийг шилжигч бус хүн амтай харьцуулахад 10 пунктээр өндөр хэдий ч байршлын хувьд онцын ялгаагүй байна. Харин байшин хорооллын шилжигч бус хүн амд 15-29 насны залуучуудын эзлэх хувийн жин шилжигч бус залуучуудаас 14.6, гэр хорооллын шилжигч бус мөн насны залуучуудаас 6.2, шилжигч залуучуудаас 13.5 пунктээр тус тус доогуур байна. Өөрөөр хэлбэл, байшин хороололд нас тогтсон хүмүүсийн эзлэх хувь, гэр хороололд залуучуудын эзлэх хувь өндөр байна.

Гэрлэлтийн байдлаар үзвэл, огт гэрлээгүй шилжигч хүн ам гэр хороололд 45.9 хувь, байшин хороололд 49.6 хувийг тус тус эзэлж байна. Харин байшин хороололд шилжигч бус ганц бие хүн амын эзлэх хувь (37.1 хувь) шилжигч ганц бие хүн амтай харьцуулахад 12.5 пунктээр өндөр байв. Энэ нь дээр дурьдсанчлан байшин хороололд харьцангуй удаан хугацаагаар хотод суурьшсан, нас тогтсон, гэр бүлтэй, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүс голдуу амьдардаг болохыг харуулж байна. Түүнчлэн бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувийн жин байшин хороололд өндөр байгааг хүснэгтээс харж болно.

Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 81.2 хувийг халх, 4.2 хувийг баяд, 2.8 хувийг дөрвөд, 2.3 хувийг буриад, 1.7 хувийг казакууд эзэлж байна.

Хүснэгт 8.1 15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал, хүн ам зүйн шинж байдлаар

Хүн ам зүйн үзүүлэлтүүд	Гэр хороолол		Байшин хороолол		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Хүйс						
Эрэгтэй	46.3	46.2	45.4	45.5	46.1	45.9
Эмэгтэй	53.7	53.8	54.6	54.5	53.9	54.1
Хүйсийн харьцаа	86.2	85.9	83.2	83.5	85.5	84.8
Насны бүлэг						
15-19	20.8	21.0	21.3	17.2	20.9	19.3
20-24	21.8	16.1	24.8	14.5	22.4	15.4
25-29	16.1	14.3	12.8	13.5	15.4	14.0
30-34	11.0	9.9	11.3	10.7	11.0	10.3
35-39	7.7	9.4	5.7	10.3	7.3	9.8
40-44	8.0	9.3	9.2	11.4	8.3	10.3
45-49	5.7	7.1	5.7	8.1	5.7	7.6
50-54	4.2	6.1	5.0	6.9	4.4	6.5
55-59	2.0	2.8	1.4	4.0	1.9	3.4
60-64	2.7	3.8	2.8	3.4	2.8	3.6
Гэрлэлтийн байдал						
Огт гэрлээгүй	45.9	41.4	49.6	37.1	46.7	39.4
Баталгаатай гэр бүл	38.2	38.3	33.3	43.8	37.2	40.8
Баталгаагүй гэр бүл	11.3	10.9	9.2	9.2	10.9	10.1
Тусгаарласан	0.9	2.0	2.1	1.6	1.2	1.8
Салсан	0.4	2.3	2.1	3.4	0.7	2.8
Бэлбэсэн	3.3	5.1	3.5	5.0	3.3	5.0
Яс үндэс						
Халх	81.2	88.9	80.9	91.1	81.1	89.9
Казак	0.5	4.3	6.4	0.2	1.7	2.5
Дөрвөд	2.9	2.2	2.1	1.9	2.8	2.1
Буриад	1.8	0.6	4.3	2.3	2.3	1.4
Баяад	4.8	1.8	2.1	2.0	4.2	1.9
Бусад*	8.8	2.2	4.3	2.5	7.8	2.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны хүн амын тоо	547	2213	141	1811	688	4024

Тэмдэглэл: * - Гадаадын 9 хүнийг бусад гэсэн ангилалд оруулав.

8.2 Өрхийн шинж байдал, ахуйн нөхцөл

Судалгаагаар тухайн өрхийн тэргүүн шилжих хөдөлгөөнд оролцсон тохиолдолд өрхийг шилжигч өрх гэж авч үзэв. Судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдлыг байршил болон шилжилтийн байдлаар Хүснэгт 8.2-д харуулав.

Өрхөд амьдардаг хүний тоогоор авч үзэхэд 3-4 хүнтэй шилжигч болон шилжигч бус өрхүүд хамгийн өндөр, ойроцоогоор нэг өрхөд 4.3 хүн ногдож байна. Харин 5 ба түүнээс дээш хүн амьдардаг шилжигч өрхийн хувийн жин ийм хүн амтай шилжигч бус өрхөөс өндөр байна. Энд нэг сонирхол татсан үзүүлэлт бол нэг өрхөд амьдардаг гэр бүлийн тоо өрхийн байршлаар нэлээд ялгаатай байна. Тухайлбал, байшин хороололд шилжигч бус гэхдээ нэгээс олон ам бүл нэг байр/сууцанд амьдрах явдал илүү байдаг нь судалгаагаар харагдлаа. Үүнийг шинээр гэр бүл болсон залуучууд байшин хороололд амьдрах сонирхолтой байдгаас эцэг, эхтэйгээ хамт амьдардаг, нөгөө талаас сүүлийн жилүүдэд байшин хороололд хүмүүс хажуу өрөө олонтой хөлсөлдөг болсонтой холбон тайлбарлаж болох юм. Мөн өрхөд амьдарч буй хүүхдийн тоо гэр хороололд байшин хорооллынхоос хоёр дахин өндөр байна.

Шилжих хөдөлгөөн

Хүснэгт 8.2 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, байршил, шилжилтийн байдал, өрхийн шинж байдлаар

Өрхийн шинж байдал	Гэр хороолол		Байшин хороолол		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Өрхөд амьдарч буй хүний тоо						
1-2	7.5	5.5	28.6	13.5	12.5	9.3
3-4	31.3	40.8	50.0	54.0	35.8	47.1
5-6	41.0	35.2	16.7	23.7	35.2	29.8
7 ба түүнээс олон	20.1	18.5	4.8	8.7	16.5	13.9
<i>Дундаж</i>	5.14	5.06	3.52	4.17	4.76	4.64
Ам бүлийн дундаж тоо	4.59	4.77	3.33	3.86	4.29	4.34
Өрхөд шилжин ирсэн хүний тоо						
0	-	91.7	-	95.7	-	93.6
1-2	38.8	6.8	54.8	4.3	42.6	5.6
3-4	43.3	1.2	40.5	-	42.6	0.6
5 ба түүнээс олон	17.9	0.3	4.8	-	14.8	0.2
<i>Дундаж</i>	3.23	0.14	2.52	0.05	3.06	0.10
Өрхөд амьдарч буй гэр бүлийн тоо						
1	85.1	82.5	95.2	86.5	87.5	84.4
2 ба түүнээс олон	14.9	17.5	4.8	13.5	12.5	15.6
Хүүхдийн дундаж тоо	2.27	2.46	1.17	1.76	2.01	2.13
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны тэргүүнтэй өрхийн тоо	134	600	42	539	176	1139

Судалгаанд хамрагдсан өрхийн сууцны төрлийг шилжих хөдөлгөөний байдлаар Хүснэгт 8.3-д задлан харуулав.

Хүснэгт 8.3 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, шилжилтийн байдал, өрхийн сууцны үзүүлэлтүүдээр

Сууцны үзүүлэлтүүд	Шилжилтийн байдал		Нийт
	Шилжигч	Шилжигч бус	
Өрхийн сууцны төрөл			
Байшин*	48.3	87.4	82.2
Гэр	51.7	12.6	17.8
Бүгд	100.0	100.0	100.0
15-64 насны тэргүүлэгчтэй нийт өрхийн тоо	176	1139	1315
Сууцны зориулалт**			
Сууцны тусдаа байшин	45.9	43.7	43.8
Нийтийн сууцны байшин доторх сууц	36.5	50.2	49.1
Нийтийн эзэмшлийн байр	5.9	3.9	4.1
Сууцны бус	11.8	2.2	3.0
Бүгд	100.0	100.0	100.0
15-64 насны тэргүүлэгчтэй, байшинд амьдардаг өрхийн тоо	85	996	1081
Сууцны эзэмшил**			
Өөрийн эзэмшлийн	77.1	88.5	87.0
Өөрийн эзэмшлийн бус	22.9	11.5	13.0
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	166	1117	1283

Тэмдэглэгээ: * Үүнд: Сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторх сууц, нийтийн эзэмшлийн байрууд мөн сууцны зориулалтын бус байрууд орно.

** Гэр ороогүй

*** Сууцны бус болон бусад гэсэн ангилал ороогүй

Шилжигч өрхийн 48.3 хувь нь байшинд (гэр хорооллын байшин орсон), 51.7 хувь нь гэрт амьдарч байна. Гэрт амьдарч буй шилжигч бус өрхийн (87.4 хувь) эзлэх хувийн жин шилжигч өрхийнхөөс (12.6 хувь) бараг 4 дахин бага байна. Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн багагүй хувь нь хүн амьдрах зориулалтаар баригдаагүй тав тух муутай орчинд амьдардаг болохыг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, сууцны төрлөөр үзэхэд сууцны тусдаа байшинд шилжигч өрхийн 36.5 хувь, шилжигч бус өрхийн 50.2 хувь нь амьдарч байхад сууцны бус байранд (гэр орохгүй) шилжигч өрхийн 11.8 хувь, шилжигч бус өрхийн ердөө 2.2 хувь нь амьдарч байлаа.

Гэрт амьдарч буй хүн амын сууцны ахуй нөхцөл шилжигч болон шилжигч бус өрхүүдийн хувьд тун ойролцоо байна. Тухайлбал, гэрт амьдарч буй нийт өрхүүдийн талаас илүү хувь нь (65 хувь) 5 ханатай гэрт амьдардаг ба шилжилтийн байдлаар онцын ялгаа байхгүй байна. Өвлийн хүйтэнд шилжигч өрхийн 47.3 хувь нь дан бүрээстэй, 46.2 хувь нь дан туургатай, 29.7 хувь нь шалгүй хүнд нөхцөлд амьдардгийг судалгааны дүн харууллаа. Ер нь гэрт амьдарч буй шилжигч өрх төдийгүй шилжигч бус өрхийн цөөнгүй хэсэг дан бүрээс, дан туургатай, шалгүй гэрт хүнд нөхцөлд амьдарч байна.

Хүснэгт 8.4 15-64 насны тэргүүнтэй, гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, шилжилтийн байдал, сууцны нөхцлөөр

Сууцны нөхцөл	Шилжилтийн байдал		Нийт
	Шилжигч	Шилжигч бус	
Ханын тоо			
<4	19.8	23.1	21.8
5	62.6	66.4	65.0
6 ба түүнээс дээш	17.6	10.5	13.2
Туурга			
Дан	47.3	37.8	41.5
Давхар	52.7	62.2	58.5
Бүрээс			
Дан	46.2	39.2	41.9
Давхар	53.8	60.8	58.1
Шал			
Шалтай	70.3	80.4	76.5
Шалгүй	29.7	19.6	23.5
Бүгд	100.0	100.0	100.0
15-64 насны өрхийн тэргүүнтэй, гэрт амьдардаг нийт өрхийн тоо	91	143	234

Шилжигч өрхийн 8.5 хувь, шилжигч бус өрхийн 2.0 хувь нь дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн гэх нийслэл хотод амьдарч байгаа хэдий ч төвлөрсөн сүлжээгээр цахилгаан хэрэглэж чадахгүй байна (Хүснэгт 8.5). Энэ бол дэд бүтэцтэй холбогдоогүй, манайхны ярьдгаар *задгайд* шилжин суурьшигч өрхүүдийн цөөнгүй хэсэг нь гэр хороололд байгаатай холбоотой юм. Мөн төвлөрсөн халуун ба хүйтэн ус хэрэглэх боломжоор хангагдаагүй шилжигч өрхийн эзлэх хувийн жин шилжигч бус өрхөөс 2 дахин өндөр байна.

Техник технологийн хурдацтай хөгжлийн өнөөгийн нөхцөлд хүний наад захын хэрэгцээ болсон утсан харилцаанд шилжигч өрхүүдийн тал хүрэхгүй хувь, шилжигч бус өрхүүдийн хувьд 64.5 хувь холбогдсон байна.

Шилжих хөдөлгөөн

Хүснэгт 8.5 15-64 насны тэргүүнтэй, гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, шилжилтийн байдал, ахуйн нөхцлөөр

Ахуйн нөхцөл	Шилжилтийн байдал		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус		
Гэрэлтүүлэг				
Төвлөрсөн цахилгаан	91.5	98.0	97.1	
Лаа	8.5	2.0	2.9	
Ундны усны эх үүсвэр				
Төвлөрсөн: Халуун, хүйтэн устай	20.5	44.4	41.2	
Зөвхөн хүйтэн устай	2.3	1.5	1.6	
Худаг	72.2	53.9	56.3	
Бусад	5.0	0.2	0.8	
Халаалт				
Төвлөрсөн	23.3	46.3	43.2	
Төвлөрсөн бус	1.1	2.0	1.9	
Ердийн	75.6	51.7	54.9	
Хог зайлуулалт				
Тусгай зориулалтын хогийн цэгт	84.1	96.3	94.7	
Ил задгай нүх, суваг, шуудуунд	15.9	3.7	5.3	
Хэрэглэдэг түлшний төрөл*				
Цахилгаан	41.5	62.8	59.9	
Мод	71.6	52.9	55.4	
Нүүрс	69.9	50.7	53.2	
Бусад	4.5	2.9	3.1	
Бие засах газар				
Сууц дотроо төвлөрсөн: Тусдаа	17.6	44.3	40.8	
Нийтийн	6.8	2.1	2.7	
Нүхэн жорлон	70.5	52.5	54.9	
Ил задгай	5.1	1.1	1.6	
Утастай эсэх**				
Утастай	45.5	64.5	62.0	
Утасгүй	54.5	35.5	38.0	
Илүү гэр/байшин/гарааштай эсэх				
Байгаа	19.3	36.2	34.0	Тэмдэгт
Байхгүй	80.7	63.8	66.0	: *
Бүгд	100.0	100.0	100.0	Гэр ороо гүй.
15-64 насны өрхийн тэргүүнтэй, гэрт амьдардаг нийт өрхийн тоо	91	143	234	**

Олон сонголттой харилцааг тооцсон хувь.

Судалгаанд хамрагдагчдаас тухайн өрхдөө бүртгэлтэй эсэхийг асуусан бөгөөд үр дүнг байршил болон шилжилтийн байдлаар Хүснэгт 8.6-д харууллаа.

Хүснэгт 8.6 15-64 насны хүн амын хувийн жин, тухайн өрхөд бүртгэлтэй эсэх, байршил, шилжилтийн байдлаар

Өрхдөө бүртгэлтэй эсэх	Гэр хороолол		Байшин хороолол	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Бүртгэлтэй	80.6	95.2	80.1	93.6
Бүртгэлгүй	19.4	4.8	19.9	6.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны нийт хүн амын тоо	547	2213	141	1811

Тухайн өрхөд бүртгэлтэй хүн амын эзлэх хувийн жин байршлын хувьд онцын ялгаагүй байна. Харин шилжигч, шилжигч бус өрхийн хувьд нэлээд ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, гэр хорооллын шилжигч өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амын хувийн жин (19.4 хувь), шилжигч бус өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амынхаас 4 дахин, харин байшин хорооллын шилжигч өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амын хувийн жин (19.9 хувь) шилжигч бус өрхөд амьдарч буй хүн амынхаас 3 дахин өндөр байв.

8.3 Шилжигчдийн боловсрол

Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшинг шилжилтийн байдал, байршлаар Хүснэгт 8.7-д харуулав.

Шилжигч бус хүн амын боловсролын түвшин ерөнхийдөө дээгүүр байна. Тухайлбал, шилжигчдийн 38.7 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой болон боловсролгүй хүмүүс байхад шилжигч бус хүн амын хувьд энэ үзүүлэлт 30.6 хувь буюу 8.1 пунктээр доогуур байна. Харин дээд боловсролтой шилжигч бус хүн амын хувийн жин шилжигч хүн амынхаас 11.0 пунктээр өндөр байна. Энэ нь шилжигчдийн шилжих хөдөлгөөнд оролцох томоохон шалтгааны нэг нь суралцах, өөрөөр хэлбэл, мэргэжил, боловсрол эзэмших явдалтай холбоотой юм.

Хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийн дунд боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь нийслэлд амьдардаг хүмүүсийнхээс нэлээд дээгүүр байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн байшин хороололд амьдардаг шилжигч хүн амын 32.6 хувь нь дээд боловсролтой, гэр хорооллын шилжигч хүн амын дөнгөж 6.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байв. Шилжигчдийн боловсролын түвшин нэмэгдэх тутам байшин хороололд амьдарч буй шилжигчдийн хувийн жин нэмэгдэж байна. Эндээс боловсрол өндөртэй хүн ам голдуу байшин хороололд амьдарч байна гэж хэлж болохоор байна.

Хүснэгт 8.7 15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Гэр хороолол		Байшин хороолол		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Боловсролын түвшин						
Боловсролгүй	3.1	1.9	2.8	0.8	3.1	1.4
Бага	11.7	9.9	6.4	4.5	10.6	7.5
Бүрэн бус дунд	27.8	28.8	14.2	13.5	25.0	21.8
Бүрэн дунд	38.6	35.9	35.5	31.7	37.9	34.0
Техник мэргэжлийн	5.1	5.2	2.8	2.8	4.7	4.1
ТМД, бүрэн бус дээд	6.9	7.3	5.7	8.9	6.7	8.0
Дээд	6.8	11.0	32.6	37.9	12.1	23.1
Ажил эрхлэлтийн байдал						
Ажил эрхэлдэг	39.9	42.1	43.3	52.3	40.6	46.7
Ажил эрхэлдэггүй	60.1	57.9	56.7	47.7	59.4	53.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны нийт хүн амын тоо	547	2213	141	1811	688	4024

Сургууль завсардалт

Чанарын судалгааны дүнгээс харахад шилжигч өрхийн хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж шилжигч бус өрхийн хүүхдүүдээс хавьгүй доогуур байгаа нь харагдаж байна.

“Шилжиж ирээд хүүхдээ сургуульд оруулах бол хамгийн хэцүү асуудал. Багтахгүй ачаалал ихтэй байна гээд ер халгаадаггүй. Тэгээд таньдаг хүнээ гуйж байгаад гэрээсээ хол, харьяаллын бус сургуульд хүүхдээ оруулсан”
(Ц.эмэгтэй, нас 39, шилжин ирсэн бүртгэлгүй, СХД)

Сургууль завсардалтын томоохон шалтгааны нэг нь шилжих хөдөлгөөн гэж өмнөх судалгаануудад өгүүлсэн хэдий ч байршлын ялгааг орхигдуулсан юм. Иймд бид судалгаандаа сургууль завсардалтыг шилжих хөдөлгөөн болон байршлын ялгавартай байдлаар авч үзсэн. Гэр хорооллын хүүхдүүдийн дунд сургууль завсардалт харьцангуй өндөр байгаа боловч шилжилтийн байдлаар ялгаа бага байна. Тухайлбал, байшин хорооллынхонтой харьцуулахад гэр хорооллын сургууль завсардсан хүүхдийн тоо бараг 8 дахин өндөр байгаа юм. Сургууль завсардсан хүүхдүүдийн талаас илүү хувийг гэр хорооллын шилжигч бус өрхийн хүүхдүүд эзэлж байна. Сургууль завсардсан гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдүүдийн талаас илүү нь эрэгтэй хүүхдүүд байна.

Бүртгэлгүй гэсэн шалтгаанаар гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдийн 33,3 хувь нь сургууль завсардсан байхад байшин хороололд ийм шалтгаан гараагүй. Гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдийн тал орчим нь 5-8 дугаар ангиас завсардаж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

Албан бус сургалтад сургууль завсардсан шилжигч өрхийн хүүхдүүд бараг хамрагдаагүй (4 хүүхэд л хамрагдсан) байна.

8.4 Шилжигчдийн эрүүл мэнд

Шилжигчдэд эмнэлгийн үйлчилгээнээс хүртэх боломж тааруу болох нь чанарын судалгааны дүнгээс харагдлаа. Үүнийг тэд нэг талаар эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах боломжоо мэддэггүй, мэдээлэл муутай зэрэг шалтгаантай, нөгөө талаар хотын захын гэр хороололд эмнэлгийн үйлчилгээ тийм ч сайнгүй байдагтай холбон ярьж байв. Учир нь шилжин ирсэн, тухайн хороонд бүртгэлгүй иргэдэд эмнэлгийн наад захын үзлэг, оношлогоо хийдэггүй бөгөөд харин өвчилсөн эсвэл өвчин хүндэрсэн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээнд хамруулдаг ажээ.

“Манай өрхийн эмнэлэг их хол. Ер нь эмч нар их зантай, их ааш муутай. Өдөржин олон хүн үзээд уур нь хүрчихдэг юм байлгүй. Шилжиж ирсэн бид нарыг байтугай үндсэн иргэдээ үзэж дийлдэггүй юм билээ”
(Ч. эмэгтэй, нас 61, тэтгэвэрт, шилжин ирсэн бүртгэлгүй, СХД)

Тэгэхдээ үүнийг дан ганц захын хорооллын эмнэлгийн үйлчилгээ, чанартай холбон тайлбарлаж болохгүй юм. Тэнд эмнэлгийн орчин, нөхцөл тийм ч сайн биш байдаг тухай эмнэлгийн эмч, ажилтнууд шүүмжилж байлаа.

“Ажиллах нөхцөл үнэхээр муу. Энэ байранд ороод 2 жил ч болоогүй байж бороо орохоор тааз нь төмбийгөөд дусаал гоождог. Тарианы өрөө гэхэд усгүй, өвчтөнгүүдийн гадуур хувцсыг өлгөх тусдаа өрөө ч байдаггүй. Өрхийн

эмнэлгийн хувьд усны хангамжийг сайжруулах, мөн төвийн халаалттай холбож өгвөл ажлын нөхцөл маань арай сайжрах байх”

(И, эмэгтэй, нас 50, өрхийн эмч, СХД)

Хүн амын эрүүл мэндийг байршил болон шилжилтийн байдлаар Хүснэгт 8.8-д харуулав.

Шилжигчдийн 13.9 хувь нь өөрийгөө эрүүл мэндийн хувьд муу, архаг хууч өвчтэй гэж хариулсан байхад шилжигч бус хүн амын 17.2 хувь нь дээрх хариултыг өгчээ. Шилжигч, шилжигч бус хүмүүсийн ийм хариултын хувь байшин хорооллын хувьд 7.7 пунктээр зөрүүтэй байна. Шилжигчдийн эрүүл мэнд шилжигч бус хүн амынхаас арай дээр байна. Энэ нь нэг талаар шилжих хөдөлгөөнд эрүүл хүмүүс орох магадлал өндөр, нөгөө талаар шилжигчид уугуул нутагтаа эрүүл мэндийн нарийн үзлэгт хамрагдах боломж муу, улмаар өөрсдийн эрүүл мэндийн талаар мэдлэг дутмаг байж болох талтай.

Хүснэгт 8.8 15-64 насны хүн амын хувийн жин, эрүүл мэндийн байдал, байршил, шилжилтийн байдлаар

Эрүүл мэндийн үзүүлэлтүүд	Гэр хороолол		Байшин хороолол		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Архаг хууч өвчтэй эсэх						
Өвчингүй	85.0	82.6	90.6	82.9	86.1	82.8
Өвчтэй	15.0	17.4	9.4	17.1	13.9	17.2
Согогтой эсэх						
Тийм	4.8	6.6	5.0	4.1	4.8	5.5
Үгүй	95.2	93.4	95.0	95.9	95.2	94.5
ЭМД-тай эсэх						
Байгаа	63.3	70.7	73.1	82.6	65.2	76.1
Байхгүй	35.6	28.1	24.1	15.2	33.3	22.3
Мэдэхгүй	1.1	1.2	2.8	2.2	1.5	1.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны нийт хүн амын тоо	547	2213	141	1811	688	4024

Шилжигчдийн гуравны нэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй бөгөөд хамрагдаагүй байдал гэр хорооллын шилжигч хүн амын (35.6 хувь) хувьд байшин хорооллынхоос (24.1 хувь) илүү өндөр байна.

Хүснэгт 8.9 15-64 насны, эрүүл мэндийн даатгалгүй хүн амын хувийн жин, даатгалд хамрагдаагүй шалтгаан, байршил, шилжилтийн байдлаар

ЭМД-д хамрагдаагүй шалтгаан	Гэр хороолол		Байшин хороолол		Нийт	
	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус	Шилжигч	Шилжигч бус
Ажилгүй	13.3	31.1	11.8	22.5	13.1	28.4
Мөнгөний боломжгүй	38.5	36.4	35.3	27.5	38.0	33.7
Бүртгэлгүй	27.2	7.9	26.5	8.7	27.1	8.1
Надад хэрэггүй	8.7	12.6	17.6	19.6	10.0	14.7
Яаж хамрагдахаа мэддэггүй	4.1	2.7	2.9	3.6	3.9	3.0
Өөрийн хариуцлагагүйгээс	3.1	7.6	2.9	14.1	3.1	9.6
Хувийн секторт ажилладаг	3.1	0.8	2.9	0.7	3.1	0.8
Мэдэхгүй	2.1	1.0	-	3.3	1.7	1.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-64 насны, эрүүл мэндийн даатгалгүй хүн амын тоо	195	621	34	276	229	897

Байршлаар үзвэл шилжигчдийн тал орчим хувь нь сумын төвөөс иржээ. Гадаадаас ирсэн хүмүүс бараг бүгд байшин хороололд амьдарч байгаа нь нэлээд сонирхол татаж байна. Үүнийг гадаад шилжих хөдөлгөөн нэг талаас тухайн өрхийн амьжиргаанд нэмэр болдог, нөгөө талаас гадаад шилжих хөдөлгөөнд байшин хороололд амьдардаг, амьжиргааны боломжийн нөхцөлтэй хүмүүс илүү оролцдог гэж тайлбарлаж болох юм.

Хүснэгт 8.10 Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирэхээс өмнө амьдарч байсан байршил, шилжилтийн шалтгаан, байршлаар

Үзүүлэлтүүд	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Шилжин ирэхээс өмнө амьдарч байсан газар			
Хангайн бүс	27.2	25.5	26.9
Баруун бүс	28.7	22.0	27.3
Төвийн бүс	31.4	27.7	30.7
Зүүн бүс	12.4	14.2	12.8
Гадаад	0.2	10.6	2.3
Шилжин ирэхээс өмнө амьдарч байсан байршил			
Аймгийн төв	30.5	46.1	33.7
Тосгон	2.6	2.8	2.6
Сумын төв	50.6	35.5	47.5
Хөдөө	16.1	6.4	14.1
Гадаад	0.2	9.2	2.0
Шилжилтийн шалтгаан			
Эдийн засгийн	39.9	29.8	37.8
Эдийн засгийн бус	38.2	61.7	43.0
Аль аль нь	21.9	8.5	19.2
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	547	141	688

Бидний шилжих хөдөлгөөний гол зорилго нь эдийн засгийнх байх болов уу гэж таамаглаж байсан боловч шилжигчдийн 37.8 хувь л ийм хариултыг өгсөн юм. Харин шилжигчдийн дийлэнх буюу 43 хувь нь эдийн засгийн бус зорилгоор хотод шилжин ирсэн гэжээ. Харин гэр хороололд шилжин ирсэн хүмүүсийн хувьд эдийн засгийн зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцсон хувь бусдаас арай илүү байв.

“Хотод ирж байгаа хүмүүс нь хэдэн малаа барсан, амьдрах аргагүй болсон хүмүүс энд хүнд зарагдаж байж хэдэн төгрөг олъё гэж, харин зарим нэг сүйхээтэй нь соёл боловсролын үйлчилгээнд ойртох гэж ирж байна”

(Д, эмэгтэй, нас 53, Хорооны засаг дарга, СХД)

Шилжигчдээс шилжих хөдөлгөөнд оролцох болсон гол шалтгааныг асуухад давхардсан тоогоор хариулагчдын 41.4 хувь нь ажил эрхлэхээр, 38.4 хувь нь амьжиргаагаа дээшлүүлэхээр, 36.9 хувь нь суралцахаар, 27.9 хувь нь зах зээлд ойртохоор хот, суурин бараадсан байна (Хүснэгт 8.11).

Шилжих хөдөлгөөний татах түлхэх хүчний онолын үүднээс авч үзэхэд, нийслэл болон хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ялгавартай байдал нь хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний гол татах хүчин зүйлс болж байна.

Хүснэгт 8.11 Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, байршлаар

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Шилжин ирсэн зорилго*			
Бизнес эрхлэх	3.3	3.5	3.3
Ажил эрхлэх	42.2	38.3	41.4
Амьжиргаагаа дээшлүүлэх	42.8	21.3	38.4
Зах зээлд ойртох	30.5	17.7	27.9
Суралцах	35.8	41.1	36.9
Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах	2.4	0.0	1.9
Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах	8.4	10.6	8.9
Хамаатан садантайгаа ойртох	22.7	27.7	23.7
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах	14.6	3.5	12.4
Бусад	5.7	2.8	3.8
Шилжин ирсэн зорилгоо биелүүлж чадсан эсэх			
Тийм	66.4	87.9	70.8
Үгүй	33.6	12.1	29.2
Шилжин ирэлтээ бүртгүүлсэн эсэх (Улаанбаатарт)			
Тийм	47.0	52.5	48.1
Үгүй	53.0	47.5	51.9
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	547	141	688

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Шалтгааныг гэр, байшин хороололд амьдарч байгаагаар ангилж үзэхэд шилжин ирсэн шалтгаан хоорондоо бага зэрэг ялгаатай байлаа. Тухайлбал, гэр хороололд амьдардаг шилжин ирэгсдийн хувьд амьжиргаагаа дээшлүүлэх (42.8 хувь), ажил эрхлэх (42.2 хувь) гэсэн шалтгаан голлож байлаа. Байшин хороололд амьдардаг шилжин ирэгсдийн хувьд суралцах (41.1 хувь), ажил эрхлэх (38.3 хувь) шалтгаанууд зонхилж байна.

Шилжин ирсэн шалтгааныг хүйсээр үзвэл давхардсан тоогоор эрэгтэйчүүдэд ажил эрхлэх (45.7 хувь), амьжиргаагаа дээшлүүлэх (43.5 хувь) гэсэн шалтгаан, харин эмэгтэйчүүдэд суралцах (40.7 хувь), ажил эрхлэх (37.7 хувь) гэсэн шалтгаан зонхилж байлаа. Мөн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол шилжин ирсэн зорилгоо илүү биелүүлсэн байна.

Нийслэлд шилжин ирэгсдийн 71 хувь нь шилжин ирсэн зорилгоо биелүүлсэн гэж үнэлсэн байна. Байшин хороололд амьдарч буй шилжин ирэгсдийн зорилгодоо хүрсэн байдал (87.9 хувь) гэр хороололд амьдарч буй шилжигчдээс 20 орчим пунктээр илүү байна. Өөрөө хэлбэл, байшин хороололд амьдарч буй шилжигчид шилжилтдээ сэтгэл илүү хангалуун амьдарч байна.

Шилжигчдийн тал хүрэхгүй хувь (48.1 хувь) нь хот руу нүүж ирэхдээ орон нутгаасаа шилжүүлэг, зөвшөөрөл авчээ.

Хүснэгт 8.12 Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, хүйсээр

Сонгосон үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
Шилжин ирсэн зорилго*			
Бизнес эрхлэх	3.2	3.5	3.3
Ажил эрхлэх	45.7	37.7	41.4
Амьжиргаагаа дээшлүүлэх	43.5	34.0	38.4
Зах зээлд ойртох	31.2	25.1	27.9
Суралцах	32.5	40.7	36.9
Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах	1.6	2.2	1.9
Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах	9.1	8.6	8.9
Хамаатан садантайгаа ойртох	24.3	23.2	23.7
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах	12.6	12.1	12.4
Бусад	3.4	4.0	3.8
Шилжин ирсэн зорилгоо биелүүлж чадсан эсэх			
Тийм	68.8	72.5	70.8
Үгүй	31.2	27.5	29.2
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	547	141	688

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Сонирхолтой нь шилжих хөдөлгөөний шалтгаан жил ирэх тутам өөрчлөгдсөн нь харагдаж байна. Ялангуяа суралцах, нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах гэсэн шалтгаанаар шилжин ирэгчдийн хувийн жин буурч эдийн засгийн болох ажил эрхлэх, зах зээлд ойртох болон амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн шалтгаан зонхилох болсон байна. Энэ нь шилжих хөдөлгөөн цаашид ч өндөр хэвээр хадгалагдах болов уу гэсэн сэтгэгдлийг төрүүлж байгаа юм.

Хүснэгт 8.13 Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн хугацаагаар,

Сонгосон үзүүлэлтүүд	Хугацаа		
	1 хүртэл жил	1-2 жил	3-4 жил
Шилжин ирсэн зорилго*			
Бизнес эрхлэх	4.2	1.9	3.9
Ажил эрхлэх	47.9	43.4	35.6
Амьжиргаагаа дээшлүүлэх	46.4	31.1	38.4
Зах зээлд ойртох	35.9	25.0	24.6
Суралцах	31.3	38.2	39.8
Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах	0.5	1.9	2.8
Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах	3.1	9.9	12.0
Хамаатан садантайгаа ойртох	26.0	29.7	17.6
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах	14.6	15.6	8.5
Бусад	2.5	4.7	7.0
Бүгд	100.0	100.0	100.0
Тоо	547	141	688

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

8.6 Оршин сууж буй газрын бүртгэл


Шилжин ирэгсдэд тулгарч буй нэг гол бэрхшээл нь оршин суугаа газартаа бүртгүүлж чадахгүй байгаа явдал юм. Тухайн оршин суугаа газраа бүртгүүлж чадаагүйгээс болж нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүйд хүрч буйг бүлгийн ярилцлагын дүнгээс харагдаж байна.

“Эгч нь амьдралаа дээшлүүлэх, хэдэн хүүхдээ сайн сурч, боловсролтой болгохын тулд бор зүрхээрээ зүтгээд ирсэн. Түүнээс би энд түших тулах, ах дүү байхгүй, таних хүн байхгүй. Гэтэл шилжүүлэг байхгүй, хороондоо бүртгүүлээгүй гээд сургуульд хүүхэд авдаггүй”

(Ж, эмэгтэй, нас 43, ажилгүй, шилжин ирсэн бүртгэлгүй, СХД)

Шилжигчдийн 52 хувь буюу 357 хүн шилжин ирэлтээ бүртгүүлж, Улаанбаатар хотод амьдрах зөвшөөрлөө аваагүй байна. Бүртгүүлээгүй хүмүүсийн 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй, 51.3 хувь нь ганц бие хүмүүс байв. Эдгээр хүмүүсийн 63.9 хувь нь ажил эрхлээгүй байгаагаас гадна дийлэнх (81.2 хувь) нь гэр хороололд амьдарч байна.

Дүүргээр үзвэл Сонгинохайрхан дүүрэгт бүртгэлгүй шилжигчид хамгийн өндөр хувийг эзэлж байна (Зураг 8.4).



Хүснэгт 8.14-т шилжин ирэгсдийн бүртгүүлээгүй шалтгааныг хүйсээр харуулав.

Хүснэгт 8.14 Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, хүйсээр

Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй шалтгаан	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
Баримт бичиг байхгүй	13.0	13.8	13.4
Орон нутгийн шилжүүлэггүй	22.5	19.7	21.0
Санхүүгийн боломжгүй	23.7	23.9	23.8
Өөр газар руу шилжих хүсэлтэй	0.6	1.1	0.8
Бүртгүүлэх шаардлагагүй	7.7	10.1	9.0
Бүртгүүлж амжаагүй	31.4	30.3	30.8
Бусад	1.2	1.1	1.1
Бүгд	100.0	100.0	100.0
Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын тоо	169	188	357

Улаанбаатар хотод шилжин ирээд бүртгүүлээгүй гол шалтгаан нь бүртгүүлж амжаагүй (30.8 хувь), мөнгөгүй (23.8 хувь), орон нутгийн шилжүүлэггүй (21.0 хувь) гэсэн шалтгаанууд болж байлаа. Бүртгүүлэх шаардлагагүй гэж хариулсан хариулагчид багагүй (9 хувь) хувь эзэлж байгаа ба ялангуяа, байшин хороололд шилжин ирсэн эмэгтэйчүүд ийм хариултыг их өгчээ.

Бүртгүүлээгүй шалтгааныг байршлаар үзэхэд гэр хороололд бүртгүүлж амжаагүй (32.4 хувь), мөнгөгүй (26.2 хувь) гэсэн шалтгаан, харин байшин хороололд бүртгүүлж амжаагүй (23.9 хувь), орон нутгийн шилжүүлэггүй (28.4 хувь) гэсэн шалтгаан өндөр хувьтай байна (Хүснэгт 8.15).

Хүснэгт 8.15 Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, байршлаар

Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй шалтгаан	Байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Баримт бичиг байхгүй	13.8	11.9	13.4
Орон нутгийн шилжүүлэггүй	19.3	28.4	21.0
Санхүүгийн боломжгүй	26.2	13.4	23.8
Өөр газар руу шилжих хүсэлтэй	0.7	1.5	0.8
Бүртгүүлэх шаардлагагүй	6.2	20.9	9.0
Бүртгүүлж амжаагүй	32.4	23.9	30.8
Бусад	1.4	0.0	1.1
Бүгд	100.0	100.0	100.0
Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын тоо	290	67	357

Бүртгэл ба шилжих хөдөлгөөний зохицуулалт

Бүртгэл нь шилжих хөдөлгөөнийг зохицуулах тохиромжтой арга мөн үү? Дээр бид шилжигчдийн талаас илүү хувь нь оршин суугаа газартаа бүртгүүлээгүй байгаа гэж тэмдэглэсэн билээ. Тиймээс бүртгэл нь шилжих хөдөлгөөнийг зохицуулах тохиромжтой арга биш гэдэг нь харагдаж байна. Түүнчлэн шилжин ирэгчдийн шалтгаанаар авч үзэхэд ч бүртгэл нь хүмүүсийг ирээдүйд шилжихээс урьдчилан сэргийлж чадахгүй гэж хэлж болохоор байгаа юм. Гэвч Хүснэгт 8.9-с харахад бүртгэлийн асуудал нь шилжигчдийн хувьд нийгмийн үйлчилгээ тухайлбал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжийг хязгаарлаж байна. Эрүүл мэндийн даатгалгүй шилжигчдийн (гуравны нэг нь) эрүүл мэндээ даатгуулж чадахгүй (даатгалгүй шилжигчдийн дөрөвний нэг) байгаа гол шалтгаан нь бүртгэл гэж хариулсан байв. Тиймээс бүртгэл нь хүмүүст нийгмийн халамж, үйлчилгээг ойртуулах гэсэн зорилгыг биелүүлж чадахгүй байгаагаар зогсохгүй сөрөг үр дагварыг бий болгож байна. Бүртгэлийн үйл явцыг төлбөргүй болгож харьцангуй хөнгөвчилсөн нь оновчтой шийдвэр болж чадсаныг судалгааны дүн батлаж байна.

8.7 Ирээдүйн шилжилт

Ирээдүйд шилжилтийн талаар судалгаанд хамрагдагсдаас асуусан бөгөөд дүнг хүн амын амьжиргааны түвшин, байршлаар Хүснэгт 8.16-д харуулав.

Судалгаагаар шилжигчдийн 15 хувь нь цаашид дахин шилжих хөдөлгөөнд орно гэжээ. Харин 1.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Шилжих хөдөлгөөн

Амьжиргааны түвшин дээшлэх тусам өөр газар руу шилжинэ гэсэн хариултын хувь нэмэгдэж байна. Магадгүй тэдний ихэнх нь гадаад шилжих хөдөлгөөнд оролцох сонирхолтой байж болох юм. Учир нь 2000 онд явуулсан Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар ирээдүйд шилжих хөдөлгөөнд оролцоно гэсэн Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын тавны нэг, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын бараг тал орчим хувь нь гадаад явна гэж хариулж байжээ. Түүнчлэн шилжих хөдөлгөөний том урсгал буцах шилжилтийг үргэлж дагуулж байдаг. Тиймээс шилжигчдийн тодорхой хувь энэхүү буцах хөдөлгөөнд мөн оролцох магадлалтай юм.

Хүснэгт 8.16 Судалгаанд хамрагдсан 15-64 насны хүн амын хувийн жин, ирээдүйн шилжилт, амьжиргааны түвшин, байршлаар

Ирээдүйд шилжих хүсэлтэй эсэх	Амьжиргааны түвшин									
	Нэн ядуу		Ядуу		Ядуу бус (бага орлоготой)		Ядуу бус (дунд орлоготой)		Ядуу бус (чинээлэг)	
	Гэр	Байшин	Гэр	Байшин	Гэр	Байшин	Гэр	Байшин	Гэр	Байшин
Шилжинэ	4.5	3.9	9.5	11.2	12.0	10.6	10.8	15.6	15.8	20.7
Шилжихгүй	94.6	96.1	89.8	88.3	87.9	89.4	89.0	83.7	83.2	78.7
Мэдэхгүй	0.8	0.0	0.7	0.5	0.1	0.0	0.2	0.7	1.1	0.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	354	76	851	206	903	480	462	557	190	633

Ирээдүйд шилжих хөдөлгөөнд орно гэж хариулсан гэр хорооллын нэн ядуучуудын эзлэх хувийн жин ядуу бус (өндөр) хүмүүсийнхээс 4 дахин бага, ядуу бус (дунд) хүмүүсийнхээс 2 дахин бага байна. Харин байшин хорооллын ирээдүйд шилжинэ гэсэн нэн ядуу иргэдийн эзлэх хувь ядуу бус (өндөр) иргэдийнхээс 5 дахин доогуур байна. Эндээс харахад шилжих хөдөлгөөнд нэн ядуу иргэд бараг оролцдоггүй гэсэн онолын дүгнэлт манай орны нөхцөлд ч батлагдаж байна.

8.8 Шилжих хөдөлгөөн ба ядуурал

Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн хотын ядууралд хэрхэн нөлөөлж буй байдлыг судлах явдал манай судалгааны нэг томоохон зорилт байв. Иймд энэхүү хэсэгт шилжих хөдөлгөөн ба ядуурлын хоорондын хамаарлын талаар нэлээд дэлгэрэнгүй судлан үзэх болно. Тухайлбал, шилжигчид илүү идэвхтэй, амжилт руу тэмүүлсэн шинж чанартай байж болох талтай. Улмаар тэд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож, албан бус секторыг ч өргөжүүлэхэд нөлөө үзүүлж болох юм. Энэ нь эргээд шилжигч бус хүн амын хувьд орлого олох, ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд хүргэдэг туршлага улс орнуудад ажиглагдсан байдаг. Үүний зэрэгцээ шилжигчид нь нийгмийн үйлчилгээний салбарт илүү дарамтыг үзүүлж, ядуу шилжигч бус иргэдийг улам ядууруулахад хүргэж ч болно. Ийнхүү олон хувилбарыг таамаглан олж болох юм. Эдгээр хувилбарын чухам аль нь илрэх магадлал өндөр байхыг үнэндээ таахын аргагүй. Гэхдээ энэхүү судалгааны хүрээнд шилжих хөдөлгөөн болон ядуурлын хооронд ямар нэгэн хамаарал байгаа эсэхийг хэмжин тодорхойлж болох юм.

Өмнө хэлсэнчлэн шилжигчид (37 хувь) шилжигч бус хүмүүсээс (31 хувь) илүү ядуу байна. Гэхдээ энэ ялгаа нь шилжих хөдөлгөөн ядууралд нөлөө үзүүлж байна гэдгийг бататгах болов уу? Энэ асуултанд хариулах зорилгоор хоёр ложистик регрессийн шинжилгээг хийсэн юм. Загвар А-д шилжих хөдөлгөөнийг цорын ганц үл хамаарах хувьсагч болгон авсан. Загвар Б-д ядуу байх эсэхэд нөлөөлж болох бусад үл хамаарах

Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2003, ХАССТ, НҮБХХ

хүчин зүйлсийг оруулан тооцсон юм. Ийнхүү магадлалын харьцааг доорх хоёр хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 8.17 Ядуу өрхийн магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Загвар А		Загвар Б		Өрхийн тоо
	Магадлалт харьцаа	Стандарт алдаа	Магадлалт харьцаа	Стандарт алдаа	
Шилжих хөдөлгөөнд оролцсон байдал	-	-	-	-	1324
<i>Шилжигч бус</i>					
Шилжигч	1.434*	0.258	1.382	0.272	176
Дүүрэг					
Баянзүрх			-	-	200
Налайх			0.960	0.306	100
Сүхбаатар			0.590*	0.134	350
Сонгинохайрхан			0.772	0.159	500
Хан-Уул			0.521*	0.172	100
Чингэлтэй			0.752	0.174	250
Өрхийн тэргүүлэгчийн хүйс					
Эрэгтэй			-	-	895
Эмэгтэй			1.248	0.271	155
			0.421*	0.145	101
Өрхийн тэргүүлэгчийн нас			1.003	0.992	0.499
Өрхийн тэргүүлэгчийн гэрлэлтийн байдал					
Баталгаатай гэр бүл			-	-	895
Баталгаагүй гэр бүл			1.248	0.271	155
Огт гэрлээгүй			0.421*	0.145	101
Тусгаарласан			0.992	0.499	33
Салсан			1.236	0.431	64
Бэлэвсэн			1.347	0.361	252
Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин					
Бүрэн дундаас дээш			-	-	675
Бүрэн дунд			1.869***	0.323	403
Бүрэн бус дунд			3.797***	0.672	272
Боловсролгүй/бага боловсролтой			3.666***	0.831	150
Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс					
Халх			-	-	1313
Казак			0.944	0.412	35
Дөрвөд			0.551	0.257	43
Вуриад			1.219	0.564	30
Баяд			1.323	0.206	37
Бусад			1.168	0.424	42
Тоо					1500
-2 log likelihood (утга) өөрчлөлт		-797,201*		-736,874***	

Магадлалын харьцаа гэж юу вэ? Жишээ нь, шилжигч өрхийн хувьд ядуу байх магадлал 1.3 дахин өндөр байна (Загвар Б). Налайх дүүрэгт дурын өрхийн үүдийг тогшиход тэр өрх ядуу байх магадлал Баянзүрх дүүрэгтэй харьцуулахад бага (Баянзүрх дүргийн ядуу өрх бүрт Налайх дүүргийн 0.96 ядуу өрх ногдоно) байх юм.

Шилжих хөдөлгөөн

Хүснэгт 8.17-д зураас тавьсан нүд харьцуулах бүлгийг илэрхийлнэ. Энэ харьцаа нэгээс бага байвал урвуу харин нэгээс их байвал эерэг хамааралтай байгааг илтгэнэ. Харин зураасаар тэмдэглэсэн нүд байхгүй хувьсагчийн хувь үр дүнг дараах байдлаар тайлбарлана. Тухайлбал, өрхийн тэргүүлэгчийн насны магадлалын харьцаа 0.992 байна. Өрхийн тэргүүний нас нэгээр нэмэгдэх тусам нийгмийн эмзэг бүлэгт орох магадлал 0.992-аар буурна.

Одоор (*) статистик ач холбогдолтой хамаарлыг тэмдгэлсэн юм. Од байхгүй байгаа нь тухайн хүчин зүйл ядууралтай хамааралтай байх нь Улаанбаатарын хүн амын хувьд магадлал байгааг илэрхийлнэ.

Загвар А нь ядуурлын түвшин өндөр байгаа шилжигчдэд үндэслэн шилжих хөдөлгөөн ба ядуурлын хоорондын хамаарлыг илэрхийлэв. Гэвч боловсролын үзүүлэлтийг хяналтын хувьсагч болгоход өөр үр дүн гарч байна. Өөрөөр хэлбэл, шилжин ирэгчид нь ядуу биш харин тэдний боловсролын түвшин нь муу байна гэсэн үг юм.

Загвар Б-д шинжилсэн хүчин зүйлсээс өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, ядуурал хоёрын хоорондын хамаарал статистик ач холбогдолтой байгааг харж болно. Тухайлбал, бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн ядуу байх магадлал техник, мэргэжлийн болон дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдтэй харьцуулахад 1.869 дахин өндөр байна. Түүнчлэн, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн өрхүүдийн ядуу байх магадлал бага байна.

Гэвч өрхийн шилжилтийн байдал ядууралд статистик ач холбогдолын түвшинд нөлөө үзүүлэхгүй байна. Тэгвэл яагаад шилжигчид илүү ядуу байна вэ? Яагаад гэвэл тэд шилжигч учраас бус харин тэдний боловсролын түвшин доогуур байгаа учраас юм (Хүснэгт 8.9). Өөрөөр хэлбэл энэ нь шилжигчдийг гадуурхах асуудалтай холбоогүй.

Шилжигчид болон шилжигч бус хүмүүс аль алинд нь ижил боломж байдаг боловч шилжин ирэгчдийн чадавхи сул байдаг юм байна.

Шилжих хөдөлгөөн ба нийгмийн эмзэг бүлэг

Уламжлалт ядуурлын үзүүлэлтүүд бус харин ядуурлын талаарх бүлгийн сүүлд тодорхойлсон нийгмийн эмзэг бүлгийнхний хувьд дүр зураг арай өөр байгаа нь сонирхол татаж байна. Эдгээр хүмүүсийн хувьд дараах асуудлуудын дор хаяж хоёр нь давхцаж илэрч байгаа юм. Үүнд хэрэглээний ядуурал, хүртээмжийн ядуурал болон нийгмийн оролцооны ядуурлын асуудлууд багтана. Түүнчлэн хэрэглээний хувьд нэн ядуу хүмүүсийн мөн энэхүү бүлэгт хамааруулж тооцсон юм.

Хэдийгээр өрхийн шилжилтийн статус өрхийн ядуу байхыг тодорхойлох хүчин зүйл биш байсан хэдий ч шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх нь нийгмийн эмзэг бүлэгт хамаарах эсэхэд чухал нөлөө үзүүлж байна гэсэн дүн гарчээ. Өөрөөр хэлбэл, шилжигчдийн хувьд орлого бага байх (зардалд үндэслэн тооцсноор) асуудлаасаа илүү хүртээмжийн болон нийгмийн оролцооны ядуурлын асуудлууд (бүртгэлгүйн улмаас эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх, илүү ядуу нөхцөлд байх гэх мэт) илүү хурц илэрч байдаг гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 8.18 Нийгмийн эмзэг өрхийн магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Загвар А		Загвар Б		Өрхийн тоо
	Магадлалт харьцаа	Стандарт алдаа	Магадлалт харьцаа	Стандарт алдаа	
<i>Шилжих хөдөлгөөнд оролцсон байдал</i>	-	-	-	-	1324
<i>Шилжигч бус</i>					
Шилжигч	2.371***	0.173	2.039***	0.194	176
<i>Дүүрэг</i>					
Баянзүрх			-	-	200
Налайх			0.632	0.336	100
Сүхбаатар			0.358***	0.241	350
Сонгинохайрхан			0.564***	0.210	500
Хан-Уул			0.259***	0.376	100
Чингэлтэй			0.524**	0.241	250
<i>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</i>					
Эрэгтэй			-	-	1144
Эмэгтэй			0.889	0.225	356
<i>Өрхийн тэргүүлэгчийн нас</i>			0.986*	0.006	1500
<i>Өрхийн тэргүүлэгчийн гэрлэлтийн байдал</i>					
Баталгаатай гэр бүл			-	-	895
Баталгаагүй гэр бүл			0.573	0.321	155
Огт гэрлээгүй			1.032	0.232	101
Тусгаарласан			1.626	0.530	33
Салсан			2.201*	0.354	64
Бэлэвсэн			1.213	0.293	252
<i>Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин</i>					
Бүрэн дундаас дээш			-	-	675
Бүрэн дунд			2.797***	0.187	150
Бүрэн бус дунд			5.295***	0.193	272
Боловсролгүй/бага боловсролтой			5.873***	0.247	403
<i>Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс</i>					
Халх			-	-	1313
Казак			2.918*	0.432	35
Дөрвөд			1.016	0.430	43
Вуриад			0.672	0.594	30
Баяд			1.298	0.455	37
Бусад			1.294	0.379	42
Тоо					1500
-2 log likelihood (утга) өөрчлөлт	1502.584*		1340.297*		
	**		**		

Дүгнэлт

Хотод шилжин ирэгчдийн дийлэнх нь гэр хороололд амьдардаг бөгөөд тэдний ихэнх нь бүрэн дунд ба түүнээс доогуур боловсролын түвшинтэй байна.

Шилжигчдийн ихээхэн хувь нь Төв болон Баруун бүсээс ажил эрхлэхээр, суралцахаар, зах зээлд ойртохоор гэх мэт эдийн засгийн шалтгаанаар шилжин иржээ.

Шилжих хөдөлгөөний шалтгаан өөрчлөгдөж ирсэн байна. Ялангуяа суралцах, нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах гэсэн шалтгаанаар шилжин ирэгчдийн хувийн жин буурч, эдийн засгийн болох ажил эрхлэх, зах зээлд ойртох болон амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн шалтгаан зонхилох болсон байна. Энэ нь шилжих хөдөлгөөн цаашид ч өндөр хэвээр хадгалагдах болов уу гэсэн сэтгэгдлийг төрүүлж байгаа юм.

Шилжигчдийн дийлэнх (71 хувь) нь өөрсдийн зорилгоо биелүүлж чадсан байна.

Шилжигчдийн талаас илүү хувь (52 хувь) нь нийслэлд шилжих хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй байв. Бүртгэл нь хүмүүсийг ирээдүйд шилжихээс урьдчилан сэргийлж чадахгүй гэж хэлж болохоор байгаа юм. Гэвч бүртгэлийн асуудал нь шилжигчдийн хувьд нийгмийн үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс бүртгэл нь хүмүүст нийгмийн халамж, үйлчилгээг ойртуулах гэсэн зорилгыг биелүүлж чадахгүй байна. Бүртгэлийн үйл явцыг төлбөргүй болгож харьцангуй хөнгөвчилсөн нь оновчтой шийдвэр болж чадсаныг судалгааны дүн баталж байна.

Шилжигчид илүү ядуу байгаа бөгөөд хотын ядуурал нэмэгдэхэд тэд нэрмээс байна. Гэхдээ шилжилтийн статус ядуурлыг тодорхойлохгүй гэдэг нь шинжилгээний дүнгээс харагдаж байгаа юм. Тэд шилжигч учраас бус харин боловсролын түвшин доогуур учраас ядуу байна. Шилжигчид болон шилжигч бус хүмүүсийн аль алинд нь ижил боломж байдаг боловч шилжин ирэгчдийн чадавхи илүү сул байгаа юм.

Шилжих хөдөлгөөнд оролцох гол шалтгаануудад амьжиргаагаа дээшлүүлэх, зах зээлд ойртох, ажил эрхлэх зэргийг нэрлэсэн нь шилжих хөдөлгөөнийг сааруулахад уугуул нутгуудийн нөхцлийг сайжруулах оновчтой арга болох юм. Хэдийгээр суралцах шалтгаанаар ирэгсдийн хувь буурсан хандлага ажиглагдсан боловч энэ нь шилжих гол шалтгаануудын нэг болж байгаа учраас боловсролын асуудалд анхаарах нь чухал байна.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөний судалгаа нь хотын байшин болон гэр хороололд оршин суугчдын амьдрал, ахуйн ялгаатай байдлыг нэлээд тод илрүүлэн харууллаа. Иймд нийслэл хотын хүн амын ядуурлыг бууруулах, улмаар гэр, байшин хорооллын ялгааг багасгахад чиглэсэн дараах бодлогын зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- Анхаарал хандуулах зорилтот бүлэг нь өрхийн олон гишүүдтэй гэр хорооллын өрхүүд байна. Мөн өрхийн тэргүүлэгч нь бүрэн бус дунд боловсролтой өрхүүдэд анхаарах нь зүйтэй.
- Орон сууцны болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах нь нэн тэргүүний үйл ажиллагаа болж байна. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа ч бид эдгээр үйлчилгээний чанарын ялгааг тоон талаас нь тогтоож чадахгүй юм. Гэхдээ энд үйлчилгээний чанарын асуудал нэн чухал байгааг чанарын судалгааны үр дүн харуулж байна.
- Засгийн газраас гэр хороололд амьдарч буй хүн амд зориулан “нэг өрөө сууц”-ны барилга барих ажлыг зохион байгуулж болох юм.
- Хүн амын орлогын түвшинг дээшлүүлэх үндсэн хөшүүрэг бол ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал юм. Үүнтэй холбоотойгоор нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг гэр хороололд оршин суугчдад түлхүү хандуулах, ялангуяа, албан бус секторыг зүй зохистой зохион байгуулах нь зүйтэй.
- Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн хөдөлгөөн, ухуулга сурталчилгааны ажлыг өрнүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,
 - Иргэний бүртгэлийн ажлыг сайжруулах, ач холбогдолыг сурталчлах
 - Аж амьдралаа сайжруулахад иргэдийн өөрсдийн оролцоог идэвхжүүлэх, амьдрах ухаанд сургах үйл ажиллагаанууд;
- Хүний халдашгүй дархан эрхийг хүндэтгэх, нийслэлд шилжин ирэгчдийн амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд хөдөө, орон нутгийн амьдралын нөхцлийг сайжруулах, амьдрах сонирхлыг татах хөдөөгийн хөгжлийн нарийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Цаашид хийх шаардлагатай судалгааны ажлууд

- Гэрт амьдрагсдын ахуйн нөхцлийг сайжруулах нөөц, боломжийг илрүүлэх судалгаа;
- Хүн амын амьжиргаа, аж байдлыг үндэстэн, ястнаар гүнзгийрүүлэн судлах судалгаа зэрэг болно.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Монгол улсын Засгийн газар, НҮБХХ, 2003. *Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003*. Улаанбаатар, Монгол

НХХЯ, ХАССТ, НҮБХАС, 2001. *Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000*. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын сургалт, судалгааны төв, НҮБ-ын хүн амын сан, Улаанбаатар, Монгол

ҮСГ, 1999. *Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998*. Үндэсний статистикийн газар, НҮБХХ, Улаанбаатар, Монгол

ҮСГ, 2001. *Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа, 2000*. Үндэсний статистикийн газар, Дэлхийн банк, Улаанбаатар, Монгол

ҮСГ, 2001. *Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн*. Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, Монгол

ЛСА, 2002. *Улаанбаатар хотын гэр хорооллын орчин ахуй*. Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Улаанбаатар Монгол